

ИЙМОНН БАТЛЕР

Капитализм ►

- Ы Н Ү Н Д Э С

КАПИТАЛИЗМЫН ҮНДЭС

Иймонн Батлер

2018 он

ННА 66
ДАА 320
Б-336

Introduction to Capitalism

by Eamonn Butler

Copyright © 2018 Institute of Economics Affairs

First published by the Institute of Economics Affairs, London, in 2018.

Капитализмын үндэс

Иймонн Батлер

Монгол орчуулгын анхны хэвлэл: 2026 он

Англи хэлнээс орчуулсан: Намхайнямын Жаргал

Монгол орчуулгын эрхийг © Намхайнямын Жаргал эзэмшдэг.

Бүх эрхийг хуулиар хамгаалсан болно.

Энэхүү бүтээлийг Улстөрийн Нам, ТББ-аас бусад хувь хүн файл хэлбэрээр татаж авах, олшруулж, бусдад дамжуулах, хэсэгчилж эсвэл бүтнээрээ нь хэвлэх нь цөм чөлөөтэй бөгөөд гагцхүү орчуулагчийн нэрийг түүндээ дурдах ёстой. Улстөрийн Нам, ТББ хэрэглэх бол орчуулагчаас зөвшөөрөл авна.

“Эрх Чөлөөт Хүмүүст Зориулсан Номын-Сан” нэртэй вэбхуудасанд зориулж файлаар бас нийтлэв: www.libraryforfreepeople.mn

Эдийн Засгийн Хэрэг Явдлын Хүрээлэнгийн зөвшөөрлөөр орчуулан гаргав.

ISBN: 978-9919-9058-8-0

ГАРЧИГ

Зохиогч	viii
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ:	1
Оршил	1
Энэ номд юуны тухай өгүүлэв	1
Энэ ном хэр өргөн хүрээтэй вэ	1
Энэ номыг хэнд зориулав	2
Капитализм ба зохиогчид	2
Номын бүтэц	3
ХОЁРДУГААР БҮЛЭГ:	5
Капитализм гэж юу вэ?	5
Бодит байдал ба буруу ойлголтууд	5
Капитализмыг гутаасан нь	6
Тодорхойлолтоос нь гардаг бэрхшээл	7
Капитализмын илүү өргөн холбоо хамаарал	8
Капитализмд амин чухал байдаггүй зүйл	10
Капитализмд л зөвхөн байдаггүй зүйлс	11
Капитализмыг тодорхойлж хэлбэл	13
ГУРАВДУГААР БҮЛЭГ:	16
Хөрөнгө буюу капитал гэж юу вэ	16
Капитал буюу хөрөнгөний тухай концепц	16
Хөрөнгийн зориулалт	16
Хөрөнгө хэрхэн бүтээмжийг эрс нэмэгдүүлдэг вэ	17
Хөрөнгийн тухай уламжлалт ойлголтууд	18

Хөрөнгийн хамгийн чухал хэлбэр	20
Тогтолцооны дэд бүтэц	22
Хуульзүй болон соёлын хөрөнгө	24
Дүгнэлт	26
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ:	28
Хөрөнгийг Хэрхэн Бүтээдэг вэ	28
Хөрөнгө хэрхэн олж авдаг тухай алдаатай үзэл санаа	28
Хөрөнгөө хадгалах амаргүй	30
Хөрөнгө хүмүүний үнэлэлт дүгнэлтээс хамаардаг	34
Хөрөнгийн жинхэнэ үүсэл гарал	35
Хөрөнгийг албадлагатай харьцуулбал	36
ТАВДУГААР БҮЛЭГ:	38
Хөрөнгийн Бүтэц Яагаад Маш Чухал Вэ	38
Бүтээмжтэй бараа бүтээгдэхүүний сүлжээ	39
Хөрөнгийн бүтцийн хэврэг байдал	40
Муу бодлого хөрөнгө үгүй хийдэг	42
Дүгнэлт	44
ЗУРГААДУГААР БҮЛЭГ:	47
Капитализмыг Юу Ажиллуулдаг Вэ	47
Өөрийн-тусыг бодох, өмч, ашиг, санаачилга	47
Өрсөлдөөний явц	52
Нарийн төрөлжих явдал ба зах зээл	54
Капитализм ба төр	56
ДОЛООДУГААР БҮЛЭГ:	58
Капитализмын Ёс Суртахууны Хэмжээс	58

Социалист болон капиталист ёс суртахууны алсын хараа	58
Капитализм үнэ цэнэ бүтээж, хүмүүсийг	59
эд баялагтай болгодог	59
Өмчийн эрхээс хүртдэг хүмүүний ашиг тус	61
Тэгш байдал ба хөгжил цэцэглэлт	63
Тэгш байдлыг тодорхойлоход гардаг бэрхшээл	64
Капитализм хүмүүний харилцааг сайжруулдаг	65
Адилхан зүйлийг адилхантай нь харьцуулах	66
НАЙМДУГААР БҮЛЭГ:	69
Капитализмын товч түүхэн замнал	69
Капитализмыг онолд нийцүүлж тааруулахаар	
мушгин гуйвуулсан нь	69
Төрөөс-чиглүүлдэг арилжаа худалдаа	70
Аж Үйлдвэрийн Хувьсгал	72
Төрөөс-удирддаг эдийн засаг	74
Корпоратизмын гамшиг	75
Ирээдүйдээ зориулж капитализмыг цогцлоохуй	78
ЕСДҮГЭЭР БҮЛЭГ:	80
Капитализмын Тухай Өгүүлсэн Аугаа Сэтгэгчид	80
Саламанкийн Сургууль ('Схоластууд буюу	
Сургуульгтнууд')	80
Адам Смит (1723-90 он)	81
Дэвид Рикардо (1772-1823 он)	83
Лүдвиг фон Мизэс (1881-1973 он)	84
Ф. А. Хаек (1899-1992 он)	85
Милтон Фрийдмэн (1912-2006 он)	86

Жэймс М. Бюканэн (1919-2013 он),	
Гордон Таллокк (1922-2014 он)	87
Гари Беккер (1930-2014 он)	88
Израэл Кирцнер (1930 онд төрсөн)	90
Деирдре МакКлоский (1942 онд төрсөн)	91
АРАВДУГААР БҮЛЭГ:	93
Шүүмжлэгчид ба Шүүмжлэлүүд	93
Ёс суртахууны шүүмжлэл	93
Капитализмын бүтцийн тухай шүүмжлэл	98
Корпорацын хүч чадал	100
Даян дэлхийн харилцан хамаарал	102
Крони бизнесээс татгалзах	103
АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ:	105
Капитализмын Ирээдүй	105
Хүч тэнхээ	105
Сул талууд	107
Боломж бололцоо	110
Аюул занал	111
Капитализмын бат бөх байдал	114
АРВАНХОЁРДУГААР БҮЛЭГ:	116
Нэмж Унших Зүйлс	116
Дайсагнасан таниулга тайлбар	116
Элгэмсэг таниулга тайлбар	117
Капитализм ба ядуурлын тухай	120
Философи ба ёс суртахууны тухай	121

ЗОХИОГЧ

Иймонн Батлер бол бодлогын тэргүүлэх тинк танк болох Адам Смит Хүрээлэнгийн захирал билээ. Тэрбээр эдийн засаг болон психологийн эрдмийн цолтой, философийн PhD, Нийгмийн Ухааны хүндэт Доктор юм. 1970-аад онд тэрбээр Вашингтонд АНУ-ын Төлөөлөгчдийн Танхимд ажиллаж байхдаа, НХУ^[1] руу Адам Смитийн Хүрээлэнг байгуулахад туслахаар буцахаасаа өмнө Мичиганы Хиллсдэйл Коллежид философийн ухааны хичээл зааж байв. Валлий Форжийн Эрх Чөлөөний Сангийн Эрх Чөлөөний шагналтан, НХУ-ын Үндэсний Чөлөөт Аж Ахуй Эрхлэлтийн Шагналтан Иймонн одоо Мон Перелин Нийгэмлэгийн Нарийн Бичгийн Даргын алба хашдаг.

Тэрбээр Милтон Фрийдмэн, Ф. А. Хаек, Лүдвиг фон Мизэс зэрэг тэргүүлэгч эдийн засагчдын тухай ном, *Эдийн Засгийн Австри Сургууль: товч тайлбар, Үндэстнүүдийн Цугларсан Баялагийг зохиосон*. ЭЗХЯХ-д зориулж тэрбээр Адам Смит, Лүдвиг фон Мизэс, олон нийтийн сонголтын тухай онолын талаархи цагаан толгойг зохиожээ; түүний *Чөлөөт Нийгмийн Үндэс* ном 2014 онд Фишерийн Шагнал^[2] хүртсэн. Тэрбээр цалингийн түүх, үнийн хяналтын тухайн, мөн IQ-гийн тухай цуврал номын хамтран зохиогч юм. Түүний сүүлийн үеийн алдартай бүтээл *Зах зээлийн тухай хамгийн сайн ном, Британийн Илжирсэн Төр, Өөр Нэг Хувилбар Тунхаг*^[3] нь хүмүүсийн сонирхлыг их татсан бөгөөд тэрбээр номын хэвлэл, өргөн нэвтрүүлэгт байнга оролцдог.

1 *UK-Нэгдсэн Хаант Улс*

2 *Fisher Prize*

3 *The Best Book on the Market, The Rotten State of Britain, The Alternative Manifesto*

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: Оршил

Энэ номд юуны тухай өгүүлэв

Капитализм гэж юу болох, энэ нь хэрхэн ажилладаг, мөн түүний хүч чадал болон сул талыг энгийн, бас тэгээд шударгаар тайлбарласан ном олоход хэцүү.

Капитализм гэсэн энэхүү үгийг доромж хэллэг болгож зохион хэрэглэсэн. Өнөөдөр ч гэсэн ийм сэдэвтэй ихэнхи номд капитализмд дайсагнасан эсвэл түүний талаархи гажуудуулсан, будлиантуулсан дүр зураг үзүүлдэг хэвээр л байна. Бүр капитализмыг өөрийг нь хамгаалж дэмжигчид түүнийг юу болохыг ойлгож чадалгүй, бодит байдлыг нь тайлбарлахын оронд гажуудлыг нь зөвтгөх гэж тэмцэлддэг нь ердийн зүйл болжээ.

Тиймээс л капитализмын тухай сэдвийг ойлгомжтой, шударгаар ерөнхийлж харуулсан богино, гарын авлага хэрэгтэй байна. Энэ ном бол ийм гарын авлага юм.

Энэ ном хэр өргөн хүрээтэй вэ

Капитализм чухамдаа юу болох талаар илүү сайн тодорхойлолтыг өгөх, үүнээс дутуугүй энэ нь юу биш болохыг хэлэхийн тулд түүн рүү шүүмжлэгчид нь овоолсон хог шороог цэвэрлэн капитализмын амин сүнснийг ухаж ойлгох гэж түүний талаархи урьдаас тогтчихсон төсөөлөл, гажуудлыг энэ ном цуу татах болно.

Энэ бүтээлд *капитал* буюу *хөрөнгө* гэж юу болох, энэ нь ямар хэлбэртэй болдог, энэ нь хэрхэн яагаад үүсдэг, мөн түүний зориулалт, үр нөлөө хийгээд түүнийг хэрхэн ашиглах тухай таниулж

мэдүүлэх болно. Энэ номд капитализмын эдийн засаг, нийгэм, ёс суртахууны мөн чанар, мөн түүний суурилдаг институтүүдийг судалж шинжилнэ.

Энэхүү номд капитализмын түүхийг мөшгөж харуулах бөгөөд түүнийг дэмжигчдийн зарим нэг гол үзэл санааг тайлбарлана. Мөн түүнийг эсэргүүцэгчдийн шүүмжлэлийг нягталж үзнэ. Бас капитализмын хүч чадал, сул тал, ирээдүйнх нь талаар илэн далангүй үнэлж дүгнэнэ.

Энэ номыг хэнд зориулав

Энэ номыг мэргэжлийн үг хэл, техникийн хэллэг, эрдэм шинжилгээний эшлэл, үг хэрэглэлгүй энгийн, ойлгомжтой хэллэгээр бичив. Үүний зорилго бол хүн бүрд жинхэнээсээ капитализм гэж юу болохыг ухуулж ойлгуулах, мөн капитализмыг ойлгодог гэж боддог хүмүүст түүнийг бүр сайн ойлгоход нь туслах явдал юм.

Энэ бүтээл дунд сургуулийн сурагч, коллежийн оюутнуудад энэ талаар сайн ойлгоход нь мэдээж туслах учиртай ч гэсэн нэгэнт ихэнхи коллежийн багш нар капитализмд дайсагнаж ханддаг тул тэр оюутнуудад багш нараа түнших зарим нэг хурц ширүүн асуулт санал болгоно.

Гээд мөн эдийн засаг, улстөрийн үзэл санаа сонирхдог, үзэл санаа болон гаргалгаа нотолгоон дунд замчлах энгийн чиг баримжаа хайж яваа жирийн хүмүүс, үүн дотроо ажил хэрэгч хүмүүс, улстөрчид гээд хэн ч унших боломжтой.

Капитализм ба зохиогчид

Капитализмын талаар бичдэг хэдхэн зохиогч л өөрсдийнхөө урьдаас тогтчихсон таамаглалаа илэрхийлж мэдэгддэг эсвэл бүр тэдэнд ийм зүйл бий гэж бодоцгоодог. Тиймээс л тэд уншигчдаа өөрсдийнхөө алдаатай ойлголтдоо автуулж, тэдний л үзэл бодол зөв зүйтэй зүйл гэж уншигчдаа бодоход хүргэдэг.

Би капитализмын идеал (төгс хэлбэр)-ийг дэмждэг гэдгээ дуртайяа зөвшөөрч байна — гэвч бодит байдал дээр үргэлж ийм бай-

даггүй. Би капитализм бол үндсэндээ ёс суртахуунгүй, нийгмийн эсрэг зүйл юм гэсэн үзэл санааг үгүйсгэдэг. Харин би капитализм бол улстөрчид хөндлөнгөөс оролцон маш ихээр гажуудуулсан, дараагаар нь үүнээс нь гарсан үр дагаварт нь шударга бусаар буруутгадаг тийм зүйл юм гэдэгт итгэдэг. Гэвч бүр иймэрхүү гажуудсан төлөвтэй байхдаа ч гэсэн капитализм манай гараг даяар хөгжил цэцэглэлт одоо ч түгээсээр байна.

Тиймээс би хэдий капитализмын үзэл санаанд нааштай хандсаар байх ч гэсэн энэ ойлголт болон бодит байдлын талаархи шүүмжлэлийг анхаарч үздэг. Эдгээр шүүмжлэлд энд хариулах үеэрээ би маргаан мэтгэлцээнийг дахин тэнцвэржүүлж, уншигчдадаа жинхэнээсээ капитализм гэж юу болох тухай шударга тайлбар өгөхөөс илүү зүйл хиймээргүй байна.

Номын бүтэц

Энэ ном капитализм гэж юу болох, юу биш болохыг ялгаж таних гэсэн оролдлогоор эхэлнэ. Дараагаар нь хөрөнгө гэж юу болох, хаанаас үүсдэг, түүгээр юу хийдэг, яагаад хөрөнгө бидэнд хэрэгтэй болох тухай, мөн хүмүүсийн нийгэмлэгт оршдог хөрөнгө ямар бүтэцтэй, хэрхэн хоорондоо сүлжилдсэн байдаг тухай (дэмжигчдийнх нь адилаар шүүмжлэгчид нь ч голдуу үл анзаардаг) хамгийн чухал ач холбогдлыг тайлбарлана.

Тэгээд өмч, өмчлөлийн эрх, сэдэл санаачилга, өрсөлдөөн, зах зээл, институтууд, төрийн мөн чанар болон үүрэг нөлөөг судалж үзэнгээ капитализм ажиллахад шаардлагатай зүйлс юу болохыг нягталж шалгагцаа. Үүний дараа капитализмын талаар гаргасан ёс суртахууны шүүмжлэлийг түүний талаархи (илүү ховор сонсогддог) ёс суртахууны зерэг төсөөлөл, үр нөлөөний хамтаар авч үзнэ.

Энэ номд капитализмын идеал болон зарчмууд үүсэхэд тус болсон эдийн засгийн тогтолцоонууд хийгээд түүнийг маш ихээр буртаглаж халхалсан улстөрийн хөндлөнгийн оролцоог тоочиж тайлбарлан капитализмыг түүхийн агуулгаар өгүүлнэ.

Ингээд энэ номд капитализмын оюун санааны зарим нэг гарамгай мэргэдийн үзэл санааг товчхон тайлбарлаж, капитализм руу

дайрагчдын шүүмжлэлд анхаарал хандуулна.

Эцэст нь ирээдүйг нь үнэлж цэгнэхийнхээ өмнө капитализмын хүч чадал, сул тал, боломж бололцоо, аюул заналыг талаар ерөнхийлж өгүүлээд, уншигчдадаа энэхүү сэтгэл хөдөлгөм сэдвийн талаархи илүү гүн мэдлэг өгөх нэмж унших эх сурвалжийн товчхон жагсаалт гаргалаа.

ХОЁРДУГААР БҮЛЭГ: Капитализм гэж юу вэ?

Бодит байдал ба буруу ойлголтууд

Гээд та нар түүнийг юу гэж тодорхойлсон ч бай капитализм хүмүүний эд баялаг, амьжиргааны төвшнийг асар ихээр өсгөсөн. 1760-аад оны Аж Үйлдвэрийн Хувьсгалын үүр цайх хүртэл хүмүүний амьдрал багахан л өөрчлөгджээ. Ихэнхи хүмүүс [Египтийн] Фараоноос хойш бараг өөрчлөгдөөгүй арга барилаар газар тариалан эрхэлдэг байв. Америк эдийн засгийн түүхч Дейрдре МакКлоский (1942 онд төрсөн)-н тооцоолсончлон 1800-аад онд дэлхийн дундаж иргэний орлого өдрийн \$1-ээс \$5 хооронд байжээ. Энэ орлого одоо өдрийн бараг \$50 болсон. Бүр дээр нь энэ дундаж утга илүү капиталист тогтолцоотой улсуудын хүрсэн асар их цэцэглэлтийг дарж халхалдаг. Өнөөдрийн хамгийн капиталист бус улсуудын зарим нь өдрийн \$1-5-ын орлоготой ядууралд шигдсэн байхад капиталист Швейцар, Австрали, Канад, НХУ дахь өдрийн дундаж орлого \$90-оос одоо давжээ. АНУ-ын хүмүүсийн орлого дунджаар өдрийн \$100-ыг давж орчин үеийн Америкчууд 1800-аад оны өвөг дээдсээсээ 20-100 дахин баян болов.

Бас дээр нь энэхүү асар их хөгжил цэцэглэлт зөвхөн хэдхэн баячуудаар л хязгаарлагддаггүй. Нэгэнтээ тансаг зүйл байсан тохитой байшин, гэрэлтүүлэг, байрны халаалт, солих хувцас, аялал, чөлөөт цаг, үзвэр үйлчилгээ, шинэ мах капиталист улсуудад бүх хүмүүст олдоцтой зүйл болов. Тоног төхөөрөмжүүд үйлдвэрлэл болон гэр орны хүнд хүчир ажлыг хийх болжээ. Эрүүлмэнд, боловсрол сайжирч, хүүхдийн эндэгдэл буурч, хүмүүс урт насалдаг болсон.

Капитализмыг гутаасан нь

Хэдийгээр бүр (МакКлоскийн нэрлэсэн) энэ "Аугаа Баяжилт" эхлээ ч үгүй байхад капитализм гэдэг үгийг нүд үзүүрлэх хэллэг болгож орхисон байв. Хөрөнгө гэдэг үгийн гарвал бүр эрт 1100-ээд он хүрдэг. Энэ үед ("толгой" гэсэн утгатай *caput* гэдэг үгнээс гаралтай) *capitale* гэсэн Латин хэллэгийг малын тоо толгойг илэрхийлэхэд ашиглаж байсан бөгөөд хожим нь бараа бүтээгдэхүүн эсвэл мөнгөнд ашиглах болсон; зүгээр л хөрөнгө өмчлөгч гэсэн утгатай капиталист гэдэг үг 1600-аад онд гарчээ. Хэдийгээр Аж Үйлдвэрлэлийн Хувьсгал өргөн олныг баяжуулсан ч гэсэн 1867 онд Герман улстөрийн сэтгэгч Карл Маркс (1818-83 он) *Das Kapital* [орч. Капитал буюу Хөрөнгө] гэсэн номдоо өнөөдөр бидний — капитализм гэж нэрлэдэг — "үйлдвэрлэлийн капиталист загвар"-ыг дорд үзэн, үл тоож байв.

Марксын ширүүн дайралт өнөөдөр ч маргаан мэтгэлцээний хэлбэрийг тодорхойлсоор байгаа, маш амжилттай довтолгоон болсон. Олон хүн өнөө ч гэсэн капитализмыг амиа хичээх, шунал, бусдыг боддоггүй зэрэг нийгмийн эсрэг эсвэл ёс суртахуунгүй сэдэлд үндэслэсэн гэж үзсээр л байна. Гол төлөв бүр эдгээрээс нийгмийн сайн сайхан зүйл гарах боломжгүй гэсэн үзлээр иймэрхүү сэдлүүдтэй капитализмыг холбож тодорхойлдог. Харин нийгмийн сайн сайхан зүйл гарах болно гэсэн үзлээр социализмыг — бусдын төлөө өөрийгөө зориулах (алтруизм), хамтын ажиллагаа, эв зохицол — гэсэн сайн сэдэлд үндэслэсэн гэж үздэг.

Гэвч хувь хүний сэдэл болон нийгэмд гарах үр дагаврын хоорондох холбоос ийм илэрхий ойлгомжтой байдаггүй. Шотландын философич, эдийн засагч Адам Смит (1723-90 он), жишээлбэл, өөрийн-тусыг бодох явдал хэрхэн нийгэмд тустай үр дагавар бий болгох боломжтой болохыг харуулсан бол харин Орос-Америкийн зохиолч Айн Рэнд (1905-82 он) бусдын төлөө өөрийгөө зориулах явдал (алтруизм) нийгэмд зөвхөн гай тарих болно гэж батлан өгүүлсэн. Капитализм эсвэл социализмд хүмүүст жинхэнээсээ ямар сэдлүүд урам зориг өгдгийг анзаарч тэдгээрээс бодитоор нийгмийн ямар сайн эсвэл муу үр дагавар гардгийг

мөшгөх явдал бол чухал хэрэг.

Капитализмыг тайлбарлагчдын өөр нэг нийтлэг гаргадаг алдаа эсвэл хууран мэхлэлт бол капитализмын бодит байдлыг социализмын идеалтай "социализмын идеалийг хэрэгжүүлэх гэж хэзээ ч оролдож байгаагүй" гэж зөвтгөн харьцуулдаг явдал юм. Тэгэхдээ социализмыг цэвэр ариун, сайн зүйл гэж дүрсэлж харуулдаг бол харин капитализмыг муу сэдэл, үйл, эдийн засгийн саяхны түүхийн үр дүн бүрд буруутгана. Гэвч онолыг бодит амьдралтай харьцуулах нь ёс бус зүйл: онолыг онолтой, үр дагаврыг үр дагавартай л харьцуулах ёстой. Капитализмыг хамгаалагчид түүнийг энэ хоёрын алинд нь ч ялна гэж хэлдэг.

Өөр олон худал домог, буруу ойлголт бий. Жишээлбэл, капитализмд хэдхэн хувь хүн л хөрөнгө өмчилж, түүнийг хянадаг гэж батлан мэдэгддэг. Энэ бол буруу: дараагийн бүлэгт харуулахчлан бид бүгдээрээ их бага ч гэсэн хөрөнгө өмчлөгчид. Мөн капитализм бол цалин өгч ажиллуулан бараа бүтээгдэхүүн асар их хэмжээгээр үйлдвэрлэх явдал юм хэлдэг бөгөөд дараагаар нь хэлэлцүүлгээ нийгмийн анги, мөлжлөгийн асуудал руу хандуулна. Дахиад л энэ бол буруу дүгнэлт: ихэнхи капиталист аж ахуйн нэгжүүд жижигхэн компаниуд, бие даасан наймаачид байдаг. Капитализмыг ашиг, зах зээлтэй холбож голдуу адилтгаж харуулна. Гээд эдгээр зүйл мөн бусад тогтолцоонд ч бий. Капитализм бол монополь байдал, кронизм буюу амин найзаа тэтгэх явдал юм гэцгээдэг. Гэвч дахиад л эдгээр зүйл зөвхөн капитализм байдаггүй ч улстөрийн хөндлөнгийн оролцоогоор тэдгээрийг энэ тогтолцоонд тэтгэж ирсэн.

Тодорхойлолтоос нь гардаг бэрхшээл

Капитализмын тухай илүү бодит тодорхойлолт бүрэн боловсорч гараагүй л байна. Бид тээшээ цэвэрлэж, жинхэнэ концепц буюу ойлголтоо таньж мэдэх хэрэгтэй байна.

Капитализм гэдэг үг бидэнд сэжүүр өгдөг. Түүний капитал гэсэн хэсэг нь энэ нь хөрөнгө буюу капиталын тухай зүйл гэдгийг хэлнэ. Харин -изм гэсэн хэсэг нь *өргөн хүрээтэй амьдрах арга*

гэдгийг харуулдаг. (Үүнийг "систем" гэж нэрлэж болох ч систем нь капитализмаас илүү төвлөрсөн зохион байгуулалт, удирдлагатай зүйлийг санагдуулдаг.) Тэгэхээр мөн чанарынхаа хувьд капитализм бол хөрөнгө ашигладаг амьдралын арга зам юм.

Хөрөнгө буюу капитал гэдэг үг энэ ойлголтыг илэрхийлдэг — энэ бол тодорхой үндсэн хөрөнгө (анг. capital goods)-ийн нийлбэр цогцын тухай хийсвэр үзэл санаа. Бид амьтан гэдэг үгээр зүгээр л зөвхөн тодорхой тооны шонхор, шумуул, бар, аалз, чийгийн улаан, далайн гахай бодитоор оршдог гэсэн санааг дүрсэлж тайлбарлах гэж хэрэглэдэгчлэн капитал гэдэг хийсвэр санаа бодит байдал дээр багаж хэрэгсэл, техник хэрэгсэл, санхүү зэрэг тодорхой үндсэн хөрөнгөд бодитоор оршдог. Гэвч энэ санаа асар аж үйлдвэр, тээрэм, том бизнесийн үйлдвэрлэлийн шугамаар л хязгаарлагддаггүй. Үндсэн хөрөнгө бид бүгдийн эргэн тойронд, хөгжингүй ертөнцийн гэр орон (угаалгын машин, тоос сорогч), албан байр (компьютер, утас), дэлгүүр (кассын машин, лангуу), театр, сургууль, эмнэлэг бүрд бий.

Хөрөнгө ашиглах явдал яагаад амьдрах арга зам юм бол? Учир нь үндсэн хөрөнгө бидэнд хүссэн зүйлээ хялбар, үр өгөөжтэй үйлдвэрлэх боломж ихээр олгодог. Жишээлбэл, бид хүний хөдөлмөр хамаагүй бага зарж, улаан буудай тарьж хураахдаа хөдөө аж ахуйн машин техник ашиглан, гурил тээрэмдэх болон талх барихдаа цахилгаан эрчим хүч хэрэглэн илүү олон талх үйлдвэрлэж чадна.

Капитализмын илүү өргөн холбоо хамаарал

Эдийн засагчид ер нь газар эсвэл хөдөлмөрийг үндсэн хөрөнгө (анг. capital goods)-д оруулдаггүй. Тэд үндсэн хөрөнгийг байгалийн нөөц гэж үздэггүй харин үйлдвэрлэлийн гарц бүтээгдэхүүнийг ихэсгэх зорилгоор хэн нэгэн хүний бүтээсэн ашиглах нөөц гэж үздэг. Бүр хэдий үндсэн хөрөнгө мод, төмрийн хүдэр зэрэг байгалийн хэрэглэгдэхүүн байдалтай анх байх боломжтой байдаг ч гэсэн хэн нэгэн хүн түүгээр хүрз, сэрээ хийх хэрэгтэй.

Тийм учраас үндсэн хөрөнгө хэн ч эзэмшдэггүй онгон зэлүүд

газар эсвэл хоосон цөл шиг зүйл биш юм. Түүнийг бүтээхэд хэн нэгэн хүн цаг хугацаа, хүч чадлаа зориулдаг. Үндсэн хөрөнгийг бүтээсэн хүн тэдгээрээ өөрийн хувийн өмч гэж үзэх ёстой гэдэг нь жам ёсны зүйл. Эцсийн эцэст ийм хүмүүсийн хүчин чармайлт л үндсэн хөрөнгийн амин чухал хэсэг бөгөөд түүнгүйгээр эдгээр зүйл оршихгүй байсан. Хөрөнгийн тухай концепц буюу ойлголт тиймээс *үндсэн* хөрөнгийн хувийн өмчлөлийг харуулдаг эсвэл дор хаяж үүний талаар тууштай сануулж байдаг.

Энэ байдал хөрөнгийг зөвхөн хэдхэн баян хувь хүмүүс, ихэд тархсан шог зургийн "баян хөрөнгөтөн" өмчилдөг гэсэн үг биш. Үүний эсрэгээр аливаа хүн, эсвэл хоршоо эсвэл компани зэрэг бүлэг хүмүүс үндсэн хөрөнгө бүтээх, өмчлөх боломжтой. (Хэдий *капитализм* гэдэг үгийн ердийн хэрэглээний хувьд гажиг харагддаг ч гэсэн зарим хүн бүр төр засаг нь аж ахуйн газар өмчилж, эрхлэн явуулдаг "төрийн капитализм" гэж ярьдаг.) Мэдээжээр капитализм хэрэв үндсэн хөрөнгийг хувь хүмүүс эсвэл хоорондоо нягт холбоотой бүлэг хүн хувьдаа өмчилдөг, хянадаг байвал хамгийн сайн ажилладаг. Хэдий хувийн өмчлөл зөвхөн капитализмд л байдаггүй (, магадгүй түүний хувьд амин чухал зүйл биш) байж болох ч гэлээ энэ нь голдуу капитализм гэсэн ойлголттой маш нягт холбоотой байдаг.

Капитализм мөн зах зээлээр дамжин бараа бүтээгдэхүүн түгж тархахтай голдуу холбоотой байдаг. Гэвч зах зээл капитализмтай адилхан зүйл биш. Капитализм бол эдийн засгийн бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэх явдал; харин зах зээл нь тэдгээрийг түгээх тархаах явдал юм. Энэ хоёрыг хооронд нь хольж будлиулснаар капитализм гэж юу вэ, энэ нь хэрхэн ажилладаг тухай ноцтой алдаанд хүрнэ.

Зах зээл зөвхөн капитализм л байдаг зүйл биш: үйлдвэрлэлийн бусад тогтолцоонд ч гэсэн түүнийг ашигладаг. Бас зах зээл капитализмд амин чухал байдаггүй: зах зээлийн бүтээсэн зүйлсийг ямар нэг өөр замаар, жишээлбэл засгийн газрын тушаал эсвэл сугалаагаар түгээх боломжтой. Гэвч капитализм юмс үйлдвэрлэхэд маш үр өгөөжтэй байгаа учраас биш ч гэлээ түгээлтийн ямар үр дүнтэй хэлбэр бид олох ёстой болсон: нарийн төрөлжсөн үндсэн

хөрөнгө ашигласнаар бий болох боломжтой болсон асар их бүтээмж хүмүүст хожим арилжаалж болох маш их илүүдэл зүйл үйлдвэрлэх бололцоо олгожээ. Зах зээл түгээлтийн маш үр ашигтай арга хэрэгсэл болж таарав: тиймээс л капитализм, зах зээл хоёр хамтдаа оршдог.

Капитализмд амин чухал байдаггүй зүйл

Марксын нөлөөнд автсан олон зохиогч капитализм гарцаагүй цалингийн тогтолцоонд суурилдаг гэж үздэг. Тэдний бодлоор бол капиталист ажил хэрэгч хүмүүс тээрэм, аж үйлдвэр зэрэг үндсэн хөрөнгө хуримтлуулаад, тэдгээрээ ажиллуулахын тулд асар олон ажилчид хөлсөлдөг ажээ. Капитализмын тухай энэ үзэл бодол эдгээр зохиогч нарт ажил хэрэгч хүмүүсийн ашиг болон ажилчдын цалинг хооронд нь сөргөлдүүлж үзэх үндэс суурь болдог бөгөөд үүнийг тэд ажилчдаа хөрөнгөтнүүд нь мөлждөг ангийн суурь хуваагдлын үндэс гэж хардаг.

Энэ үзэл бодол буруу зүйл. Капитализм заавал цалингийн тогтолцоо, мөн ангийн хуваагдлыг илэрхийлдэггүй. Хэнийг ч хөлсөлдөггүй ганцаараа ажилладаг наймаачид бас л үндсэн хөрөнгөтэй болдог: ваарчин эргэх хүрд, шатаах зууханд, дэлгүүрийн эзэн кассын машинд, зөвлөх хүн компьютер, утсанд тус тус хөрөнгө оруулна. Бүхэлдээ тоног төхөөрөмж ажилладаг илүү том хэмжээтэй үйлдвэрлэлийг төсөөлцгөөе: үнэндээ автомашин үйлдвэрлэгчид, онлайн худалдаачид, санхүүгийн арилжаа хийгчид, бусад хүмүүс ч бараа бүтээгдэхүүнээ хүргэж өгөхдөө улам бүр л робот хэрэглэх болжээ. Үнэн хэрэгтээ капиталист нийгэм л жинхэнээсээ дэлхийн хамгийн нээлттэй, нийгмийн шилжилт хөдөлгөөн ихтэй, хамгийн бага ангийн хуваагдалтай улс байдаг.

Бас *монополь байдал* капитализмын салшгүй зүйл байдаггүй. Маркс цар хүрээний үр нөлөөнөөс болж капиталист аж ахуйнууд гарцаагүй асар том монополь аж ахуйнууд болж томрох болно гэж бодсон. Гэвч бодит байдал дээр эдгээр аж ахуй нэгж цар хүрээний нөлөөнөөс ангид бас байдаг: том аж ахуйн нэгжүүдийг удирдахад

хамаагүй хэцүү бөгөөд эдгээр нь технологи болон хэрэглэгчдийнхээ эрэлтийн өөрчлөлтөд хоёуланд нь хамаагүй удаан дасан зохицдог — ингэхдээ илүү жижиг, овжин өрсөлдөгчдөдөө өөрсдийнхөө бизнесийг булаах боломж, хугацаа олгоно. Үйлдвэрлэгчид улстөрийн нөлөөг өөрсдөдөө таатайгаар зах зээлийг залж залуурдах гэж ашиглах боломжтой, голдуу ашиглахыг оролддог гэдэг нь үнэн: гэвч энэ явдал капитализмын тухай ойлголттой ерөөсөө үл нийцэх зүйл бөгөөд бас түүний амин чухал зүйл биш. Жинхэнэ капитализмд бизнес томрох цор ганц арга зам бол хүмүүсийн худалдаж авахыг хүсэж буй бараа бүтээгдэхүүн нийлүүлж, үйлчилгээ үзүүлэх явдал юм. Технологи болон хэрэглэгчдийн таашаал маш хурдтай өөрчлөгдөхийн хэрээр ямар ч хүнд монополь байдлаа хадгалах маш хэцүү болдог.

Капитализмд л зөвхөн байдаггүй зүйлс

Шүүмжлэгчид нь үнэндээ бодит байдал дээр тийм биш байдаг ч гэсэн капитализмын хувьд амин чухал байгаад зогсохгүй, бас зөвхөн түүнд байдаг гэж боддог, бичдэг хэд хэдэн зүйл бий. Энэ бол капитализмын нэр хүндийг унагаадаг өөр нэг будлиан, эсвэл хууран мэхлэлт юм.

Жишээлбэл, капитализмыг ерөөсөө ашиг хөөдөг гэж ихэвчлэн бичдэг: ашгийг голдуу л муу зүйл гэж үздэг. Энэ хоёр үзэл бодол хоёулаа алдаатай зүйл. Ашиг зүгээр л өөрийн оруулсан зүйлээсээ илүү их үнэ цэнэ олж авна гэсэн үг юм. Гэвч ашиг нь зөвхөн мөнгөний тухай ойлголт биш. Бид амьдралынхаа мөч бүрдээ санхүүгийн бус ашгийн төлөө зорьж тэмүүлдэг. Бид шанд нь биширмээр үзэсгэлэнтэй байдал харах гэж уулын орой руу зовж зүдрэн авирах эсвэл асар их сонирхдог зүйлээ сурч мэдэх гэж лекц ярианд суухдаа гаргасан хүчин чармайлтаас ашиг хүртэж байна гэж бодоцгооно. Капиталист байна уу эсвэл өөр байна уу эдийн засгийн аливаа тогтолцоонд хүмүүс үнэ цэнийн хувьд үүнтэй адилхан өгөөж олж авахыг боддог. Үнэндээ цаг хугацаа, эрч хүч, нөөц зэрэг орц хэрэглэгдэхүүн оролцдог, эрсдэл хүлээсэн эдийн засгийн аливаа

үйл ажиллагаа хэрэв бид бүтээсэн бараа бүтээгдэхүүнээ түүнийг үйлдвэрлэхэд оруулсан орц хэрэглэгдэхүүнээсээ бага үнэлж үзвэл энэ нь утгагүй хэрэг болно.

Бас хачин байлаа ч гэсэн хөрөнгө зөвхөн капитализмд л байдаг зүйл биш. Үйлдвэрлэлийн бусад хэлбэрт мөн л үндсэн хөрөнгө ашигладаг. Бүдүүн бараг тосгоны хамтралд хэрэглэдэг гар багажнаас авахуулаад хамгийн хөгжингүй социалист эдийн засгийн тээрэм, үйлдвэрүүд хүртэл бүгд барьж бүтээсэн, үйлдвэрлэлийг илүү хялбар, үр өгөөжтэй болгоход ашигладаг үндсэн хөрөнгө юм.

Капитализмын шүүмжлэгчид голдуу үр нөлөөнийх нь төлөө "амь өрссөн өрсөлдөөн" гэж нүд үзүүрлэн нэрлэдэг *өрсөлдөөн* зөвхөн капитализмд л байдаггүй. Бусад тогтолцоонд ч гэсэн хүмүүсийг илүү шаргуу ажиллуулах, илүү бүтээлч эсвэл санаачилгатай байлгах гэж урин дуудах арга зам болгож шагнал (жиш. санхүү, улстөр эсвэл хүндэтгэлийн шан урамшуулал)-ын төлөөх өрсөлдөөнийг хэрэглэдэг.

Кронизм бол капитализмын цөм ойлголт биш, мэдээжээр зөвхөн түүнд ч энэ зүйл байдаггүй. Капитализмын зарчмууд хөрөнгө өмчлөгч болон улстөрчдийн бузар муу хамсал бусдыгаа мөлжиж ашиглах явдлыг илэрхийлдэггүй. Үнэндээ эдгээр зарчим төрийн эрх мэдлийг хувь хүмүүсийг бусад хувь хүмүүсээс ирэх эсвэл төр болон түүний амин найзуудаас ирэх албадлага, хулгайнаас *хамгаалахаар* л хязгаарладаг. Бодит байдал дээр кронизмын хувьд социалист нийгэм дотор олз олох хамаагүй илүү боломж бий. Ийм нийгэмд төр нь аливаа юмсыг удирдаж чиглүүлэхийн тулд данхар байх учиртай бөгөөд үүнээс улбаалаад улстөрчид болон албан тушаалтнуудыг хахуульдах замаар төрийн эрх мэдлийг улам ихээр сорж мөлждөг.

Мөлжлөгүнэн хэрэгтээ капитализмын нэг хэсэг биш. Капитализм хүмүүсийг тодорхой эд зүйл худалдан авах эсвэл үйлдвэрлэх эсвэл хэрэглэхийг албадаж хүчлэх замаар биш харин сайн дурын солилцоогоор дамжуулан ашиг тусаа хүмүүст өгдөг. Хүмүүсийг ажил олгогчийн төлөө цалинтай хөдөлмөр хий гэж албадаж хүчилдэггүй: хүмүүс өөрсдийнхөө төлөө л ажиллах боломжтой; аж ахуйн нэгжүүд төрийн шаардсан зүйлийг үйлдвэрлэх үүрэггүй;

хувь хүмүүс юу хийх, юу худалдан авахаа сонгох боломжтой байдаг. Нэгэнт л капитализм дахь солилцоо сайн дурынх байдаг тул солилцооны хоёр тал хоёулаа ашиг тус хүртэх үед л зөвхөн солилцоо болно. Хүүхдүүд хөлбөмбөгийн наадаг зургаа хоорондоо солилцдог шиг сайн дурын солилцооноос тал нэг бүр нөгөөдөө өгснөөс илүү үнэ цэнэтэй ямар нэг зүйлтэй үлддэг: тухайн солилцооноос хоёр тал ашиг тус гарна гэж үзэхгүй л бол арилжаа худалдаа ерөөсөө болохгүй. Капитализмд ч гэсэн ийм зүйл бий: хөгжиж цэцэглэхийн тулд үйлдвэрлэгчид тэдэнд хэрэглэгчид нь өгдөг мөнгөнөөсөө илүү үнэлж үзэж буй бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээ бүтээх ёстой; хэр таарсан ажил олохын тулд ажилчид оронд нь өгч буй цаг хугацаа болон хүчин чармайлтаасаа илүү, олох орлогоо үнэлж үздэг байх ёстой. Сайн дурын иймэрхүү солилцоо хүмүүсийг мөлждөггүй харин тэднийг илүү баян чинээлэг болгодог.

Эцэст нь *шунал* капитализмд л зөвхөн байдаггүй; шунал эдийн засгийн бүх тогтолцоонд, амьдралын алхам бүрд бий. Капитализм мэдээж хүмүүний жам ёсны зан чанар болох өөрийн-тусыг бодох явдалд үндэслэдэг: хэрэв бид өөрсдийнхөө ашиг сонирхлоо хүндлэхгүй бол урт хугацаанд амьдарч чадахгүй. Гэвч капитализм (ёс суртахуунгүй) шуналыг шийтгэдэг. Чөлөөт хүмүүс тэдний шударга бус, итгэл даадаггүй эсвэл зөвхөн өөрсдийгөө хэтэрхий анхаардаг, харилцагчдаа үл тоодог гэж үздэг үйлдвэрлэгчидтэй ерөөсөө харьцахгүй. Өрсөлдөөнт эдийн засагт тэдний очих боломжтой өөр олон нийлүүлэгч бий. Энэ нь яагаад бидэнд цайны газрууд илүү мөнгө нэмж авч байгааг зогсоох "шуналын эсрэг" хууль хэрэггүй болохыг харуулдаг: хэрэв тэд ингэсэн бол хэрэглэгчид нь тэднийг орхин одно. Үнэндээ капитализм бол хүмүүс хамтран ажилладаг газар юм: бид бүгдээрээ шударга худалдаагаар өрнөдөг хамтын ажиллагаанаас ашиг тус хүртэнэ; бид бүгдээрээ хүмүүс нь шударга байдаг ертөнцөд амьдрахыг хүсдэг.

Капитализмыг тодорхойлж хэлбэл

Тэгвэл капитализмыг хэрхэн тодорхойлох вэ? Мөн чанартаа энэ

бол хүмүүс тэд болон бусад нь хүсэж буй бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээг аль болох үр өгөөжтэйгөөр үйлдвэрлэж гаргахын тулд үндсэн хөрөнгө барьж бүтээдэг, хэрэглэдэг эдийн засгийн амьдралын ерөнхий арга зам юм.

Энэхүү суурь тодорхойлолтоос гадна капитализм түүнд л зөвхөн байдаггүй эсвэл амин чухал байдаггүй бусад зүйлтэй мөн холбоотой байж болно. Жишээлбэл, энэ нь хувь хүмүүс болон бүлэг хүмүүсийн өмч өмчлөх хувийн өмчлөлтэй холбоотой байдаг. Өмчийг хэрхэн олж авах, хамгаалах, ашиглах эсвэл дамжуулах тухай ёс журам болох өмчийн эрх эдгээр нь бүтээмж-сайтай бараа бүтээгдэхүүн өөртөө итгэлтэйгээр бүтээх, хэрэглэх боломж олгодог учраас капитализмд чухал байдаг.

Капитализм мөн зах зээлийн солилцоотой холбоотой. Эдийн засгийн бараа бүтээгдэхүүнийг түгээх бусад арга зам байх боломжтой ч зах зээлийн солилцоо л капитализмын (мөн маш их үр ашигтай) үйлдвэрлэгчдийн бий болгох боломжтой элбэг дэлбэг байдлыг түгээж тархаах үр ашигтай арга зам болдог. Нэмж хэлэхэд зах зээлийн үнэ үйлдвэрлэгчдэд хэрэглэгчдийнх нь чухалчилж буй зүйлийн талаар сануулж, үйлдвэрлэгчдэд хөрөнгөө тэдний илүүд үзэж буй зүйлийг аль болох үр ашигтай хангахад нь тусалдаг.

Капитализмыг ихэвчлэн амьдрах эдийн засгийн арга зам гэж хардаг — энэ арга зам эдийн засгийн бараа бүтээгдэхүүн бүтээх, түгээхтэй холбоотой ч харин ёс суртахуун эсвэл нийгэмд гарах үр дагавартай холбоогүй. Гэлээ гээд энэ бол үнэндээ олон төвшин дэх хүмүүний хамтын ажиллагаанд үндэслэсэн нийгмийн тогтолцоо юм.

Капитализм бас маш ёс суртахуунтай тогтолцоо. Энэ тогтолцоон дахь хүмүүний харилцаа албадаж хүчлээгүй харин сайн дурынх байдаг. Хүмүүс хүссэнээрээ хөрөнгө оруулж, эд зүйл бүтээж, нийлүүлж, зарж, худалдан авна. Ямар ч төр засаг тэдний үйлдлийг заадаггүй: тэд л шийдвэр гаргадаг. Үнэндээ төр засагт байдаг эрх мэдлийн цор ганц үүрэг бол хувь хүмүүсийг албадаж хүчлэх эсвэл дээрэмдэх, хууран мэхлэх, эсвэл өөр бусад байдлаар халдахаас тэднийг хамгаалах явдал юм. Капитализм тушаал

зааварт тулгуурладаггүй харин хууль ёсонд үндэслэдэг. Хууль ёс бол (шударга харилцах, гэрээгээ хүндлэх, хүчирхийллээс зайлсхийх зэрэг) нийтээр-мөрддөг ёс журмыг хүнд бүрд, үүн дотроо төр засгийн засаг захиргаанд хэрэглэх явдал юм.

Гэлээ гээд дүрмээ дагаж тоглодог тоглоом адилаар капитализм ямар нэг тодорхой үр дүнг баталгаажуулж өгдөггүй. Капитализмыг гэмт хэрэг, тэнэг үйлдэл эсвэл хүмүүн төрөлхтөний азгүйтэлд буруутгах учиргүй. Капитализм гэгээрэл эсвэл тэгш байдлыг амладаггүй. Капитализм (хэдийгээр үнэндээ капитализм хүн бүрийг баян болгодог ч гэлээ) хүн бүрийг баяжуулна гэж бүр ч амладаггүй. Харин капитализм эдийн засгийн бүтээмжийг эрс нэмэгдүүлнэ, үүнийгээ бүх хүнд боломж бололцоо нээлттэй байлгах замаар нэмэгдүүлнэ, хүмүүстэй ижил тэгш, шударга харьцана, хуурам мэхлэлт, албадлага, хүчирхийллээс татгалзана гэж амалдаг.

ГУРАВДУГААР БҮЛЭГ: Хөрөнгө буюу капитал гэж юу вэ

Капитал буюу хөрөнгөний тухай концепц

Бидний харсанчлан *хөрөнгө* бол *амьтны* тухай ойлголттой адилхан хийсвэр санаа юм. Гэвч ихэнхи хүмүүс харах үедээ ямар нэг зүйлийг амьтан гэж ялгаж таньж чаддаг бол харин бүр түүнийг өмчилдөг, хэрэглэдэг хэрнээ цөөн хүн л хөрөнгө гэж юу болохыг ухаж ойлгодог.

Дахиад л олон хүн асар том үйлдвэр, барилга, өргөгч цамхаг, метал хэвлэгч, санхүүгийн сан гэсэн утгаар л хөрөнгийг хардаг явдал хөрөнгийг зөвхөн баян цөөнхи л өмчилдөг гэсэн санааг улам лавшруулдаг. Гэвч бодит байдал дээр үндсэн хөрөнгө (*capital goods*)-ийг хөгжингүй улс оронд бараг л хүн бүр өмчилдөг бөгөөд үүнээс нь бусад хүмүүс ашиг тус хүртдэг. Үндсэн хөрөнгийг ардчилсан шинжтэй гэж хэлж ч болох юм.

Хөрөнгийн зориулалт

Юуны түрүүнд хөрөнгө яагаад оршдог вэ гэдгийг асуугууштай. Үүний хариулт бидэнд хэрэгтэй, бидний хүсдэг олон бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээг илүү үр ашигтайгаар үйлдвэрлэхдээ ашиглах гэж л үндсэн хөрөнгө бид бүтээдэг гэсэн хариулт байх болно. Эдгээр нь хувцас, хүнс, орон байр, гэрэлтүүлэг, байрны халаалт, эм, боловсрол, тоглоом, тээвэр, харилцаа холбоо, урлаг, үзвэр үйлчилгээ, бидний хүсдэг бусад олон зүйлийг илүү хямдаар, үр ашигтай үйлдвэрлэх боломж олгодог.

Бидний эд юмс үйлдвэрлэдэг цор ганц шалтгаан бол бид тэр эд юмсыг таашаан эдлэх гэж хүсдэг явдал юм гэдгийг санаж

байх нь чухал шүү. Шотландын эдийн засагч Адам Смит (1723-90 он) үүнийг дараахь байдлаар хэлсэн: "Хэрэглэх явдал бол бүх үйлдвэрлэлийн цор ганц зорилго, зорилт юм." Гэлээ гээд капитализмын олон шүүмжлэгч юуны түрүүнд бид яагаад эд юмс үйлдвэрлэдэг эсвэл бид юу үйлдвэрлэхийг хүсдэг вэ гэдгийг бодолгүйгээр үйлдвэрлэлийн бүтцийг яаж дахин өөрчлөх вэ гэдэгт л анхаарлаа төвлөрүүлдэг. Гэвч бидний цаг үед дэмий зарлагадахад хүчин чармайлт, оюуны хүч хэтэрхий хайран байна. Бид өөрсдөдөө хэрэгтэй эсвэл өөрсдийнхөө хүсэж буй эд юмсаа үйлдвэрлэхэд, мөн тэдгээрээ чадахынхаа хэрээр хурдан, хялбархан, хямд үйлдвэрлэхэд анхаарлаа төвлөрүүлэх хэрэгтэй.

Хөрөнгө хэрхэн бүтээмжийг эрс нэмэгдүүлдэг вэ

Бид хөрөнгө биднийг илүү бүтээмжтэй болгодог учраас түүнийг барьж бүтээн, ашигладаг. Жишээлбэл завь, нарийн мяндас, тор ашиглаж нүцгэн гараараа барьж чадахаасаа хамаагүй их загас бид барьж чадна. Трактор, комбайн ашиглаж бид газар тариалан эрхэлж, илүү бага хүчин чармайлт гаргаж илүү их хүнс үйлдвэрлэх боломжтой. Нэхэх машин ашиглаж бид илүү их хөвөн боловсруулснаар илүү хурдан, илүү хямдаар, илүү олон хувцас үйлдвэрлэж чадна. Ачааны машин ашиглаж бид эдгээр бүтээгдэхүүнийг хамгийн хэрэгтэй газар нь хурдан шуурхай хүргэж түгээх боломжтой.

Үнэндээ үндсэн хөрөнгө бидэнд юмсыг асар их хэмжээгээр эсвэл чанартайгаар, хамаагүй бага өртгөөр үйлдвэрлэх боломж олгон бүтээмжийг маш ихээр нэмэгдүүлэх боломжтой. Британийн зохиогч Матт Ридлий (1958 онд төрсөн) өнөөдрийн цахилгаан чийдэн 1800 оны лаг бодвол 43 200 дахин хямдаар гэрэл гаргадаг гэж тооцоолсон бол харин хөдөө аж ахуйн үйлдвэрлэл 1900 оныхоос 600 дахин их болжээ. Ном хуулан бичигчид л ном бичих ёстой байсан үед зөвхөн хэдхэн баян хүн л үүнийг худалдан авах чадалтай байв; хэвлэлийн дардсаар одоо хэдэн саяар нь ном хэвлэж, бас түүнийг онлайнаар татан авах болжээ. Хөвөн даавуун хувцас

нэгэнтээ мөн тансаг хэрэглээ байлаа; гэвч Аж Үйлдвэрлэлийн Хувьсгалын нэхэх машин үүнийг зуу дахин хямд болгосон бөгөөд дэлхий даяар олон хүн хэрэглэх боломжтой болов. Үйлдвэрлэлийн шугамаас өнөөдөр гарч буй бугуйн цаг арванесдүгээр зуунд гараар хийдэг байсан халаасны цаг хийх зардлын мянганы нэгтэй дүйх өртөгтэй, улам л нимгэн, илүү нарийн заадаг болжээ.

Бүр үндсэн хөрөнгө бүр бидэнд эдгээр зүйл байхгүй бол хийх боломжгүй юмсыг бүтээх бололцоо олгодог. Европчууд болон Америкчууд өнөөдөр нэгэнт давслахаа байсан шинэ манго таашаан идэцгээж байгаадаа, үүнийг нь ердийн зүйл болгосон хөргүүртэй тээвэр, агаарын тээвэрт талархах учиртай. Ухаалаг утсаа ашиглаж бид дэлхийн нөгөө талд буй хүнтэй бизнес хийж, явуут дундаа найзтайгаа ярилцаж, эсвэл мэдээ, мэдээлэл, зугаацах зүйлээ асар том сангаас татаж авч чаддаг — дэлхийн симфони найрал хөгжим таны халаасанд одоо байна. Нанотехнологи бидэнд харахад хэт жижиг нарны зай, нян устгах чадалтай гэрэл цацруулдаг хальс, анхны хэмжээнээсээ арвантав дахин сунадаг даавуу бүтээх боломж олгодог.

Бидэнд шууд хэрэглэх шинэ, хямд, илүү сайн, илүү элбэг олдоцтой бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээ өгөхийнхөө хажуугаар үндсэн хөрөнгө мөн л эдгээр зүйлийг хийх үйл ажиллагаанд зориулж бүтээдэг, бас ашигладаг орц хэрэглэгдэхүүнийг ч гэсэн сайжруулдаг. Жишээлбэл, тоног төхөөрөмж бидэнд төмрийн хүдэр олборлох, ган цувих боломж олгоно. Энэ ганг бид хөнгөн тэрэг хийх эсвэл угаалгын машин эсвэл хоол хүнсээ хадгалах шилэн сав бүтээх шил үйлдвэрлэх эсвэл гутал, ор, цонхны хүрээ, каное завь хийхдээ ашигладаг полиуретан бодис гаргаж авахын тулд хэрэглэдэг хлор үйлдвэрлэхэд ашиглана.

Хөрөнгийн тухай уламжлалт ойлголтууд

Энэ бол биет таваар. Ихэнхи хүмүүс үндсэн хөрөнгийг багаж хэрэгсэл, үйлдвэрлэлийн техник төхөөрөмж, усан онгоц, үйлдвэр, эсвэл магадгүй албан байр, компьютер, түгээлтийн ачааны

машин зэрэгтэй адилхан биет таваар гэж боддог. Иймэрхүү бараа бүтээгдэхүүн бид эдгээр зүйлгүйгээр хийж чадахаасаа юмсыг илүү хурдан, илүү хялбар, илүү их хэмжээгээр хийх, түгээх боломж олгож бидний бүтээмжийг шууд л нэмэгдүүлдэг. Энэ бол энгийн ойлгохуйц зүйл.

Гэвч үндсэн хөрөнгийн зах зээл эдгээр (болон бусад) үндсэн хөрөнгийн бүтээмжийг улам л ихээр сайжруулдаг гэдгийг голдуу үл анзаардаг. Шинэ болон хуучин бүтээгдэхүүний зах зээл машин техник, усан онгоц, автомашин, бүр барилга байшинг ч хамгийн их үнэ цэнэтэй хэрэглээ рүү нь залж чиглүүлнэ.

Жишээлбэл, зай хураагуурын технологи сайжирснаар олон үйлдвэрлэгчид илүү хямд, илүү найдвартай, илүү дуугүй, илүү цэвэрхэн учраас илүү ачааны олон цахилгаан машин харин дизель ачааны машин илүү цөөн худалдан авч эхэллээ гэж төсөөлцгөөе. Ийм өөрчлөлт ачааны машин үйлдвэрлэгчид рүү тэднийг үйлдвэрлэлийн шугамаа шинэ эрэлтэд нийцүүлэн тохируулж, өөрсдийгөө дахин тоноглох ёстой гэсэн зах зээлийн дохио өгнө. Үүний дараагаар машин үйлдвэрлэгчдийн нийлүүлэгчид тэд илүү цөөн дизель хөдөлгүүр зарж байгаагаа олж мэдэх бөгөөд үйлдвэрлэлийнхээ шугамыг илүү сайн зарагдаж буй бүтээгдэхүүн үйлдвэрлэх рүү шилжүүлнэ. Хуучин дизель ачааны машин болон хөдөлгүүрийг энэ үеэр металыг нь илүү бүтээлч хэрэглээнд оруулахаар төмрийн хаягдалд тушаана эсвэл тэдгээрийг хэрэглэсээр байгаа хүмүүст хямд үнээр хуучин машины зах зээл дээр зарна. Ийм байдлаар хуучин болон шинэ үндсэн хөрөнгө автоматаар хамгийн их бүтээмжтэй хэрэглээ рүү урсдаг.

Энэ бол санхүүгийн хөрөнгө. Хөрөнгийн өөр нэг нийтэд танигдсан хэлбэр бол санхүүгийн хөрөнгө юм. Жишээлбэл сангийн менежерүүд банкуудаас хадгаламж эзэмшигчдээсээ цуглуулсан мөнгийг нь зээлж, үүнийгээ бизнесээ эхлүүлэх эсвэл өргөжүүлэхэд мөнгө хэрэгтэй байгаа бизнесүүдэд хөрөнгө оруулдаг. Энэ бизнесүүдийн хувьд санхүүжилт бол бусдынхаа л адил үндсэн хөрөнгө байж, тэдэнд юмсаа илүү үр ашигтайгаар үйлдвэрлэх эсвэл гарц бүтээгдэхүүнээ хэрэглэгчдийнхээ эрэлтэд нийцүүлэн

нэмэгдүүлэхэд хэрэгтэй тоног төхөөрөмж худалдан авах боломж олгодог.

Хэрэглэгчдийн эрэлт хангахдаа хамгийн их амжилт гаргасан бизнесүүд амжилт арай муутай нэгнээсээ илүү их орлого аз жаргалтай хэрэглэгчдээсээ олно: үүнээс улбаалаад тэд ч хөрөнгө оруулагчдаа илүү сайн өгөөж санал болгож чадах бөгөөд өөрсдийнхөө аж ахуйдаа санхүүгийн илүү их хөрөнгө татах боломжтой болно. Биет хөрөнгийн адилаар санхүүгийн хөрөнгийн зах зээл тиймээс санхүүгийн хөрөнгийг хамгийн их бүтээмжтэй хэрэглээ рүү залж чиглүүлдэг.

Хүмүүс ихэвчлэн хөрөнгийн бусад төрлийн адилаар санхүүгийн энэхүү хөрөнгийг ч баян цөөнхи заавал өмчилдөг байх ёстой гэж үздэг. Энэ бол алдаатай зүйл: эргээд бизнесүүдэд хөрөнгө оруулдаг сангийн эцсийн хөрөнгө оруулагчид "хүнд хэцүү үе"-дээ зориулж мөнгөө хадгалдаг эсвэл тэтгэвэрт гарах орлогоо хуримтлуулдаг, голдуу л жирийн хувь хүмүүс байдаг. Энэ хүмүүс бол жинхэнэ "хөрөнгөтнүүд".

Энэ бол дэд бүтэц. Цардмал зам, гүүр, боомт зэрэг дэд бүтэц бол арилжаа наймааг илүү хялбар, хямд болгож, бүтээмж нэмэгдүүлдэг таваар юм — гээд энэ нь хувь хүмүүс, бүлэг хүмүүс гэхээсээ илүүтэй төр засаг ерөнхийдөө өмчилдөг хөрөнгийн содон төрөл байдаг. Энэ байдал капитализмыг шүүмжлэгчдэд "капиталист" гэх аж ахуйн нэгжүүд үнэндээ төрөөс асар их хамааралтай байдаг гэж батлан өгүүлэх боломж олгодог. Гэвч ингэх нь олон цардмал зам, төмөрзамын сүлжээ, боомтыг анх хувийн хөрөнгө оруулагчид эсвэл оролцох сонирхолтой иргэдийн хувийн санаачилга хөдөлмөрөөр бүтээсэн гэдгийг мартсан хэрэг болно — үлдсэн байгууламжуудыг нь хувь иргэд болон бизнесүүдийн төлсөн татвараар санхүүжүүлдэг. Тиймээс бүр "олон нийтийн" дэд бүтцийг ч хувийн эд баялгаар барьж байгуулжээ.

Хөрөнгийн хамгийн чухал хэлбэр

Тэдгээр нь чухал гэж харагдаж байсан ч гэсэн хөрөнгийн төрлүүдийн

аль ч хэлбэр бид бүгдэд байдаг, бидний хүмүүний капитал (human capital) шиг чухал биш.

Америкийн эдийн засагч Гари Беккер (1930-2014 он) "хүмүүний капитал" гэдэг хэллэгийг гаргаагүй ч гэсэн энэ үзэл санааны талаар өргөн хүрээнд ажиллаж байсан. Хүмүүний хөрөнгө бол хувь хүмүүсийг илүү бүтээмжтэй болгодог бүх мэдлэг, хувийн зан чанар юм. Түүнд боловсрол, ур чадвар орох ч гэлээ мөн хөдөлмөрч зан, бүр эрүүлмэнд сайтай байх явдал ч ордог. Бид эдгээр зүйлдээ бусад үндсэн хөрөнгөд хөрөнгө оруулдгийн адилаар өөрсдийгөө улам бүр бүтээмжтэй болохын тулд хөрөнгө оруулдаг.

Тиймээс л бид өөрсдийгөө бүтээмжтэй болгоход хэрэгтэй нийгмийн болон практик чадварт суралцах гэж сургууль, коллеж, сургалтын курсэд явдаг. Бидний хувьд олох боломжтой орлого юуны түрүүнд чухал байх боломжтой ч гэсэн хэрэв бид илүү бүтээмжтэй байвал бид ерөнхийдөө илүү их орлого олж чадна. Ажил олгогч шинэ ажилтнаа тэдний техник төхөөрөмж, мэдээллийн системийг хэрхэн ажиллуулахад зааж сургах гэж цаг хугацаа болон мөнгөөрөө хөрөнгө оруулна. Гэр бүлүүд хүүхдүүдээ дэг журамтай, шударга, итгэл даадаг, нягт нямбай байхад, мөн ажил бизнесийнх нь ирээдүйн төлөвийг адилхан сайжруулах бусад үнэ цэнэд сургадаг. Өөрсдийнхөө эрүүлмэнд болон биеийн ерөнхий чадвартаа хөрөнгө оруулснаар бид илүү урт хугацаанд илүү бүтээмжтэй байх боломжтой.

Энд дахиад л зах зээл бидэнд өөрсдийнхөө бүтээлч чадвараа хамгийн их болгоход тусалдаг. Эдгээр зүйлд мэргэжил олж авдаг коллеж, ур чадвараа хөгжүүлдэг курс, бидний чадвар болон хувийн чанарыг бидэнд хамгийн сайн тохирсон ажлын байр руу зуучилдаг ажлын байрны зуучлагч газар, эрүүл байхад тусалдаг фитнес клуб, бидний сэтгэлийн болон биеийн эрүүлмэндийг сэргээдэг эмнэлэг, эрүүлжүүлэх төвүүд багтана.

Эдийн засагчид уламжлал ёсоор хөдөлмөрийг газрын адилаар хөрөнгөөс ангид тусдаа ямар нэг зүйл гэж хардаг ч хүмүүний капиталын тухай санаа энэхүү ангиллыг хэтэрхий явцуу болгож харагдуулдаг. Хүмүүний капитал багаж төхөөрөмжийн адилаар

хөдөлмөрийг илүү бүтээмжтэй болгоно. Үнэндээ энэ нь хөрөнгийн бусад бүх төрлүүд хамтдаа байснаас ч илүү, бүтээмжид хамгийн чухал зүйл магадгүй байж болно. Бүр хэдийгээр ерөнхийдөө хөрөнгийг хүмүүсийн төлөөлж байснаас илүү өргөн хүрээнд өмчилдөг ч гэсэн хүн бүр хүмүүний капиталдаа өмчилдөг, ихэнхи хувь хүмүүс болон гэр бүл хүмүүний капиталд маш ихээр хөрөнгө оруулдаг гэдэг нь бодит баримт юм. Оргүйгээс амжилттай бизнес босгосон Астор, Карнегий эсвэл Проктер & Гамбл, Крафт, Дүпонтыг үндэслэгчид зэрэг цагаачдын амжилт боловсрол, ур чадвар, мөн юманд төвлөрөх, хөдөлмөрч байх зэрэг хувийн зан чанарын ач холбогдлыг нотлон харуулдаг. Ийм зүйл мөн Хонг Конг, Макао эсвэл Сингапурын эд баялгаас ч харагддаг — эдгээр улс хүн амынх нь үнэт зүйл, ажлын ёсзүйг эс тооцвол байгалийн нөөц маш багатай, жижиг газар нутагтай улс юм.

Гэсэн ч хүмүүний капитал цэцэглэж хөгжихөд зөв орчин нөхцөл хэрэгтэй. Ингэхийн тулд хүмүүс өөрсдөдөө болон гэр бүлдээ чөлөөтэй хөрөнгө оруулдаг байх, уг хөрөнгө оруулалтынхаа үр шимийг таашаан эдлэх эрхийг нь хүндэлдэг байх ёстой.

Тогтолцооны дэд бүтэц

Үндсэн хөрөнгийг яаж ашиглаж байгаа нь түүний ашиг тусын чухал хэсэг юм. Шинэ санаа гаргагч, суудлын машин үйлдвэрлэгч Хенри Форд (1863-1947 он)-ын ажилчид бусадтай л адилхан алх, эрэг тайлах түлхүүр эсвэл өргүүр хэрэглэж байсан; гэвч тэрбээр суудлын тэрэг хийдэг угсрах шугамд ашигладаг энэ үндсэн хөрөнгийг түүнээс өмнө хийдэг байснаас хамаагүй илүү бүтээмжтэй болгож зохион байгуулжээ. Зөв тогтолцоо бол хөрөнгийн чухал бүрдэл хэсэг юм.

Сүлжээ. Утасны сүлжээ, нийлүүлэлтийн сүлжээ, түгээлтийн тогтолцоо бол харилцаа холбоо болон түгээлтийн үр ашгийг ихээр нэмэгдүүлдэг энэхүү "зохион байгуулалт"-ын хөрөнгийн бусад хэлбэр. Интернет, интерактив ТВ, и-мэйл зэрэг мэдээллийн сүлжээ бидний бүтээмжийг мөн л өсгөдөг: бас үйлдвэрлэл болон солилцоог хөнгөвчлөхөөс гадна шинэ санаа, санаачилга болон шинэ, илүү

сайн бүтээмжтэй арга ажиллагаа олж нээх явдлыг тэтгэх замаар эдгээр нь үзэл санаа тархах явдалд тус хүргэдэг. Тэдгээр зүйл мөн л ажиллах илүү үр дүнтэй арга зам — жишээлбэл, гэр бүлүүдийг хүүхэд асрагчтай, аялагчдыг жолоочтой, байрны эздийг хоноглох газар хайж буй хүмүүстэй холбодог, "хамтран хэрэглэх эдийн засаг" (sharing economy)-ийн апп — санаачлах боломж олгодог.

Зах зээл. Зах зээлийн тогтолцоо капитализмтай адилхан зүйл биш. Гэвч бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, эсвэл хөдөлмөрийн салангид зах зээл нэг бүр бол маргаангүй хөрөнгийн нэг хэлбэр юм. Тэдгээр нь зүгээр нэг бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээ түгээх нийлүүлэх арга зам биш харин өөрсдөө байгаагаараа бүтээмжтэй зохион байгуулалт юм.

Хөрөнгийн бусад хэлбэрийн адилаар зах зээл хөгжиж цэцэглэхэд хөрөнгө оруулалт, мөн худалдан авагчид, бараагаа борлуулагчид, зуучлагчдын ажил хамаардаг харилцаа холбоо болон бусад тогтолцоог сахин хамгаалахад хэрэгтэй ёс журам боловсруулж гаргах, сахин хэрэгжүүлэх явдал шаардлагатай.

Зах зээл мөн илүүдэл болон хомсдолын талаархи мэдээллээр дамжуулан бүтээмжийг ихээр нэмдэг. Хэрэв олонд алдартай ТВ-ийн нэвтрүүлэг бичлэгийг нь хийсэн газарт зочилж очихыг хүсдэг хүмүүсийг улам олон болгосон бол жишээлбэл жуулчлалын газар хүмүүсийг тийш аялуулахын тулд тэднээс илүү их үнэ нэхэж болохыг олж мэдэх болно. Энэ жуулчлалын газар тэр газарт хүрэх илүү их нислэг, галт тэрэг, эсвэл автобусыг ашиг багатай бусад чиглэлээс татан авч захиална. Нэмж хэлэхэд зочлон очигч хүмүүсийн тоо нэмэгдсэнээр орон нутгийн ресторан, кофе шоп үнээ өсгөх, шинэ салбараа нээхэд өдөөдөг; энэ үед нутгийн хүмүүс өөр ажил хийхээс илүүтэй үйлчлэгч, зөөгчөөр ажиллавал илүү их орлого олох боломжтой гэдгийг олж мэднэ. Эдгээртэй адилхан үнийн дохиогоор дамжуулан үйлдвэрлэл болон хөрөнгийг хамгийн их үнэ цэнэтэй хэрэглээ рүү үр дүнтэйгээр, автоматаар замчилж чиглүүлнэ.

Үнэндээ зах зээлийн үнэ энэ гараг даяар тоо томшгүй хувь хүмүүсийн үйл ажиллагааг уялдуулж зохицуулдаг. Бүр 1776 онд Адам Смит бүр жирийн ноосон хүрэм үйлдвэрлэхэд маш олон хүн

оролцдог гэж ярьж байлаа. Үүнд: хоньчин, утас ээрэгч, даавуу нэхэгч, будагч, худалдаачин, далайчин, усан онгоц баригч, багаж үйлдэгч, өөр бусад олон хүн орно. Гэвч энэ бүх хувь хүмүүсийн аль нь ч тодорхой үйлчлүүлэгчид зориулж, тодорхой хүрэм үйлдвэрлэх гэж зорьдоггүй: тэд зүгээр л хүчин чармайлтыг нь хаана хамгийн сайн хэрэглэх боломжтой байгааг мэдээлдэг зах зээлийн үнэд л хариу үйлдэл хийдэг. Хэрэв хэрэглэгчийн эрэлт (эсвэл, үүнээс улбаалаад үйлдвэрлэлийн технологи) өөрчлөгдвөл үнэ мөн өөрчлөгдөх бөгөөд шинэ дохио нийт сүлжээгээр дамжин тархаад шинэ бодит байдалд дасан зохицох гэсэн хүн бүрийг сэдэлжүүлнэ.

Иймэрхүү динамик (буюу байнгын хөдөлгөөнт) уялдуулж зохицуулах явцаар дамжуулан зах зээл үйлдвэрлэгч нэг бүрийн, тэдний ашиглаж буй үндсэн хөрөнгө нэг бүрийн бүтээмжийг ихээр нэмэгдүүлдэг. Зах зээл илүү их үнэ цэнэ бүтээдэг үйлдвэрлэгчид болон бодолтой төлөвлөгчдийг шагнаж урамшуулдаг, харин бүтээмж илүү муутай үйлдвэрлэгчдэд хүчин чармайлтаа өөр газар руу чиглүүлэх сэдэл төрүүлдэг. Ингэх үеэрээ зах зээл ашиглах нөөцийг мөн л хадгалж хямгадах болно — эцсийн дүндээ хэн ч цаг хугацаа, хүчин чармайлт эсвэл хөрөнгөө хэрэв түүнийг хаа нэг өөр газарт илүү сайнаар ашиглах боломжтой бол дэмий зарлагадахыг хүсдэггүй.

Хуульзүй болон соёлын хөрөнгө

Шударга ёс. Капитализм сайн дурын үйлдэл болон харилцан үйл хийхэд үндэслэдэг. Гэвч иймэрхүү харилцан зохицуулалт хэрэв хүмүүс чөлөөтэй үйл хийх, харилцан үйл хийх, төлөвлөгөө гаргах, итгэлтэйгээр хөрөнгө оруулах боломжтой бол л ажиллах бололцоотой. Тиймээс капитализмд хүмүүс хүчирхийлэл, хулгайд өртөхгүй эсвэл хуурч мэхлүүлэхгүй байх, мөн гэрээний амлалтаа биелүүлэх, "хувь хүний" эрх болон эрх чөлөөг хүндлэх явдлыг бататгадаг шударга ёсны тогтолцоо шаардлагатай байдаг.

Зах зээлийн адилаар шударга ёсны тогтолцоонд мөн хөрөнгийн актив буюу бүрдэл хэсгийн шинж чанар бий. Бид түүнд (хууль тогтоох

явц, цагдаа, шүүх, шорон гм.) их хэмжээгээр хөрөнгө оруулдаг бөгөөд энэ нь харьцангуй бат суурьтай байж, итгэлцлийг тэтгэн, улмаар капитализм жигд тогтуун ажиллах явдлыг баталгаажуулан биднийг илүү бүтээмжтэй болгодог.

Энэхүү бүрдэл хэсэг олон хэсэгтэй. Жишээлбэл шүүхэд маргаан шийдвэрлэдэг, арилжааны зан үйлийн хэм хэмжээг үүсгэж тогтоодог нийтийн хууль гэж бий; үүнд мөн шударга ёс зохих үйл ажиллагааг сахин хэрэгжүүлдэг, эрх мэдэлд байгаа хүмүүс үлдсэн бидэнтэйгээ адилхан хуулиар хязгаарлагддаг хууль ёс; төр засгийн эрх мэдэлд тавьдаг үндсэн хуулийн хязгаарлалт бүхий ардчилал болон бидний төлөөллийг сонгохтой холбоотой ёс журам багтана. Эдгээр бүх зүйл итгэлцэл, тодорхой байдал, аюулгүй байдлыг тэтгэх бөгөөд үүнээс улбаалаад өмнөх ажлаа төлөвлөх, хөрөнгө оруулах, зах зээлийн арилжааг хялбарчлах явдлыг нөхцөлдүүлж сайжруулан шударга ёсыг бидний бүтээмжийг ихээр нэмэгдүүлдэг хөрөнгийн актив буюу бүрдэл хэсэг болгодог.

Өмчийн эрх. Хүмүүс хэрэв тэд үүнийгээ өмчилнө, мэдэж хянана, мөн бүтээсэн зүйлээсээ ашиг тус олно гэж мэдэж байвал хөрөнгө оруулах, үндсэн хөрөнгө бүтээх илүү магадлалтай байдаг. Иймээс бидний өмчийн эрх гэдэг өмчлөл болон өмч хэрэглэх талаархи хуульзүйн ёс журам, нийгмийн уламжлал харьцангуй тодорхой ойлгомжтой, тогтвортой байх ёстой. Гэвч бид эдгээрийг үргэлж ойлгомжтой тодорхой байлгадаггүй (жиш. та нарын өмч дээгүүр онгоц нисэхийг зөвшөөрдөг үү: хэрэв тийм бол ямар өндөрт нисэх вэ?). Эдгээр эрх нөхцөл байдал болон бодол санаа өөрчлөгдөхөд дагаж өөрчлөгддөг (жиш. та нарыг каннабистай байх, түүнийг зарахыг зөвшөөрдөг үү?). Гэлээ гээд харьцангуй зөн совингийн шинжтэй, тогтвортой байснаараа эдгээр ёс журам итгэлцэл, бүтээмжийг тэтгэнэ.

Оюуны өмч — худалдааны тэмдэг, зохиогчийн эрх, патент — бол хугацаагаар хязгаарлагддаг өмчийн тусгай төрөл юм. Үүний цаад нь санаа хөрөнгө оруулагчид, зохиогчид, үнэ цэнэтэй брэнд бий болгосон бусад хүн өөрсдийнхөө гаргасан хүчин чармайлтын үр шимийг таашаан эдлэх явдлыг бататгаж баталгаажуулах явдалд

оршдог - энэ нь бусад шинийг эрэлхийлэгчдэд үүнтэй адилхан зүйл хийх урам зориг өгдөг учраас бид бүгд түүнээс ашиг тус хүртдэг. Гэвч бизнесийн газар, эсвэл хүний өв залгамжлагч, түүнийг залгамжлагчид уг бүтээгдэхүүн эсвэл шинэ бүтээлийн монополь эрхийг мөнх эдлэх зөвшөөрөл байх ёсгүй: бид үзэл санаа хөгжиж цэцэглэх, түгж тархахыг хүсдэг. Тиймээс бид эдгээр хамгаалалтыг хугацаагаар хязгаарладаг. Дэлхий даяар ёс журам яг нарийндаа өөр өөр байж болох ч харин ерөнхий зарчмыг хүндэлж дагадаг явдал одоо ч итгэлцэл, бүтээмжийг тэтгэсээр л байна.

Соёл болон ёс суртахууны уламжлал. Харилцан биесээ хүндлэх, өргөн хүрээнд харилцан зөвшөөрсөн үнэт зүйлстэй байх, итгэлцэх, бусдын эсрэг хүч хэрэглэхийг нийтээрээ эсэргүүцдэг соёл капитализмд тус болдог бөгөөд түүний хүрч чадсан тэр бүтээмжид ч нэмэр болсон. Эдийн засгийн туршилт судалгаа капитализм болон дээрхи соёл харилцан биесээ хүчирхэгжүүлдгийг харуулдаг: зах зээл сайтар үүсэж тогтсон газрын хүмүүс зах зээл тийм ч чухал биш байдаг газрын хүмүүсийг бодвол нэг нэгэндээ илүү их итгэх хандлагатай байдаг; итгэлцэх соёл жам ёсоороо арилжаа худалдааг хялбар болгоно.

Жижиг, нэгэн жигд бүтэцтэй нийгэмд итгэлцэл цаанаасаа тогтчихсон байдаг байж болно. Гэвч хүн ам нь олон янз байдаг ихэнхи газарт итгэлцэл зуу зуун жил дамжин бий болдог. Ингэхийн тулд капитализмд ажиллах боломж олгодог үнэт зүйлс болон институтүүдэд хөрөнгө оруулах шаардлагатай. Нэгэнт бид бүтээж бий болгох гэж хөдөлмөрлөх ёстой ийм соёл харьцангуй тогтвортой, бидний бүтээмжийг их нэмэгдүүлдэг зүйл тул энэ нь байгаа байдлаараа капитал буюу хөрөнгийн хэлбэртэй маш адилхан харагддаг.

Дүгнэлт

Хөрөнгийг яг нарийн хэрхэн тодорхойлох явдал маргаантай байж болно. Гэвч хөрөнгө хэдхэн хүн өмчилдөг үйлдвэрийн газар, хүнд машин механизм, усан онгоц, санхүүгийн активаар хязгаарлагдахгүй

гэдэг нь ойлгомжтой. Энэ бол хамаагүй ардчилсан шинжтэй зүйл юм. Бид бүгдээрээ гэр орон, дэлгүүр, албан байрандаа үндсэн хөрөнгө ашигладаг. Бид банк болон санхүүгийн санд мөнгөө хадгалуулдаг бөгөөд энэ нь эргээд бүтээмж ихтэй аж ахуйн нэгжүүдэд хөрөнгө оруулалт болж очно. Бид хувийн сүлжээ, хувийн эд баялаг ашиглаж бүтээсэн олон нийтийн сүлжээ ашигласнаар улам л бүтээмжтэй болдог.

Бид бүтээмжид өөрийн хувь нэмрээ оруулдаг зах зээл болон бусад тогтолцоо ашигладаг бөгөөд итгэлцлийн соёлыг сахин хамгаалахыг чармайдаг. Энэ бүгдийн дундаас бид бүгдээрээ өөрийн гэсэн хүмүүний капиталтай: энэ бол бидний мэдлэг, ур дүй, чадвар. Бид бүгдээрээ хөрөнгөтнүүд бөгөөд хөрөнгө бол маш олон янз байдаг, маш ардчилсан шинжтэй зүйл юм.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: Хөрөнгийг Хэрхэн Бүтээдэг вэ

Капитализмыг ойлгохын тулд хөрөнгийн зам мөрийг ухаж ойлгох нь чухал: хөрөнгө зүгээр л оршин байдаггүй, түүнийг бүтээх ёстой, түүнийг хялбархан алдах эсвэл устгах боломжтой, түүнийг сахин хамгаалах чармайлт гаргах ёстой. Эдгээр зүйлийн талаар төөрөгдөл капитализмыг өөрийг нь шүүмжилсэн, байгаа оноогүй асар олон шүүмжлэл гарахад хүргэдэг.

Хөрөнгө хэрхэн олж авдаг тухай алдаатай үзэл санаа

Олон шүүмжлэгч хөрөнгийг зөвхөн бусдын шаргуу хөдөлмөрөөс л хулгайлах замаар олж авах боломжтой гэж үздэг нь харагддаг. Тэд ажил олгогч ажилчдынхаа бүтээсэн үнэ цэнийг хууран мэхэлж хөрөнгөтэй болдог гэж батлан өгүүлнэ. Эсвэл тэд үндэстнүүд дайн хийж, эзлэн түрэмгийлсэн хүмүүсийнхээ бүтээлийг олзлон хөрөнгөө бүрдүүлдэг гэж зарлан мэдэгддэг. Эсвэл тэд улстөрийн кронизмоо ашиглах замаар хэрэглэгчдээ хууран мэхлэх монополь байдал үүсгэдэг гэж корпорацуудыг харна. Өөрөөр хэлбэл капиталистууд буюу хөрөнгөтнүүд хууран мэхлэх, дайн өдөөх эсвэл бусдаас булаах замаар л хөрөнгөтэй болдог гэнэ. Энэ төсөөлөл бол ийм гэмт хэрэг үйлдэж олж авсан хөрөнгө тэдэнд л үлдэнэ, тэд ч ямар нэг хүчин чармайлт гаргахгүйгээр байнга түүнээс үр өгөөж хүртдэг гэсэн үг юм.

Эдгээр санаа нэг бол буруу, эсвэл дор хаяж хоцрогдсон зүйл. Хөрөнгийг хүчээр булаах замаар байнга олж авдаг тийм цаг үе байсан: нэг улс нь нөгөөгөө эд баялгийг нь олзлон авах гэж эзлэн түрэмгийлнэ, дараагаар нь эзлэгдсэн хүмүүсийн хөдөлмөрөөр

амьдарцгаана; язгууртнууд зарц нараа мөлжих боломжтой; эзэн хаад өөрсдийнхөө найзуудад асар их өгөөжтэй монополь эрх батлан олгодог байв. Гэвч ийм зүйл хүмүүс өнөөдрийг бодвол үгээгүй ядуу байсан, өөрийн гэсэн үндсэн хөрөнгө олж авах чадалтай нь ховор байсан, капитализмын өмнөх цаг үед болж байжээ. Өнөөдөр хөгжингүй улсуудад хүч хэрэглэх явдал хууль бус зүйл бөгөөд бусдыг албадаж хүчлэхгүйгээр эв найртай арга замаар хөрөнгөө бүтээх ёстой. Хөрөнгө төлөө нь тэмцэлдэх эсвэл хулгайлж авах ховор өмч байхаа аль хэдийнээ больсон: одоо хөрөнгө хамаагүй хүртээмжтэй болж, дэлхийн илүү чинээлэг хүн ам өргөн олноороо түүнийг өмчилдөг болжээ. Хөрөнгө олж авах цор ганц, хууль ёсны дагуухь арга зам бол түүнийг бусдаас булааж авах биш харин өөрөө үүнийг бүтээх явдал юм.

Хөрөнгө бол байнгын өмч гэж үздэг, мөн модноос алим унаж буй адилаар өмчийн эзэндээ ямар ч хүчин чармайлтгүйгээр ирэх олз омог тасралтгүй өгдөг гэсэн үзэл санаа буруу зүйл. Үнэндээ хөрөнгөө хадгалж үлдэхэд цаг хугацаа, мөнгө хөрөнгө, хүчин чармайлт хэрэгтэй. Түүнийг арчилж тордож, бусдаас хамгаалах ёстой. Өөрчлөгдөж буй, өрсөлдөөнтэй ертөнцөд хөрөнгийн үнэ цэнийг хэвээр хадгалахын тулд түүнийг үргэлж шаргуу, нягт нямбай ашиглах учиртай. Бүр жимсний модыг ч тарьж ургуулах, бордох, услах, шүрших, арчлах, аажимдаа тариалангаа хэвээр хадгалахын тулд түүнийг шинээр солих ёстой болдог. Бүр дараа нь жимсээ хураах, мөн хэрэглэхийн тулд, жишээлбэл, дэлгүүрт хүргэж өгөх эсвэл ундаа болгож боловсруулах ёстой. Хэрэв эдгээр ажлын алийг нь ч хийгээгүй бол жимсний тариалан үнэ цэнэтэй байхаа больж, зүгээр л хэрэгцээгүй зүйл болон атаршина: хөрөнгө биш харин хог болно.

Дахиад л шүүмжлэгчид үнэндээ хөрөнгө (болон капитализм) хэр зэрэг индивидуалист-шинжтэй, ардчилсан болохыг олж хардаггүй. Капитал буюу хөрөнгө зүгээр л оршин байдаггүй харин түүнийг бүтээдэг. Өнөөдөр цөөхөн хүн биш харин олон хүн хөрөнгө бүтээж, өмчилж байна. Түүний үнэ цэнэ тэр хүмүүс юу үнэндээ бүтээдэг, хэрхэн үүнийгээ хамгаалдаг, арчилж торддог, хэрэглэдгээс

хамаардаг.

Хөрөнгөө хадгалах амаргүй

Хөрөнгийг тун хялбархаан — эрсдэл, буруу үнэлэлт дүгнэлтээс болж, мөн хэрэглэж, эсвэл хүчирхийлэл, татвараас болж — алдах боломжтой.

Эрсдэл болон тодорхойгүй байдал. Бидний хэн ч ирээдүйг тодорхой болгон, таамаглаж чадахгүй. Хэн ч бидний хүчин чармайлтыг талаар нэг болгоно гэж бодоогүй зарим үйл явдалд тааруулж төлөвлөгөө гаргаж чадахгүй. Бүр бид ирээдүйд бидэнд юу тохиолдохыг нэлээд итгэлтэйгээр мэдэж байгаа, амжилт гаргах эсвэл бүтэлгүйтэх магадлалаа нямбай тооцоолж байгаа ч гэсэн бидний буруу болохыг батлах эрсдэл байсаар л байна.

Тиймээс л бид үндсэн хөрөнгө бүтээх гэж цаг хугацаа, хүчин чармайлт эсвэл мөнгөөрөө хөрөнгө оруулах үедээ эрсдэл үүрч байдаг. Ирээдүйн үр дагаврын талаархи бидний үнэлэлт дүгнэлт буруу байх боломжтой: бидний хөрөнгө оруулалт бидний бодож байснаас бага өгөөжтэй байх боломжтой эсвэл бүр алдагдал хүлээж болно. Жишээлбэл, та нар хамгийн сүүлийн үеийн технологитой пиццаны ресторан нээж болох ч хэрэглэгчид тань өрсөлдөгчийн чинь пиццаг илүү үздэг эсвэл үүний оронд ногооны салат иддэг болсныг олж мэдэж ч болох юм. Хэрэв юмс жинхэнээсээ муу болбол та нар хөрөнгө оруулалтаа үргүй зардал гэж үзэн, үндсэн хөрөнгийн тоног төхөөрөмжөө хаяад бизнесээ хаахаас аргагүй болж болно.

Хэрэв хүмүүс аж ахуй эрхлэх явдлын эрсдэл өндөр гэж бодвол тэд ирэх өгөөж нь маш их байна гэж үзсэн үедээ л хөрөнгө оруулна. Гэвч урт хугацаандаа бүр дунд зэргийн эрсдэл ч хүмүүсийн үндсэн хөрөнгийг үгүй хийх боломжтой. Энэ бол хөрөнгө нэг хүнд яагаад мөнх байдаггүйн өөр нэг шалтгаан юм. Тавин жилийн өмнөх, таарсан нэг сэтгүүлээ аваад зар сурталчилгааг нь харна уу: та нарын таньдаг компаниуд байх аваас тэдгээр нь маш цөөхөн л байх болно. Тэр үеийн бизнесийн ихэнхи нь илүү шинэ, илүү сайн эсвэл илүү хямд зүйл санал болгосон өрсөлдөгчдөөсөө болж, бизнесээсээ шахагдсан

байдаг. Гэр бүлийн бизнесүүд ч гэсэн хуучны зүйр үг болох "цамцтай эхлээд дахиад цамцтайгаа үлдэхэд хүний 3 үе болдог" гэсэн зүйр үгийн адилаар ийм л тавилантай: нэг хүн бизнесээ үүтгэж эхлүүлнэ, хүүхдүүд нь өвлөж аваад ажиллуулна, харин бизнес хийх санаагүй ч мөнгө мэддэг болсон ач зээ нь түүнийг үгүй хийнэ.

Хэрэглээ. Үрэлгэн байдал хөрөнгийг үгүй хийдэг — хөрөнгийг хэрэглэж идэж ч болно, бас эрсдлээс болж алдах ч боломжтой. Жишээлбэл, гэр бүлийн бизнесийн эзэн шинэ үндсэн хөрөнгөд хөрөнгө оруулахгүйгээр харин зүгээр л өөртөө элбэг дэлбэг цалин өгөх гэж түүнийгээ барьцаалж зээл авах эсвэл эд хөрөнгүүдээ зарж болно. Эсвэл үүсгэн байгуулагчид нь хүүхдүүд болон ач зээ нартаа туслах гэж итгэлцлийн сан буюу траст сан байгуулах ч боломжтой — эд бол ирээдүйнхээ төлөө ажиллах гэж зүтгэхийн оронд уг хөрөнгийг зүгээр л ('трастафар' байр байдлаар буюу баян өв залгамжлагчдын адил) идэж дуусгадаг хүмүүс юм. Эдгээрийн аль ч арга зам гэр бүлийнхээ хөрөнгийг хэрэглэж дуусгана. Тун удахгүй тэд буцаад л цамцтайгаа үлдэнэ.

Хүчирхийлэл. Мэдээжээр хөрөнгөө хулгай эсвэл хууран мэхлэлтэд алдах эсвэл хүчирхийллийн улмаас сүйтгүүлэх боломжтой. Эдгээр үйлдэл ёс суртахуунгүй үйлдэл, хохирогчдод хохирол учруулахаас гадна хүн бүрд зардал чирэгдэл болно. Тухайн гэмт хэргийг мөрдөн шалгах, түүний төлөө шийтгэхийн тулд тодорхой нөөц зарцуулах ёстой болдог. Бүр хэрэв уг гэмт хэргийг шийтгэхгүй орхисон ч гэсэн хөрөнгө хүчээр булаан авсан хүн түүнийг нарийн нямбай бүтээдэг, бас хамгийн үр өгөөжтэй зорилгод хэрэглэхэд анхаарал тавьдаг, удирдаж чиглүүлдэг, хэрэглэдэг тэр хүмүүсийг бодвол тухайн хөрөнгөөс илүү бага үнэ цэнэ гарган авах бөгөөд энэ нь нийт нийгэмд алдагдал болно.

Хүчирхийллийн хамгийн аймшигт хэлбэр бол дайн юм: бидний харсанчлан капитализмын зарим шүүмжлэгчид дайн хүчтэй нь хүчгүйгээсээ өмч хулгайлах боломж олгодог гэж боддог. Бусад нь бизнес эрхлэгчид тэд хэрэгцээтэй байгаа усан онгоц, нисэх онгоц, цахилгаан хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, зэр зэвсэг бүгдийг нь нийлүүлж ашиг хүртдэг учраас зүгээр л дайн (дайн өрдөх)-д

дуртай гэж батлан мэдэгддэг. Гэвч үнэндээ бизнесүүдээс болж дайн эхлэх боломжгүй. Зөвхөн засгийн газрууд л тулган шаардах эсвэл цэрэг хөдөлгөх эрх мэдэлтэй. Бизнес эрхэлдэг хүмүүст дайн ямар ч хэрэгцээгүй зүйл бөгөөд тэднийг маш ихээр хохироодог гэдгийг тэд мэддэг: дайн (бизнес явуулах зардал өсгөдөг) эрсдэл нэмэгдүүлнэ, хэрэглэгчийн ирээдүйн итгэлийг бөхөөж, хэрэгцээг нь үгүй хийнэ, хөрөнгө, үүн дотроо биет эд бараа, тогтолцоо, хүмүүний капиталыг устгана. Энэхүү илэрхий үнэн одоо яагаад маш цөөхөн ардчилсан улс наймаа хийдэг улсуудтайгаа дайн хийдгийг шалтгаан юм. Өнгөрсөн зуунуудад дайн хийх явдал бусад улсуудын хөрөнгийг булаан авах сайн арга зам байсан байх боломжтой; өнөөдөр бид хөрөнгийг бусдаас булаан авахаас түүнийг бүтээх нь илүү хялбар, илүү аюулгүй, илүү үр өгөөжтэй болохыг мэддэг болжээ.

Татвар. Хөрөнгийг эд хөрөнгө (wealth tax, манайд үүнийг үл хөдлөх хөрөнгийн татвар гэдэг) эсвэл орлогын татвар зэрэг төрийн арай аядуу үйл ажиллагаагаар устгах боломжтой.

Жишээлбэл, ядууст туслах, "баячууд"-ыг олон нийтийн үйлчилгээнд илүү хувь нэмэр оруулдаг болгох гэсэн нэрээр засгийн газар хөрөнгийн бүх хэлбэрт 10 хувийн татвар ногдуулжээ гэж бодъё. Бизнес босгох эсвэл түүнийгээ өргөжүүлэх гэж боддог хүмүүс одоо бизнесээ явуулахад тэдэнд шаардлагатай үндсэн хөрөнгө — барилга байгууламж, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, санхүү — бүгд 10 хувиар үнэтэй болсон болохыг олж мэднэ. Энэ явдал тэднийг бизнесээ хөгжүүлэх сэдлийг нь бууруулна. Тэд мөнгө болон хүчин чармайлтаа аж ахуйдаа зориулж эрсдэл гаргахаасаа өмнө бизнес нь амжилттай байх явдалд итгэлтэй байх ёстой. Тэд мөн үндсэн хөрөнгөө бүтээх, өргөжүүлэх эсвэл солихдоо хойрго болно. Үр дүнд нь бүтээлч чадвар гээгдэж, нийт нийгмээрээ бага зэрэг ядуурна.

Үүнтэй адил зүйл ерөнхийдөө эд хөрөнгөд татвар оногдуулахад гардаг. Хүмүүс мөнгөө бүтээлч бусаар сул хадгалах, эсвэл өнөөдрийнхөө таашаалд зориулж зарж үрж ч болно. Гэвч тэд эд хөрөнгөө бүтээмжтэй үндсэн хөрөнгөний зүйл болгож хувиргахаар болбол түүнийгээ нарийн нямбай байдлаар тэр зорилго руугаа

чиглүүлэх шаардлагатай болдог. Бид хүмүүст хүчин чармайлтынхаа үр шимийг бүрэн хүртэх боломж олгож үүнийг дэмжих боломжтой. Гэвч эд хөрөнгөд татвар оногдуулбал гарч болох үр шим багасаж, гарах эрсдэл нэмэгдэнэ. Үр дүнд нь хүмүүс эд хөрөнгөө үр өгөөж багатайгаар хэрэглэдэг болж, санхүүгийн сан нь үрэн таран болж бутран, хөрөнгөөрөө бүтээлч байдлыг нэмэгдүүлэхийн оронд түүнийг зарж үрнэ. Үүнээс бүгд хохирдог.

Дахин-хуваарьлалт. Дахин-хуваарьлалт бол хөрөнгө устгах өөр нэг бодлого юм. Хөрөнгийг бүтээмжийг нь хорогдуулахгүй эсвэл үгүй хийхгүйгээр бусдаас авах, бусдад өгөх боломжгүй. Хөрөнгийн бүтээлч байдал энэ хөрөнгө юу болох, энэ нь хаана байна, хэрхэн түүнийг удирдаж залж байна, бүр чухал нь энэ нь бусад өмчтэй хэрхэн нэгдэж нийлдэг вэ зэрэг олон зүйлээс хамаардаг. Жишээлбэл, бүтээгдэхүүн хүргэж өгөх нарийн нийлмэл сүлжээ хэрэв тээврийн зарим машиныг нь бусад газрын хэрэглээнд хүчээр татан авбал гарцаагүй гацаж, доголдоно.

Энэ байдлыг фермүүдийг өмчлөгчдөөс нь булаан авсан, газар болон тоног төхөөрөмжийг бусад хүмүүст дахин-хуваарилан өгсөн улс орнуудаас харах боломжтой. Нэгдмэл тогтолцоо болон хөрөнгийн бүтэц эвдэрч задарвал дийлэнхидээ л ургац муудаж, хүнсний дутагдалд ордог. Хятадуудын туршсан газар тариалангийн хамтралын аж ахуй аймшигт сүйрлийн үр дагаврыг энэ улс хувийн өмчлөлд илүүтэй түшиглэсэн, хөдөө аж ахуйн "гэр бүлийн хариуцлага" (family responsibility)-ын шинэ тогтолцоо нэвтрүүлэн байж илааршуулсан.

Монополийн эсрэг тогтоол шийдвэр. Том компаниудын монополь-шинжтэй хүч чадлыг хязгаарлах зориулалттай хууль мөн л хөрөнгийн сүлжээнд сүйтгэх нөлөө үзүүлэх боломжтой. Нээлттэй, өрсөлдөөнт эдийн засагт компаниуд албадлага эсвэл кронизм ашиглаж биш харин зөвхөн хэрэглэгчдэд тэдний үнэлж үздэг зүйлийг нь өгч л өсөж томрох боломжтой байдаг. Компаниудын өсөлт тэдний амжилтыг илэрхийлнэ. Зах зээлд хязгаарлалт тавих явдал бол олон нийтэд хамгийн их үнэ цэнэ өгөх гэж хөрөнгөө ашиглаж боломжтой компаниудад ийм зүйл хийхийг нь хориглоно,

хөрөнгө үр өгөөж илүү муутай үйлдвэрлэгчид рүү урсана гэсэн үг юм.

Гэвч ийм явдал болохоос ч өмнө олон нийт үүнээс болж хохирох боломжтой. Тодорхой пүүс хэзээ зах зээлд "давамгай" болохыг, мөн түүний том хэмжээ нь хэрэглэгчдэд хүргэж буй үнэ цэнийнх нь илрэл үү, эсвэл тэдэнд учирч буй аюул занал уу гэдгийг тодорхойлох маш хэцүү. Тийм учраас монополийн эсрэг гаргах хууль-тогтоогчдын шийдвэрийг пүүсүүд урьдаас таамаглахад хэцүү байдаг. Иймээс тэдгээр компани жижиг хэвээр үлдэхээр шийддэг бөгөөд тэдгээрийн үр ашигтай байдлаас гаргах боломжтой өгөөж гээгдэнэ; эсвэл тэд томрох ч гэсэн хожим нь тэдгээрийг засгийн газрын хяналтын байгууллага задалж, хөрөнгийнх нь сүлжээ бутран үр дүнд нь хэрэглэгчдээ алдах болно.

Бидний харсанчлан бүр хамгийн том пүүсийг ч гэсэн бусад том компаниуд эсвэл бусад компаниудын нэгдэл эсвэл бүр жижиг пүүсүүд бизнесийнх нь янз бүрийн хэсгийг зах зээлээс булаан авч аюулд оруулж байдаг. Тиймээс л капитализмын олон дэмжигчид засгийн газрын аливаа бодлого олон нийт мэддэг, амжилттай яваа үйлдвэрлэгчдэд дур зоргын хэмжээний хязгаар тавихаасаа илүүтэй зах зээлийг илүү нээлттэй болгоход анхаарал хандуулах ёстой гэж батлан өгүүлдэг.

Хөрөнгө хүмүүний үнэлэлт дүгнэлтээс хамаардаг

Шүүмжлэхдээ гээгдүүлдэг, хөрөнгийн ардчилсан эсвэл индивидуалист мөн чанарын өөр нэг шинж бол хөрөнгө хүмүүн бодгалиас тусдаа, дангаараа оршин байдаггүй явдал юм. Зүгээр л нэг үнэ цэнэгүй зүйл биш харин үндсэн хөрөнгө байхын тулд эд юмс заавал хүмүүний хэрэгцээ, хүсэл, үнэ цэнэд үйлчилдэг байхаар бүтээгдсэн байх ёстой. Хүмүүн түүнээс бүтээмжийнх боломжийг — жишээлбэл, байшин барих эсвэл үр тариа бутлах боломжийг нь — олж мэдэх хүртэл чулуу зүгээр л чулуу байна. Үүний дараа л чулуу хөрөнгө болдог. Ураан гэдэг эрдсийг бид түүгээр хэрхэн цөмийн эрчим хүч үйлдвэрлэж болохыг олж нээх хүртэл хэрэггүй (үүнээс

улбаалаад үнэ цэнэгүй) эрдэс гэж нийтээрээ боддог байсан. Одоо урааны уурхай хөрөнгийн үнэ цэнэтэй актив буюу бүрэлдэхүүн хэсэг болсон.

Гэвч хэрэв хүмүүн бодгаль ямар нэг хэрэггүй эд зүйлийг хөрөнгийн гарцаагүй бүтээмжтэй бүрэлдэхүүн хэсэг буюу актив болгож хувиргадаг байхад тэдэнд үүнийгээ өмчлөх эрх шаардлагатай байдаг. Тэд хөрөнгөө өмчилж, хянаж удирдаж чадна, мөн хэрэглээнээс нь ашиг тус хүртэнэ гэсэн итгэлтэй байх ёстой. Хэдхэн жилийн өмнө Перүгийн эдийн засагч Хернандо Де Сото (1941онд төрсөн) Перү улсын хамгийн ядуу олон хүн гэр орноо барьж, хэсэг газарт тариалан эрхэлдэг хэрнээ эдгээр зүйлээ хуульзүйн дагуу өмчлөх эзэмших эрхгүй учраас хөрөнгө гэж тэдгээрээ үзэж чаддаггүй гэдгийг цохон тэмдэглэж байв. Тэрбээр үүнийг өөрчлөх гэж ухуулгын ажил явуулсан: одоо тэдний зарим хувийн аж ахуйтан хуульзүйн дагуухь өмчлөх эрхтэй болж, гэр орноо газар болон тоног төхөөрөмж худалдан авахдаа зээлийн барьцаа болгох боломжтой болжээ. Тэдний өмчлөх эрх нэгэнтээ үнэ цэнэгүй байсан газрыг баталгаатай, үнэ цэнэтэй зүйл болгож, тэр хүмүүст хөрөнгөө улам бүр үр өгөөжтэй болгохоор хөрөнгө оруулах түлхэц болдог.

Өмч эзэмших эрх, өмчлөлийн хуульзүйн статус, корпорац оршин тогтнох боломж олгосон хууль, дүрэм журмын зохицуулалт, зах зээлийн соёл зэрэг үзэл санааг Өрнөдийн хөгжингүй улс орнуудад нийтээр мэддэг болсон тул эдгээрийг бараг л анзаардаггүй. Бас өмчийн эрх орших боломжгүйгээр эрх чөлөөг маш их дарангуйлдаг, эдийн засгийн эрх мэдлийг ихээр төвлөрүүлсэн улс орнуудад ч гэсэн эдгээр зүйл үл харагддаг. Гэвч иймэрхүү эрхүүд бол ашиглах нөөцийг үр өгөөжтэй хэрэглэхэд амин чухал байдаг, хөрөнгийн хуульзүй болон соёлын актив буюу бүрэлдэхүүн хэсэг юм.

Хөрөнгийн жинхэнэ үүсэл гарал

Өмчийн эрх, хуульзүйн тогтолцоог бүтээх явдал тиймээс эд зүйлийг хөрөнгө болгох чухал арга зам бөгөөд эдгээр тогтолцоог сахин

хамгаалах нь капитализмд маш чухал. Гэхдээ юмсыг цаг хугацаа, хүчин чармайлт зарж байж л хөрөнгө болгодог.

Жишээлбэл, та нар нүцгэн гараараа цөөн загас барьж чадна; гэвч та бүхэн саваа модыг уурга болговол эсвэл мяндас цуглуулж тор нэхвэл, эсвэл загасаар баян газар загасчлах завь хийвэл хамаагүй их загас барина.

Бүр эдгээр энгийн үндсэн хөрөнгийг бүтээхэд шаардлагатай мэдэгдэхүйц их цаг хугацаа, хүчин чармайлт хаанаас гардаг юм бол? Энэ бүхэн хэрэглээнээс үүдэж гардаг. Барьсан загас бүрээ даруй хэрэглэхийн оронд эдгээр бүтээмж-сайжруулах шинэ тоног төхөөрөмж бүтээх гэж ажиллах үеэр амь зуухын тулд нөөц үүсгэж гэж бага хэрэглэх (эсвэл загас барихад бага цаг зарцуулах) шаардлагатай. Энэ нь та нар хэрэглээгээ багасгана, цөөн загас иднэ эсвэл амрах хугацаа тань богино болно гэсэн үг.

Хэрэглэхээсээ татгалзах явдал бол хөрөнгө бүтээх үндсэн арга зам юм. Та нар мэдээж загасны хэрэгслээ хийх үедээ урьдын адил амьдрахын тулд хэн нэгнээс загас зээлдэж чадна; гэвч хожим нь ирээдүйд зарим хэрэглээгээ танахад хүрч зээлээ хүүтэй нь төлөх ёстой. Хэрэглэхээсээ татгалзах явдал (нэлээд цаг хугацаа, хүчин чармайлт шаарддаг өмчийн эрх, шүүх тогтолцоо, зах зээл болон тэдгээртэй адил зүйлсээс гадна) бол хөрөнгө бүтээх тогтвортой цор ганц арга зам юм.

Хөрөнгийг албадлагатай харьцуулбал

Хөрөнгө оруулж, хөгжиж дэвжихийн тулд хэмнэж хадгалдаг байх ёстой гэсэн санаа бол та нарын суралцаж мэдэх ёстой сургамж. Гэвч хүмүүс өмчийн эрх болон хуул ёсоор хамгаалсан, өөрсдийнхөө бүтээсэн капитал болон түүний үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг засгийн газрыг оруулаад өөр хэн нэгэн хүчээр булаан авахгүй эсвэл залилж хулгайлахгүй гэсэн итгэлтэй байсан тохиолдолд л хэмнэж хуримтлал үүсгэдэг.

Капитализмд өмчийн эрхийн аюулгүй байдал болон хууль ёс хөрөнгө бүтээх явдлыг хөхиүлэн дэмждэг бөгөөд үүнээс улбаалаад

нарийн төрөлжих явдлаар дамжуулан илүү их бүтээлч байдлыг тэтгэдэг. Энэ илүү их бүтээлч байдлаас үүсдэг бараа бүтээгдэхүүнээ сайн дураараа солилцох явдлаас үнэ цэнэ бий болно. Хөрөнгө бүтээх явдал, үнэн хэрэгтээ капитализм хэнийг ч мөлжихгүй, албадахгүйгээр үнэ цэнэ бий болгодог.

Хөрөнгө барьж бүтээх, өсөж томроход хууран мэхлэлт болон бусдын хүчирхийллээс ангид байх явдал амин чухал байдгийн адилаар төр засгийн бодлого мөн чухал байдаг. Хадгаламж, хөрөнгө оруулалт, орлогоос татвар авах явдал хүмүүсийг хадгалж хураах, хөрөнгө оруулах эсвэл үнэ цэнэ бүтээх санаачилгагүй болгодог. Дахин-хуваарилалт хийх нь бүтээдэг, арчиж хамгаалдаг, анхаарал хандуулдаг хөрөнгө оруулагчаас хөрөнгө татан авч ийм зүйл хийх дургүй эсвэл хөрөнгөө өнөөгийн хэрэгцээндээ бүхэлд нь үрж дуусгадаг (төр засгийн албан тушаалтнууд адил) хүмүүст өгдөг. Гэвч үүнээс гадна иймэрхүү бодлого үндсэн хөрөнгүүд нэгдэж нийлэн хамгийн их бүтээлч байдлыг бий болгодог хөрөнгө оруулалтын эмзэг сүлжээ — *хөрөнгийн бүтэц* (capital structure)-ийг — задалж сүйтгэдэг.

ТАВДУГААР БҮЛЭГ: Хөрөнгийн Бүтэц Яагаад Маш Чухал Вэ

Давамгайлж буй эдийн засагчид хэсэг бүр нь нөгөөтэй бараг л адилхан байдаг элс адил нэгэн жигд, нэг ижил бүтэцтэй зүйл гэж хөрөнгөтэй харьцдаг. Тэдний тооцоо, загвар, урьдчилсан таамагт тэнд ямар хөрөнгө хэр хэмжээгээр оршиж байгаад л анхаарал хандуулдаг.

Гэвч бодит байдал дээр хөрөнгө маш олон янз. Бүгдээрээ хоорондоо адилгүй, тодорхой үндсэн хөрөнгө (capital goods) байдалтай л зөвхөн оршдог: алх хадуураас авахуулаад суудлын тэрэг болон ачааны машин, хөвөнгийн үйлдвэр болон автомашины үйлдвэр, компьютер болон принтер, кассын машин болон хөлдөөгч, зээл болон бонд гээд олон зүйл бий. Үндсэн хөрөнгийн чухам ямар төрлийг ашигладаг, хэрхэн тэдгээрийг хэрэглэдэг, эдгээр нь яаж бусад үндсэн хөрөнгөтэйгөө сүлжилддэг зэрэг нь бүгд эдийн засгийн үр дагаварт гүнзгий нөлөөлдөг.

Энэ байдлыг үл ойлгох явдал ноцтой алдаанд хүргэнэ. Жишээлбэл, Францын эдийн заагч Тома Пикетти (1971 онд төрсөн) 2013 онд хэвлүүлсэн *Хориннэгдүгээр Зууны Хөрөнгө* гэсэн номдоо өгүүлсэнчлэн "хөрөнгийн өгөөж (return on capital)" гэж ярих нь утгагүй. Хөрөнгийг бүрдүүлдэг өөр өөр үндсэн хөрөнгө нэг бүр ондоо ондоо эрсдэлтэй, байж болох өгөөжтэй байдаг бөгөөд мөн хөрөнгөө хянаж удирдах янз бүрийн чадвартай, бас эдгээрээ ашиглах өөр өөр зорилготой янз бүрийн хүн өмчилдөг. Хөрөнгийн ондоо ондоо төрлийг алдах, хулгайлах, үрж дуусгах, хэрэглэх, татварлах эсвэл дүрэм журмаар зохицуулж дуусгах зэрэгт зарим нь бусдыгаа бодвол хялбархан байдаг тийм олон арга зам бий — энэ бүгд үндсэн хөрөнгөөс ирэх, байж болох өгөөжийг өөр

өөр арга замаар ондоо ондоо хувь хэмжээгээр идэж үгүй хийдэг. Үүгээр зогсохгүй мөн хэрэглэж буй үндсэн хөрөнгийн бүрдэл үргэлж өөрчлөгдөж байдаг: нэгэнтээ сүйх тэрэг, логарифмын шугам ашиглаж байсан бид өнөөдөр суудлын тэрэг, компьютер хэрэглэж байна. Иймээс л үндэстний хувьд тогтвортой "өгөөжийн төвшинтэй", өөрчлөгддөггүй, нэгэн-ижил бүтэц гэж байдаггүй.

Бүтээмжтэй бараа бүтээгдэхүүний сүлжээ

Үндсэн хөрөнгө нэг нэгтэйгээ хэрхэн ондоо ондоо байдлаар сүлжилдсэн байдаг явдал эдгээр хөрөнгө хэр олон байгаа, мөн тэдгээрийг бүтээхэд хэр их зардал гаргасан гэдгээс бүр илүү чухал. Нийлүүлэлтийн хэлхээ бүрэлдэхүүн хэсгүүдийг бүтээхэд ордог төрөл бүрийн орц хэрэглэгдэхүүн, дараагаар нь бидний хэрэглэдэг эцсийн бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээ үйлдвэрлэдэг олон улс орны ондоо ондоо асар олон үйлдвэрлэгчдээс бүрддэг байж, маш урт байх боломжтой.

Адам Смитийн жирийн ноосон хүрмийн жишээг харцгаая. Зөвхөн олон хүнээр зогсохгүй энэхүү эцсийн бүтээгдэхүүнийг нийлүүлэхэд үндсэн хөрөнгийн асар олон салаа мөчир нэгдэх нийлэх ёстой байдаг. Тэдгээрт дэлгүүр, жижиглэн худалдаа, агуулахын дэлгүүрийн тоног хэрэгсэл, бөөний худалдааны ачааны машин, үйлдвэрийн нэхэх болон оёх машин, будах үйлдвэр, утас ээрэгчийн ээрэх машин, хоньчдын хайч болон боогч машин, мөн эдгээр бүх хүмүүс хэрэглэдэг багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж хийдэг хайлуулах болон цутгах үйлдвэр, түүхий эд болон шат дамжлага бүрд хэрэглэдэг тоног төхөөрөмж, тээвэрлэгчийн усан, онгоц, нисэх онгоц, дээр нь нэмээд энэхүү энгийн өдөр тутам хэрэглэдэг эд зүйл нийлүүлэхэд бүгд хувь нэмэр оруулдаг өөр олон зүйлс багтана. Бүр тэгээд энэ үйл явцад ажиллаж буй олон хүний хоол, унд, орон байрынх нь хэрэгцээ, мөн үнэндээ тэр хүмүүсийн өөрсдийнх нь хувцсыг нь хангадаг олон хүнд шаардлагатай зүсэн зүйлийн үндсэн тоног төхөөрөмж (capital equipment)-гүйгээр энэхүү үйл явц амьдрах чадваргүй.

Шуудхан хэлбэл эдгээр үндсэн хөрөнгийн аль нэг нь байхгүй бол энэ нь үйлдвэрлэлийн үйл явцыг бүхэлд нь гацааж зогсоон, тухайн гинжин хэлхээний дагуухь бүх л үйл ажиллагаанд улам бүр хомсдол үүсгэж, нийлүүлэлт доголдуулан, тээвэрлэлтийг гацааж саатуулах боломжтой. Жишээлбэл, будах үйлдвэр байхгүй бол нэхэгч, эсгүүрчдэд будганд оруулсан ноос нийлүүлэх боломжгүй болж, цаашдаа хувцас хунар бөөний худалдаачин, жижиглэнгийн худалдаачин, хэрэглэгчид очиж чадахаа болино.

Үндсэн хөрөнгийн дэлхий-дэхний сүлжээ хамтдаа маш өргөн хүрээнд сүлжилдсэн байдаг учраас бараа бүтээгдэхүүн бүтээх бүтээмж болон үр өгөөжийг сахин хамгаалах, хөхиүлэн дэмжих нь маш чухал байдаг. Түүнд үйлдвэрлэлд хэрэглэдэг бараа бүтээгдэхүүн болон хэрэглэгчид очдог бараа бүтээгдэхүүн хоёулаа хамаарна – ноосон хүрэм зэрэг хэрэглээний бараа бүтээгдэхүүн гаргах нь бүхэлдээ энэ хүчин чармайлтын гол зорилго байдаг.

Тиймээс бидний бүтээмж зөвхөн бидэнд байдаг хөрөнгийн хэмжээ эсвэл үйлдвэр, машин техник, ачааны машин, багаж хэрэгслийн тооноос хамаардаггүй. Үндсэн хөрөнгө хамтдаа хэр сүлжилдсэн болохыг харуулдаг хөрөнгийн бүтэц бол бидэнд хэрэгтэй, бидний хүсэж буй бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээг хэрхэн бүтээх, мөн эдгээрээ хэр үр дүнтэй, бүтээмжтэйгээр үйлдвэрлэхэд маш чухал зүйл юм.

Хөрөнгийн бүтцийн хэврэг байдал

Хөрөнгийн бүтцийн амин чухал ач холбогдлыг хүмүүсээс хөрөнгийг нь үүгээр бүтээх үнэ цэнийг алдагдуулахгүйгээр булаан авах, бусдад түүнийг түгээх, эсвэл "илүү рационал буюу оновчтой" хэрэглээнд оруулах боломжтой гэж боддог улстөрийн зөнчид эсвэл эдийн засаг төлөвлөгчид голдуу л үл анзаардаг - үнэндээ тэд энэ хөрөнгө шинэ эздийн гарт илүү бүтээмжтэй болон, одоо байгаасаа илүү их үнэ цэнэтэй юмс үйлдвэрлэх болно гэж голдуу бодоцгоодог. Гэвч ингэх нь наанадаж л үйлдвэрлэлд асар их сүйтгэл учруулдаг гэдэг нь үнэн.

Эдийн засаг төлөвлөгчид олон улс орон, үйлдвэрлэлийн олон салбар, олон үйл явц дамнасан, үндсэн хөрөнгийн нарийн нийлмэл энэхүү бүтэц энэ сүлжээний бүрэлдэхүүн хэсэг нэг бүрийг түүнийг өмчлөгч нь хэрэглэгчдийн өөрчлөгдөж буй шаардлагыг биелүүлэх, хүмүүсийн хамгийн их үнэлж үзэж буй эд зүйлийг үйлдвэрлэх гэж түүнд байнга тохируулан тааруулдаг, хэлбэрийг нь өөрчилдөг эволюцтэй-холбоотой үйл явцын үр дүн гэдгийг санаж байх учиртай. Жишээлбэл, хэрэв цаг агаар дулаан болоход дэлгүүрийн эзэд ноосон хувцасны оронд хөвөн даавуун хувцас шаардаж нэхэж эхлэх бөгөөд жижиглэнгийн худалдаачин, бөөний худалдаачид хөвөн даавуун бараа илүү их захиалж эхэлнэ. Тэр үед үйлдвэрлэгчид тэдгээрийг нь үйлдвэрлэх гэж тоноглолоо сольж, харин нийлүүлэгчид нь илүү их хөвөн худалдан авна. Харин ачаа тээвэрлэгчид тариалангийн талбайгаас боловсроогүй хөвөн тээвэрлэх ажил руу бизнесээ чиглүүлэх бөгөөд тариаланчид нь шинэ эрэлтийг хангахын тулд илүү их хөвөн тариална. Цөөрөмд чулуу шидэхэд долгион түгж тархдагийн адилаар энэ нийт үйл явц хэрэгцээ гарахын хэрээр хөрөнгийн бүтцийн хувь хэсгүүдэд даалгавар оноон өгч, хольж солих зэргээр бодит байдалд тохируулж тааруулдаг.

Төлөвлөгч мөн л хөрөнгө нэгэн жигд бүтэцгүй, бүх үндсэн хөрөнгийг нөхцөл байдал өөрчлөгдөхөд бусад хэрэглээнд оноож хэрэглэх боломжгүй гэдгийг санаж байгууштай. Үйлийн хайч, оёдлын машин эсвэл ачааны машины адилаар зарим хөрөнгийг өөр олон янзын зорилгод ашиглах боломжтой: эдгээрээр ноосон даавууны адилаар хөвөн даавуу зүсэж, оёж эсвэл тээвэрлэнэ. Гэвч даавуу нэхдэг үйлдвэрлэлийн-хэмжээний нэхэх машиныг шинэ, илүү нарийн хөвөн утсаар нэхэх ажилд нийцүүлж тааруулахад ажиллагаа их орж ч болох юм. Муугаар бодоход үйлдвэрт байдаг энэ болон тэр машин техник бүрэн элэгдэж дуусаж болно, тусгайлан үйлдвэрлэсэн шинэ машин техник худалдаж авах хэрэгцээ гарч болно.

Зарим үндсэн хөрөнгийг өөр зориулалтад нийцүүлж тааруулах боломжгүй гэсэн бодит баримт бол яагаад хөрөнгө өмчлөх явдал өмчлөгчдөө баталгаатай, таатай орлого баталгаажуулж өгдөггүй

болох тухай өөр нэг шалтгаан юм. Нөхцөл байдал өөрчлөгдөхөд зарим үндсэн хөрөнгө хуучран, хэрэггүй болж, өмчлөгчдөө бодит алдагдал болж болно. Шотландын ноос ээрэгчдийн гэрийн ээрүүл, гар ээрэх машин, жишээлбэл, усны хүчээр ажилладаг ээрэх, нэхэх машин зохион бүтээмэгц л ашиггүй зүйл болсон. Эдгээр олон машиныг Шинэ Ертөнц [орч. Америкийг хэлж байна]-өөс ирж буй шинэ төрлийн хөвөн утас боловсруулахад нийцүүлэн, өөрчилж тааруулж байжээ. Энэтхэг, Хятад, Балба болон бусад хөгжиж буй зах зээлээс НХУ (UK) хувцас хэрэглэлийнхээ дийлэнх ихийг импортоор авдаг болсон учраас өнөөдөр тэдгээр тоног төхөөрөмж, эдгээрийг байрлуулж байсан салхин хүрд бүхий байшинг задалж нураан, эсвэл албан байр, үзэсгэлэнгийн танхим эсвэл музей болгож өөрчилсөн.

Бүр төрийн үйлдвэрийн газрууд ч хөрөнгийн алдагдлаас ангид байж чаддаггүй. Трабант суудлын тэрэг 1957 оноос хойш үйлдвэрлэдэг байсан, Зүүн Германы Цвиккау үйлдвэр Герман улс нэгдэж, хүмүүс илүү хурдан илүү хямд, илүү чимээгүй, илүү цэвэрхэн, илүү тохитой өөр машин худалдаж авах боломжтой болмогц зориулалт нь бүхэлдээ алга болж, ханхай, зэвэрч муудсан хог болов. Үнэндээ хуучны Зөвлөлт Холбоот Улсын үеэ өнгөрөөсөн, хэрэгцээгүй хөрөнгийн дийлэнхэд ч ийм л зүйл тохиолдсон.

Муу бодлого хөрөнгө үгүй хийдэг

Хөрөнгө зүгээр л энэ нь зөв газарт, зөв цагтаа хэрэгцээтэй зүйл байхаа болих төдийдөө хэрэггүй зүйл болох боломжтой. Технологи хөгжих, хэрэглэгчдийн хэрэгцээ, хүсэл, таашаал ондоо болохын хэрээр хөрөнгийн бүтэц эдгээр өөрчлөлтөд таарч тохирох ёстой болдог бөгөөд зарим хөрөнгө зүгээр л таарч тохирч чадахгүй байж болно. Тэдгээрийг ашиглалтаас гаргах ёстой болдог. Гэвч бидний үзсэнчлэн хөрөнгийг үрэн таран болгох боломжтой, өмчлөгчид нь таамаглал буруу гаргах, муу үнэлэлт дүгнэлт гаргах эсвэл чадваргүй удирдаж чиглүүлэх зэрэг олон өөр арга үүн дотор бий.

Олон нийтийн бодлого мөн л хөрөнгийн бүтцийг бусниулж, хөрөнгө үгүй хийх боломжтой бөгөөд энэ нь үргэлж зориуд

гаргасан бодлого биш байдаг. Үүний нэг жишээ бол олон улс оронд тохиолддог худалдааны огцом өсөлт болон хямрал (мөн бизнесийн мөчлөг гэдэг)-ын мөчлөг юм. Шинэ технологи уурын хөдөлгүүр, цахилгаан, эсвэл интернетийг зохион бүтээсэн шиг олон зүйлийг илүү сайн эсвэл илүү хямд болгосон учраас огцом өсөлт гарах боломжтой. Гэвч энэ явдал хүмүүс шинэ технологийн байж болох ашиг тусыг хэт өндөр үнэлээгүй, мөн ийм байна гэж бодон хэт их хөрөнгө оруулалт хийгээгүй бол хямралд хүргэх албагүй.

Байнга тохиолддог, их тархсан энэхүү огцом өсөлт-хямралын мөчлөгийн учир шалтгаан нь юу юм бол? Эдгээр мөчлөгийг судалдаг байсан, Австри сургуулийн эдийн засагч Ф. А. Хаек (1899-1992 он) болон Лүдвиг фон Мизэс (1881-1973 он) хоёр тэдгээр нь ихэвчлэн засаг төрийн муу бодлогын улмаас л гардаг гэж дүгнэсэн. Төр засаг зээлийн хүүг бага байлгах эсвэл эргэлтэд буй мөнгөний тоо хэмжээг өсгөх зэргээр эдийн засгийн үйл ажиллагааг идэвхжүүлэх, мөн ажил эрхлэлтийг нэмэгдүүлэхийг оролдоход эдгээр мөчлөг эхэлдэг. Халаасандаа их мөнгөтэй болсон хэрэглэгч илүү их үрнэ, түүнтэйгээ дүйхээр илүү үнэтэй зүйл болон илүү орчин үеийн бүтээгдэхүүнд тэдэнд боломж гарсан учраас мөнгө зарлагадна. Зээлийн хүү бага учраас зээл авах хямд болоход үйлдвэрлэгчид хэрэглэгчдийн эрэлтийг дориун хэмжээгээр хангаж, энэ бүх бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхийн тулд шинэ үйлдвэр, тоног төхөөрөмжид хөрөнгө оруулах арга саам хайдаг.

Гэвч согтууруулах ундаа эсвэл амфетамины үйлчлэлээр үүссэн хөөрлийг шарталт дагалддагийн адилаар мөнгө болон зээлийн энэхүү огцом өсөлтийг хямрал дагалдана. Хүмүүс хадгаламжийн өгөөж нь бага байсан учраас бага мөнгө хуримтлуулдаг. Тиймээс банк энэ бүх шинэ зээллэгээ санхүүжүүлэх хангалттай сангүй болсноо мэднэ, зээлээ буцааж төлөхийг шаардаж эхэлнэ. Зээллэг огцом багассантай нүүр тулсан хэрэглэгчид илүү хямд, ердийн зүйл худалдан авч эхэлдэг. Гэвч үйлдвэрлэгчид хүмүүс одоо нэгэнт худалдан авахгүй байгаа тансаг бүтээгдэхүүн үйлдвэрлэх гэж аль хэдийнээ үйлдвэрээ барьчихсан байдаг. Эдгээр үндсэн хөрөнгө одоо ямар ч зориулалтгүй болж хоцорно: үйлдвэрлэлийн шугамууд

зогсоно, техник төхөөрөмжийг ажиллагаанаас хасна, ажилчид ажлаасаа халагдана, ажилчдын мөнгөөр амьдарч байсан дэлгүүрүүд бас хохирч борлуулалт нь буурна, бүр зарим нь хаалгаа барина. Энэ нь хямд зээллэг болон хялбар мөнгөөр босгосон хуурамч огцом өсөлт байсан боловч жинхэнээсээ алдагдал үүсгэдэг.

2000-аад оны эхээр болсон огцом өсөлт, түүнийг дагалдсан санхүүгийн хямрал мэт иймэрхүү сүйрлийн шалтгаан бол банк эсвэл шунал биш байдаг эсвэл бас олон нийтэд таалагддаг аливаа бусад тайлбарласан шалтгаан ч биш байдаг. Эдгээр циклийг эдийн засгийн өсөлтөө идэвхжүүлж өдөөх гэж оролддог, ингэх үеэрээ хуурамч дохио явуулан хөрөнгийн бүтцийн эмзэг сүлжээг бусниулдаг төрийн засаг захиргаа бий болгодог. Муу бодлогын улмаас гардаг хохирол сүйтгэл хөрөнгийн хувь эзэмшигчийн алдаа эсвэл чадваргүй байдал эсвэл нэг технологи нөгөөгөөрөө солигдсоноос болж үүссэн аливаа сүйтгэлээс хамаагүй их байна. Огцом өсөлт-хямралын мөчлөг эдийн засгийн амьдралын салаа мөчир бүрд нөлөөлдөг: алдагдал сүйтгэл нэг компани эсвэл салбараар хязгаарлагдахгүй ч өргөн хүрээнд тархаж, тогтолцооны шинжтэй болно. Засаг захиргааны ойрыг харсан бодлогоос хөгжил цэцэглэлт үүсдэг гэсэн хоосон яриа богино настай эд; гэлээ гээд энэ зүйл бодит алдагдал, ажилгүйдэл, дампууралд хөтөлдөг — мөн хөрөнгийн бүтэц болон эдийн засгийг бүхэлд нь тасар татдаг, банкуудын дампуурал голдуу үүнээс л гарна.

Дүгнэлт

Нэгтгэж дүгнэвээс капитал буюу хөрөнгө бол ямар нэг сүйтгэл эсвэл зардал гаргалгүйгээр хүссэнээр ийш тийш шилжүүлж болдог нэгэн ижил бүтэцтэй ямар нэг зүйл биш; бас азтай гэх өмчлөгчид нь ирэх баталгаатай орлогын байнгын үүсгүүр гэж байдаггүй. Үүний эсрэгээр хөрөнгө зөвхөн тусгай багаж хэрэгсэл эсвэл машин техник, эсвэл хүмүүсийн онцгой чадвар болон мэдлэг гэх мэт хүмүүний капитал зэрэг тусгай тодорхой үндсэн хөрөнгийн хэлбэртэй зөвхөн оршдог. Эдгээр үндсэн хөрөнгө бүр өөр өөр өвөрмөц шинжтэй. Үүнд: зарим нь илүү удаан эдэлгээтэй эсвэл богино эдэлгээтэй, хэд

хэдэн зориулалтаар эсвэл зөвхөн нэг зорилгод ашиглах боломжтой, өөрчлөгдөж буй эрэлтэд нийцэж таарамтгай эсвэл тийм биш, дор хаяж ямар нэг хаягдал болох өчүүхэн үнэ цэнэтэй эсвэл тийм биш байна.

Үүнээс гадна эдгээр үндсэн хөрөнгө (capital goods) байгаа учраас л гарах боломжтой болсон бүтээмж, мөн уг бүтээмжээс дагалдаж гардаг орлого огцом нэмэгдэх явдал зөвхөн эдгээрийн эздээр хязгаарлагддаггүй, бас нийтэд хүн амд ямар нэг хэмжээгээр өргөжин тархдаг. Тухайн улс оронд буй хэн бугай ч зам, нийтийн аж ахуйн сүлжээ, бичиг үсэгт тайлагдах явдал, нутаг нэгтнүүдийнхээ чадвараас ашиг тус хүртдэг бөгөөд үйлдвэрлэгчид илүү бүтээмжтэй үйл ажиллагаа болон тоног төхөөрөмжид хөрөнгө оруулсны үр дүнд гардаг илүү сайн, илүү хямд бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг таашаан эдэлдэг.

Гэвч эдгээр ашиг тус байнга байж байдаг зүйл биш. Хөрөнгө үргүй зүйл болох эсвэл хулгайлагдах боломжтой; энэ нь өөрөө хуучирч муудах эсвэл түүнийг хэрэглэж дуусгах ч боломжтой; хөрөнгийг буруу удирдаж залж эсвэл буруугаар хэрэглэх боломжтой; энэ нь шинэ технологи гарч ирэх эсвэл хэрэглэж буй олон нийтийн таашаал өөрчлөгдөхөд хэрэггүй зүйл болох ч боломжтой. Хөрөнгө бол азтай хэдхэн хүнд зориулагдсан ид шидтэй мөнгөний мод биш: түүнийг бүтээж, арчилж тордон, хамгаалж, бас зөв удирдаж чиглүүлэх ёстой. Энэ бол зүгээр нэг хялбар ажил биш.

Эцэст нь хэлэхэд хөрөнгүүд хоорондоо сүлжээ үүсгэх учиртай. Өнөөдөр үйлдвэрлэлийн олон үйл ажиллагаа урт хугацаанд үргэлжилдэг, нарийн нийлмэл болсон бөгөөд бас дээр нь дэлхий даяар байх газраас ирдэг түүхий эдийн орц хэрэглэгдэхүүн шаардлагатай байдаг. Энэ орц хэрэглэгдэхүүн нь цуглуулах, боловсруулах, угсрах олон-улсыг хамарсан нийлмэл бусад ажиллагаанаас хамаарна. Иймэрхүү үйлдвэрлэл даяар хэрэглэдэг үндсэн хөрөнгийг үе шат бүрд нь бусадтай нь нягт уялдуулж ашиглах хэрэгтэй болдог.

Тиймээс бид үндэстэн (эсвэл дэлхий)-ий хөрөнгийг хянаж чадна, ямар нэг зардал сүйтгэлгүйгээр үүнийгээ зарим нэг илүү үнэ цэнэтэй

гэж үзэж буй үр дагавар гаргах явдал руу чиглүүлж ч чадна гэж бодох явдал бол том алдаа. Энэ нь онолын хувьд боломжтой гэж харагдаж болох ч гэлээ ийм байх бараг л боломжгүй: эцсийн эцэст эдгээр үндсэн хөрөнгийн олныг нь эсвэл бүгдийг нь үйлдвэрлэлийн олон-улсын нийлмэл сүлжээний нэг хэсэг болгож ашиглах гэсэн тодорхой зориулалтаар л бүтээдэг. Энэ байдал бид илүү аятай дүр зураг гаргахын тулд эвлүүлдэг дүрснүүд (puzzle or jigsaw pieces)-ийн байрлалыг нь өөрчилж чадна гэж төсөөлөхтэй адилхан: гэвч тэр хэсгүүд өөр хоорондоо нэг л байдлаар эвлэж нийлдэг; хэрэв байрлалыг нь өөрчилбөл тэр хэсгүүдээс сайхан зураг барагтай бол гарахгүй. Хэрэв бид шинэ зураг бүтээх гэж байвал бид шинэ хэсгүүд бүтээх, тэдгээрээ хооронд нь эвлүүлж нийлүүлэх ёстой; үүнтэй адилаар өөр өөр бүтээгдэхүүн бий болгохын тулд бид ондоо ондоо үндсэн хөрөнгө бүтээх, тэдгээрээ хооронд нь бат бөх, бүтээмжтэй бүтэц болгож хамтад нь тааруулж нийцүүлэх ёстой. Зарим нэг төлөвлөгч, дарангуйлагч эсвэл хууль тогтоогчийн тогтворгүй хувьсамтгай, улстөрөө бодож гаргасан шийдвэр гэхээс илүүтэй зах зээлийн алдаж онох явдлын урт хугацаанд үргэлжилсэн, тасалдалгүй, эволюцтэй-холбоотой үйл явцаар хамгийн сайн үүнийг гүйцэтгэдэг.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ: Капитализмыг Юу Ажиллуулдаг Вэ

Бидний харсанчлан зөвхөн капитализмд л байдаггүй эсвэл бүр түүний амин чухал зүйл байдаггүй ч амжилтад нь гарцаагүй хувь нэмэр оруулсан учраас капитализмтай ихэвчлэн холбоотой гэж боддог хэд хэдэн зүйл бий. Тэдгээрийг дурдвал өөрийн-тусыг бодох явдал, хувийн өмч, эв найр, ашиг, өрсөлдөөн, нарийн төрөлжих/мэргэжих явдал, зах зээл орно.

Өөрийн-тусыг бодох, өмч, ашиг, санаачилга

Өөрийн-тусыг бодох (self-interest). Капитализм өөрийн-тусыг бодох явдлаар сэдэлждэг ч шуналыг шийтгэдэг. Энэ хоёр зүйл нэлээд ондоо зүйлс юм.

Шунах гэдэг нь бусдынхаа ашиг сонирхол эсвэл мэдрэмжийг үл тоон, бүр магадгүй давамгайлж буй хууль, дүрэм журам, уламжлалыг үл тоон өөрийн ашиг сонирхлын төлөө үйл хийхийг хэлдэг. Мөн хэрэгцээнээсээ үл хамаарч шуналаасаа болж эд зүйл хуримтлуулахыг хэлнэ. Гэвч капитализм хүмүүс ёс журмаа сахиж, нэг нэгтэйгээ шударга харилцах, амлалтаа биелүүлдэг бол л зөвхөн ажиллах боломжтой. Аз болоход бусад олон худалдан авагч, арилжаалагч хийгчээс гарах өрсөлдөөнөөс болж, бизнес хийхдээ худал хэлдэг эсвэл хууран мэхэлдэг аливаа хүн удалгүй хэрэглэгчид болон ханган нийлүүлэгчид нь түүнээс холдож буйг мэдэх болно. Хөгжиж цэцэглэх цор ганц арга зам бол бусдад хүсэж буйг нь өгөх явдал юм. Бусад хүмүүсийн ашиг сонирхлыг үл тоох явдлаас ангид оршдог капитализм биднийг бусдыгаа таньж мэдэх, тэдэнд үйлчилдэг болгох хандлагатай байдаг.

Үүнээс ялгаатай нь өөрийн-тусыг бодох явдал бол байхгүй бол бидний аль ч нь амьд үлдэж чадахгүй хүмүүний заяагдмал шинж чанар юм. Түүнийг хэрхэн хязгаарлах, мөн өөртөө-үйлчилдэг хувь хүмүүсийн хаос гэхээсээ сайн ажилладаг нийгэм бий болгох явдал руу залж чиглүүлэх явдал бол ёс суртахууны асуудал. Аз болоход дахиад капитализм хүн бүрийн ашиг тусын төлөө тэдний өөрийн-тусыг бодох явдлыг нь ашигладаг.

Өөрийн-тусыг бодох гэдэг нь хүмүүс бусад нь тэдэнд оноож өгөөгүй өөрсдийнхөө зорилго, алсын хараа, зорилт, алсын бодолдоо хүрэхээр тэмүүлэхийг хэлдэг. Энэ хүмүүс зөвхөн хувийн ашиг тусынхаа төлөө биш бас гэр бүлийнхээ, мөн хайрладаг, анхаарал хандуулдаг бусдынхаа ашиг тусын төлөө эдгээр мөрөөдөлдөө хүрэхээр тэмүүлнэ. Хүмүүс хэрэв энэ нь хоёр талын хоёулынх нь ашиг сонирхолд нийцэж байвал бусадтайгаа, жишээлбэл, арилжаа наймаанд хамтран ажилладаг. Гэвч үүний сэдэл нь өөрийн-тусыг бодох явдал байх боломжтой ч энэ нь ямар нэг таагүй үр дагаврыг илэрхийлдэггүй. Үүний эсрэгээр арилжаа наймаагаар хамтран ажиллах явдал — Адам Смит "Үл Үзэгдэх Гар" гэсэн санаагаараа тайлбарласанчлан нийгэмд ашиг тустай байх үр дагавар ерөнхийдөө бий болгоно.

Хувийн өмч. Хувийн өмч зөвхөн капитализмд байдаггүй ч түүнийг сайн ажиллахад гарцаагүй хэрэгтэй зүйл. Магадгүй санамсаргүй зүйл гэж харагдаж болох ч хувийн өмч хөдөлмөрч, харилцан биесээ хүндэтгэдэг, чин шударга, итгэлцсэн нийгмийг хөхиүлэн дэмждэг.

Хүмүүс өмчөө бусад хүмүүсийн өмчөөс илүү сайн анхаарч бөөцийлдөг гэдэг нь бодит баримт. Олон улс оронд, жишээлбэл, хэдийгээр эзэд нь орон сууцнуудаа гоё сайхан байлгадаг ч гэсэн орон сууцных нь орц шат, нийтийн талбай хуучирч муудсан, бас тордож засаагүй байдаг.

Хүмүүс мөн л хувиараа өмчилдөг эд зүйлээс өөрсдөд нь ч нийгэмд ч ашиг тустай илүү их үнэ цэнэ гарган авдаг. Зөвлөлт Орос эсвэл Маогийн Хятадын хамтралууд нийтийг хамарсан өлсгөлөнгөөс өөр юу ч бүтээгээгүй бол капиталист нийгэм дэх хувь хүмүүс өмчилдөг хөдөө аж ахуйн фермүүдийг байж болох хамгийн их ургац авахаар

маш хянамгай эрхлэн явуулдаг. Хэн ч өмчилдөггүй дэлхийн эх далайгаас загас хэтрүүлэн олборлодог бол харин Шотландын яргай загасны нөөцийг тэдгээрийн орж нутагшсан голын эзэмшигч, спорт загасчлалаас амьжиргаа нь хамаардаг, хувь өмчлөгчид нь чанд хамгаалдаг.

Хүмүүс өмчөө хамгаалдаг, бөөцийлдөг, үнэ цэнэ түүнээс гардаг авдаг байхын тулд тэд тэр өмчийг өмчилдөг гэдэгтээ итгэлтэй байх учиртай. Өмч өмчлөх, түүгээр юу хийх боломжтой, ямар ашиг тус гарган авах боломжтой, бусдад өмчөө хэрхэн шилжүүлэх боломжтой тухай ойлгомжтой ёс журам байх ёстой. Өмч, үүн дотроо зөвхөн газар эсвэл үндсэн хөрөнгөөр зогсохгүй хэрэглээний аливаа бараа бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээ худалдаж авах эсвэл зарахтай холбоотой гэрээ ойлгомжтой, түүнийг биелүүлдэг байх учиртай. Хулгай болон залилан мэхлэхийг үгүйсгэдэг байх ёстой бөгөөд энэ нь ийм зүйл болбол түүнийг улмаас хохирсон хөрөнгийг сэргээн олгох шүүхийн ямар нэг тогтолцоо хэрэгтэй болохыг харуулдаг. Тийм үед л хүмүүс ирээдүйд арилжаа хийхэд оролцох, эсвэл эрсдэлтэй, бас үр шим нь олон жилийн дараа гарах аж ахуйд хөрөнгө оруулах боломжтой болно. Капитализм ийм л ертөнцөд зөвхөн ажиллах боломжтой.

Засаг захиргаа мэдээжээр бусад бүх хүний адилаар нэгэн ижил хууль ёсонд захирагддаг байх ёстой. Тэнд ажилладаг хүмүүс улстөрийн эсвэл шүүх эрх мэдлээ зарим нэг бүлэг хүмүүст таатай хандахад эсвэл өмнөө тавьсан зорилгодоо хүрэхийн тулд зах зээлийг гажуулахад ашиглах боломжгүй; ингэх нь зах зээлийн тэнцвэрийг алдагдуулж, капиталист үйлдвэрлэлийн үр ашгийн нийлмэл сүлжээг устгах эрсдэлтэй.

Ашиг. Ашиг бас л зөвхөн капитализмд байдаг зүйл биш. Үнэндээ, бид түүнийг өөрсдөө оролцдог үйл ажиллагаа нэг бүрээс эрэлхийлж байдаг бөгөөд санхүүгийн ашгаас гадна олон төрлийн ашиг бий. Амьдралдаа юу ч хийж байсан бид гаргаж буй цаг хугацаа болон хүчин чармайлтаас гарах ашиг тус нь асар их байна гэж найддаг. Уулын оргил руу авирах нь харах гэсэн үзэсгэлэн төгөлдөр харууцтай дүйдэг үү? Урт лекцэд сууснаар та нар жинхэнээсээ

хэрэгтэй зүйл сурч мэдэж чадсан уу? Хэрэв тийм бол та нар ашиг тус хүртэж байна гэсэн үг.

Бүр арилжаанд ч гэсэн ашиг зөвхөн санхүүгийнх байдаггүй. Ихэнхи хүмүүс заавал асар их эд баялагтай болох гэж биш, харин өөрсдийгөө болон гэр бүлээ хангалуун байлгахын тулд мөнгө олох гэж бизнест ордог нь мэдээжийн зүйл. Гэлээ гээд хэн ч үүнийг азгүйтэж эсвэл байнга зовж зүдрэн хийхийг хүсдэггүй. Ингэвэл энэ нь хохирч буй хэрэг болно. Эдийн засгийнхаа амьдралаас өөр өөр хүмүүс эрж хайдаг санхүүгийн бус ашгийн дунд ажлаараа бахархах бахархал, чөлөөт цагаа өнгөрүүлэх бололцоо, мөн тэд бусдад тус болох ямар нэг хэрэгтэй зүйл хийж байна гэсэн бодол ордог. Бидний ихэнхийн хувьд магадгүй ийм зүйлээс авч буй тайтгарал таашаал мөнгөнөөс илүү үнэ цэнэтэй байж болох юм.

Капиталист ажил хэрэгч хүмүүсийн бүтээдэг санхүүгийн ашиг ямар нэг мөлжлөгөөр дамжин ажилчдын цалингаас гарсан байх ёстой гэж хэлцгээдэг. Гэвч хэнийг ч хөлсөлж ажиллуулдаггүй ажил хэрэгч хүмүүс мөн л ашиг хийдэг байх боломжтой байдаг явдал энэ гаргалгаа нотолгоог үгүйсгэдэг. Хоёрдугаарт хэнийг ч тодорхой нэг ажил хэрэгч хүмүүст ажилла гэж хүчилж албаддаггүй: тиймээс тэр хүмүүс яагаад тэднийг мөлжиж буй газар ажиллах ёстой гэж? Тэд өөр нэг ажил олгогч руу явах эсвэл бүр өөрсдийнхөө төлөө ч ажиллах ч боломжтой.

Гуравдугаарт, хамгийн чухал нь дээр хэлсэн гаргалгаа нотолгоонд ашиг болон үнэ цэнийг бүтээдэг гэдгийг мартчихдаг. Ажилчдаа мэхэлж авч чадвал л ажил олгогчдын гарт орох боломжтой үнэ цэнийн тогтмол сан (ө.х. нэг нь алдаж байж нөгөө нь хождог, тэг нийлбэртэй тоглоом шиг сан) гэж зүйл байдаггүй. Үнэ цэнэ эд зүйлд биш харин бидний ухаан санаанд оршдог: нэг хүн тодорхой нэг ваарыг үнэлж баршгүй зүйл гэж харж байхад нөгөө нэг нь үүнийг зүгээр хог гэж үздэг. Юмсыг хүмүүс өөр өөр үнэлж үздэг учраас тэд хоорондоо наймаа хийх боломжтой болж, хүн бүр өөртөө илүү сайн ашиг олж авдаг. Ажил хэрэгч хүн ажилчдаасаа үнэ цэнэ хулгайлдаггүй харин тэдний авьяас чадварыг залж удирдан ямар нэг шинэ зүйл хийх замаар үнэ цэнэ бүтээнэ.

Ажил хэрэгч байдлын ашиг. Ажил хэрэгч хүний ашиг олон үүсгүүрээс гарах боломжтой. Жишээлбэл, эд юмсыг үнэлж үзэх хүмүүсийн ялгаанд суурилсан арилжаанаас эсвэл хэрэглэгчийн эрэлтийг илүү үнэ дүнтэй хангахын тулд орц хэрэглэгдэхүүн, хөдөлмөр, үйлдвэрлэх үйл явц, маркетинг, түгээлтийг чадварлагаар хуваарилах явдлаас түүний ашиг гардаг. Эсвэл бусад хүмүүс үл анзаарсан нөөц бололцоог олж мэдэх явдлаас мөн гарах боломжтой.

Зарим ажил хэрэгч хүн, жишээлбэл, Сони компани хувийн хөгжим тоглуулагч Волкманаараа хийсэн шиг эсвэл Старбакс тусгай кофены мухлаг ажиллуулсан шигээр бусад нь хараагүй байж болох эрэлтийг олж мэдэн ашиг хийдэг. Заримдаа ажил хэрэгч хүмүүс Эли Витний ноос самнах машин хийсэн шиг, мөн Томас Эдисон гэрлийн улайсдаг чийдэн бүтээсэн шигээр шинэ технологи зохион бүтээж ашиг хийж чадна. Бусад нь Жэймс Дайсон тоос сорогч хийсэн шиг, мөн Аппл компани iPhone хийсэн шигээр байгаа технологи ашиглаж шинэ бүтээгдэхүүн, үйл явц зохион бүтээж ашиг хийдэг.

Ажил хэрэгч хүмүүс Амазон онлайн дэлгүүрээ нээж бий болгосон шигээр эсвэл Үбер, Эйр-Би-эн-Би болон бусад олон "хуваалцаж хэрэглэх" аппууд хийсэн шиг бүхэлдээ шинэ зах зээл, ажиллах арга зам олж нээсэн шиг хэрэглэгчдийнхээ ая тухыг сайжруулах арга зам олж ч болно. Дүрэм журмын зохицуулалтыг шинэчлэх явдал мөн ажил хэрэгч байдлын шинэ нөөц бололцоог бий болгох боломжтой. Гар утасны сүлжээ, жишээлбэл, АНУ дахь Велл Телефон Компани болон НХУ дахь Бритиш Телекомын монополийг задалсны дараа хурдтай өсөн нэмэгдсэн.

Хэдхэн хүн аз тохиолдлоор олон нийтийн анхаарлыг өөртөө татсан ямар нэг зүйл бүтээх эсвэл олж нээн, бахадмаар амжилтын замаар явж, асар их хөрөнгөтэй болдог гэдэг нь эргэлзээгүй. Хүмүүс заримдаа хуучин эдлэлийн дэлгүүрээс худалдаж авсан уран зураг нь Эртний Суут Зураачийнх болохыг хааяа хааяа олж мэддэг. Гэвч иймэрхүү ажил хэрэгч байдлын цэвэр ашиг гэж нэрлэдэг зүйл бол зүгээр л азны хэрэг, хүртэх ёсгүй эд юм гэж бодох нь буруу хэрэг. Ихэнхи ажил хэрэгч хүмүүс жинхэнээсээ амжилтынхаа төлөө шаргуу хөдөлмөрлөж, бүтээгдэхүүнээ сурталчлахын тулд цаг

хугацаа гаргаж чармайдаг. Бүтэлгүйтэхдээ, бас тэднийг үл тооход зовдог ч гэсэн тэд амжилтад хүрэх хүртлээ үүнийг тэсэж тэвчдэг: Ж. К. Роулингийн *Харри Поттер*ын анхны ботийг Блүүмбэри хэвлэлийн газар хүлээн авахаас өмнө арван хоёр хэвлэн нийтлэгч түүнээс татгалзсан байдаг — харин Блүүмсбэри хэвлэлийн газар амжилтад энэ ном хүрнэ гэдэгт тийм ч их итгээгүй гэдэг.

Санаачилга. Тийм учраас ажил хэрэгч байдлын ашиг ховорхон тохиолдолд аз байдаг эсвэл бүр аз бараг биш байдаг: энэ бол алсын хараа, оюун санаа, цаг хугацаагаар хөрөнгө оруулах, мөн чадвар, эрсдэл хүлээх, тууштай байдал шаарддаг, бодсон зүйлдээ хүрэхээр идэвхитэй тэмүүлэх явдал юм. Иймэрхүү хүчин чармайлтын ихэнхи нь бүтэлгүйтлээр дуусдаг: гэвч амжилтад хүрсэн нэг нь хүн бүрийн амьдралыг сайжруулж, цааш хөгжиж дэвжих үндэс суурийг барьж байгуулдаг.

Тиймээс ажил хэрэгч явдал болон түүний үндэс суурь болдог хөрөнгө оруулалт болон хувийн зан чанарыг тэтгэдэг, мөн шагнаж урамшуулдаг хуульзүй, улстөр, нийгмийн соёлтой байх явдал амин чухал байдаг. Эдгээрийн дундаас хамгийн гол нь эв найрыг аюулгүй байлгах явдал болон хууль ёс (rule of law) юм. Учир нь эдгээр зүйл байвал ажил хэрэгч хүмүүс тэд иймэрхүү хөрөнгө оруулалтаа бат итгэлтэй хийж чадна, тэдний ажлыг бусад хүн, үүн дотроо харийн цэрэг, дотоодын гэмт хэрэгтнүүд, бас дээр нь өөрийнх нь төр засаг устгахгүй, эсвэл бүтээсэн зүйлийг нь хулгайлахгүй гэдгийг мэддэг. Нэгэнт бүтэлгүйтэх эрсдэл өндөр тул жишээлбэл эрсдэлийг нь өсгөж, зардлыг нь улам бүр өсгөх өндөр татвар, залхаасан дүрэм журмаар хялбархан гэгч нь ажил хэрэгч хүний урмыг хугалж болно.

Өрсөлдөөний явц

Капитализмыг маш динамик хөдөлгөөнтэй болгодог өөр нэг зүйл бол өрсөлдөөн юм. Өрсөлдөөний тэргүүнд явахын тулд, хэрэглэгчдээ бусдад алдахаас сэргийлэхийн тулд үйлдвэрлэгчид санал болгож буй зүйлээ, мөн түүнийг хэрхэн хийх арга барилаа байнга шинэчилж, сайжруулах ёстой.

Эдийн засгийн ухааны сурах бичигт өрсөлдөөний энэхүү динамик буюу хөдөлгөөнт үр нөлөөг ховор дүрсэлж тайлбарладаг. Тэдгээр номд маш ихээр "төгс өрсөлдөөн"-ий тухай өгүүлдэг — энэ бол яг ижил бараа бүтээгдэхүүн зардаг ижил тооны олон худалдагч болон худалдан авагчтай онолын төлөв юм. Гэвч бодит байдал дээр бараа худалдагч болон худалдан авагчид бүгдээрээ өөр өөр байдаг. Яг ижил бүтээгдэхүүн арилждагаас ялгаатай нь бараа худалдагчид өрсөлдөгч нараасаа илүү содон, илүү хүсүүштэй зүйл худалдан авагчдаа санал болгож бусдаасаа ялгарах гэж зорьцгооно.

Харамсалтай нь "төгс өрсөлдөөн"-ий санаа маш өргөн тархсан тул бүр капитализмын хамгаалагчид ч өрсөлдөөн жинхэнээсээ хэрхэн ажилладгийг ухаж ойлголгүй ерөнхийдөө алдаа гаргадаг; "төгс" гэдэг төөрөгдөлд оруулсан хэллэг капитализмын шүүмжлэгчид (бүр түүнд талтай ханддаг хүмүүс ч) төр засаг зах зээлийг илүү "төгс" болгох гэж хөндлөнгөөс оролцох ёстой гэж бодоход хүргэдэг.

Гэвч жинхэнэ зах зээл хэзээ ч "төгс" тэнцвэрт оршдоггүй: өрсөлдөөн бол дасан зохицох, шинэчлэх, сайжруулах байнгын үйл явц бөгөөд энэ бол өрсөлдөөн бидэнд өгч буй маш том ашиг тус юм. Ажил хэрэгч хүн бидний өөрчлөгдөж буй хэрэгцээг хангах гэж тэмүүлэхийн хэрээр шинэ бараа бүтээгдэхүүн болон үйл явц арай муу үр дүнтэй нэгнүүдээ зах зээлээс шахдаг. Албан тушаалтнууд биш харин хэрэглэгчид л энэхүү динамик үйл явцыг өдөөж чиглүүлдэг. Албан тушаалтны зах зээлийг "төгс" болгох гэсэн оролдлого зүгээр л зах зээлийг тодорхой төвшинд царцаадаг; гэвч бодит өрсөлдөөний үеэр хэрэглэгчид илүү сайн, бүр илүү сайн бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдээс өршөөлгүйгээр шаардаж харин үйлдвэрлэгчид нь тэдгээрийг тэдэнд нийлүүлэхийн тул илүү сайн, бүр илүү сайн арга зам идэвхтэй эрж хайна.

Зарим бизнес энэхүү үйл явцыг тэсэж чадахгүй байж магадгүй. Гэвч зах зээлийн өрсөлдөөн бол үхэх сэхэх нь ашиглах нөөцийг аль нь авснаас хамаардаг, бас тэр нөөц нь тодорхой хэмжээтэй байдаг биологийн өрсөлдөөнтэй адилгүй. Өрсөлдөөн нөөцийг бүтээж, нийт үнэ цэнийг өргөжүүлж тэлдэг. Бизнесүүд өдөр тутам зах зээлийн туршилтад ордог учраас тэдгээр нь нөөцөө бага үнэ цэнэтэйгээс нь

илүү их үнэ цэнэтэй хэрэглээ рүү шилжүүлсээр байх ёстой. Хэн ч үхэхгүй: тэд зүгээр л өөрөөр ажиллах ёстой болно.

Нарийн төрөлжих явдал ба зах зээл

Нарийн төрөлжих явдал ба түүний ашиг тус. Үндсэн хөрөнгө (capital goods) маш сайн төрөлжих боломжтой. Тэдгээрээс олон нь нэг тодорхой бүтээгдэхүүн эсвэл түүний бүрэлдэхүүн хэсгийг бүтээх зориулалтай зөвхөн оршдог. Зарим тохиолдолд бараа бүтээгдэхүүн эсвэл түүний бүрэлдэхүүн хэсгийг тэдгээрээр хэдэн мянга дахин хурдан хийх эсвэл маш хямд болгох боломжтой. Жишээлбэл, гараар аливааг хийхээс хэдэн мянга дахин хурдан, хямд ган хийх төмөр уурхайлах, ган хайлуулах, моторын блок цутгах болон өнгөлөх, суудлын тэрэг угсрах боломж эдгээр хөрөнгө олгодог. Ур чадвар ч мөн л төрөлждөг: байрны засварчин, дээвэрчин, шилчин, цахилгаанчин, сантехникийн ажилтан бидний гэр орны засварыг хийж чадах бөгөөд бид өөрсдөө хийж чадахаас хамаагүй сайн, илүү аюулгүй үүнийг хийж үйлчилдэг. Харин тусгай мэргэжсэн эмч мэргэжээгүй мэргэжил нэгтнээсээ бидний өвчний талаар илүү ихийг мэдэх боломжтой.

Жирийн хүмүүс өвчин бүрийн талаар бүгдийг мэдэж чадахгүй эсвэл өрөөгөө хэрхэн хамгийн сайн будах эсвэл угаалгын машин хэрхэн засахыг мэдэхгүй; бас хүн бүр суудлын тэрэг хийхэд хэрэгтэй үндсэн хөрөнгө өмчилж чадахгүй. Үнэндээ, хэрэв бид бүгдээрээ ингэхийг оролдвол энэ нь маш үрэлгэн хэрэг болно. Үүний оронд бид бүгдээрээ бусад хүмүүсийн ур чадвар, тэдний худалдан авсан үндсэн хөрөнгө төрөлжих явдлаас өгөөж хүртдэг. Бидний суудлын тэрэг, цаг, үсний машин, бидний хүсдэг бусад бүх зүйл бусад хүмүүс мэргэжиж, төрөлжсөний ачаар илүү хямд, илүү сайн болдог.

Зах зээл. Үнэндээ төрөлжих явдал капитализмыг маш бүтээмжтэй болгодог тул түүний бүтээсэн энэ бүх бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээг түгээх түүнтэй адилхан үр өгөөжтэй арга зам яаралтай олох хэрэгтэй болсон. Энэ явдал бол яагаад зах зээл капитализмтай зэрэгцэн үүсэж хөгжсөний шалтгаан юм. Зах зээл л бидэнд

үйлдвэрлэж чадах асар их илүүдэл зүйлээ борлуулах, мөн бусад хүмүүсийн бүтээмжтэй байдлаас үр шимийг нь хүртэх боломж олгодог.

Өөр өөр хүмүүс нэг ижил бараа бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээг ондоо ондоогоор үнэлж үздэг учраас зах зээл дээрхи солилцоо болдог. Үнэ цэнэ бол жин эсвэл хэмжээ мэт юмсын объектив шинж чанар биш: үнэ цэнэ түүнийг үнэлж үзэгчийн ухаанд л зөвхөн оршдог. Бид илүү үнэлж үздэг ямар нэг зүйлийг төлөө үүнээс арай бага үнэлж үздэг зүйлээрээ шууд эсвэл мөнгө ашиглаж сольж авсныхаа дараа өөрсдийгөө — бидэнтэй наймаа хийсэн хүний адилаар — ашиг тус илүү их хүртсэн гэж үздэг. Бүр хэдийгээр бидний солилцоо ямар ч шинэ бараа бүтээгдэхүүн үйлдвэрлээгүй ч гэсэн энэ нь нийт үнэ цэнийг өсгөнө.

Капитализмын асар их бүтээмжийг бодож үзвэл энэ явдал онцгой чухал зүйл юм. Жишээлбэл, том хэмжээний газар хагалах, үр суулгах, ургац хураах механикжсан арга ашигладаг үр тариа тариалагч фермер хурааж авсан улаан буудай эсвэл үр тарианыхаа өчүүхэн хэсгийг л зөвхөн хэрэглэж чадах бөгөөд энэ ургацаа зах зээл дээр ямар нэг зүйлээр солилцож чадах учраас л үнэлж үздэг. Үүнтэй адил зүйл хүрднээс нь өдөр бүр гарах аяга, сав суулга бүрээ бүгдийг нь хувьдаа хэрэглэж чадахгүй ваарчинд тохиолдоно. Мөн суудлын тэрэг үйлдвэрлэгч, гутал хийгч, чадварлаг усан будгийн зураач, эсвэл рестораны эзэнд ч энэ зүйл тохиолддог. Гэвч зах зээл энэ бүх бараа бүтээгдэхүүнийг тэдгээрийг илүү ихээр үнэлж үздэг хэрэглэгчид рүү хүргэдэг.

Солилцоо бол эртний зүйл; гэвч зах зээл өсөж томрох, үүсэж тогтсон зүйл болохын хэрээр өөр өөр зүйлийг солилцдог үнийн ханш, тэдгээрийн үнэ бүгдээрээ мэддэг, урьдаас таамаглахуйц зүйл голдуу болдог. Энэ байдал байгаа байдлаараа хүн бүрд ашиг тустай. Учир нь энэ нь бид бүгдэд хаана бидний хөрөнгө оруулалт илүү сайн өгөөжөө өгч болох тухай хамгийн сайн санааг хэлж өгнө. Үнийн ханш үйлдвэрлэгчдэд бүтээгдэхүүнээ хамгийн сайн үнээр зарахад тус болно: жишээлбэл, интернетэд холбогдсон гар утсаараа жижиг фермерүүд бүр дэлхийн хамгийн алс бөглүү газраас ч гэсэн олон-

улсын хүнсний зах зээлийн мэдээ шалгаж, бөөний худалдаачин тэдний ургацыг үндэслэлтэй үнээр авч буй эсэхийг нягтлах боломжтой болсон. Фьючерсийн зах зээл (futures markets)-ийг харах явдал тэдэнд хамгийн сайн орлого олохын тулд юу тарих, хэзээ үрээ суулгах эсэхээ шийдэхэд нь тус болно.

Зах зээлийг хууль, уламжлал захирдаг ч гэсэн энэ нь хэрэглэгчийн өөрчлөгдөж буй эрэлтэд нийцэж таарах ёстой. Хуваалцаж хэрэглэх үйлчилгээний апп (sharing-economy app) мэт шинэ бүтээгдэхүүн, үйл ажиллагаанд зах зээл дасан зохицох хэрэгтэй. Бүх шинэ санаа, шинэчлэл зах зээлийн зохицуулагчид (market regulators)-ад сорилт учруулдаг: шинэ бүтээгдэхүүнийг зарж болох эсэх талаар аюулгүй байдалтай холбоотой жинхэнээсээ санаа зовоосон асуудал байж болох ч үүнийг голдуу өрсөлдөөнөөс айсан хүн албан тушаалтныг лоббидож дэвэргэдэг. Зах зээлийг чөлөөтэй байлгах, ялангуяа нийлүүлэгчдийг агшин зуур, хялбархан онлайнаар үнэлэх боломжтой байх нь мөн л ашиг тус өгдөг. Хэрэв шинэ санаа, шинэчлэлд боломж олговол бид хөгжиж дэвшиж чадна.

Капитализм ба төр

Капитализмын дэмжигчид бас төр үндсэн хөрөнгө өмчлөх, хэрэглээг нь удирдаж чиглүүлэх ёсгүй гэж батлан өгүүлдэг. Тэд улстөрчид болон олон нийтийн албан тушаалтнуудыг хэрэглэгчдийн өргөн хүрээний хэрэгцээг гэхээсээ илүүтэй улстөрийн явцуу ашиг сонирхолд хэт автамхай гэж үздэг. Хамгийн сайн даа л төр капитализмыг ажиллуулдаг зарчмуудыг, үүн дотроо хувь хүний эрх, шударга ёс, албадлагагүй хамтын ажиллагааг хамгаалах ёстой. Үүнийг хийхийн тулд төрд өөрийнх нь албадлагын хүч, цагдаа, цэрэг, шүүх, шорон хэрэгтэй. Гэвч бүх эрх мэдэл авилгалд автамхай бөгөөд шунахай ашиг сонирхлын олз болдог тул төр засгийн эрх мэдлийг хязгаарлах ёстой.

Капитализмын дэмжигчид хувь хүмүүс өөрсдөө ихэнхи зүйлийг шийдвэрлэж чадах ч хамтын төсөл, жишээлбэл, батлан хамгаалах эсвэл шинэ онгоцны буудал болон цардмал зам хаана барих

зэргийг шийдэж чадахгүй — ийм шийдвэр гаргах зохистой арга бол ардчилал юм гэж батлан өгүүлдэг. Тэд мөн ардчилал бол төрийн албадлагын эрх мэдэлтэй хүмүүсийг хязгаарлах, шаардлагатай үед албан тушаалаас нь зайлуулах эв найртай арга зам юм гэж хардаг.

Гэвч ажиллуулахын тулд ардчиллыг ч бас өөрийг нь хязгаарлах учиртай. Ардчилал бол бүх зүйлийг шийдвэрлэх сайн арга зам биш бөгөөд энэ нь өөр замаар бидний гаргаж чадахгүй тэр шийдвэрүүд рүү улстөрийн шийдэл оруулж ирдэг. Бас дээр ардчилал гэдэг нь 51 хувийн олонхи үлдсэн 49 хувийн цөөнхийн амьдралын бүх явдлыг шийдвэрлэж чадна эсвэл олонхи хүссэнээрээ тэр цөөнхөө мөлжиж ашиглана гэсэн үг биш: ардчилал хүлцэн тэвчих болон өөрийгөө барьж хорих соёлтой байхыг шаарддаг. Иргэд болон улстөрчид хоёулаа эдгээр хязгаарлалтыг мэдэж байх хэрэгтэй; гэвч үргэлж шахуу ардчиллын ололт амжилтад маш их бахархдаг болсон тэд улам олон зүйлийг ардчилсан байдлаар шийдвэрлэх хэрэгтэй гэж боддог. Харамсалтай нь энэ нь улам олон зүйлийг улстөрийн үйл явцаар шийдвэрлэнэ гэсэн үг бөгөөд хурцадмал байдал болон зөрчлийн үүдийг нээж, бас олонхи биднийг мөлжиж ашиглах үүдийг нээдэг.

Үндсэн хууль ардчиллын функцийг сайн гүйцэтгэдэг зүйлсэд нь төвлөрүүлэх, мөн цөөнхийг хамгаалахад туслах боломжтой. Ингэж чадахын тулд үндсэн хуулийг өргөн олноороо дэмждэг байх, энэ нь харьцангуй тогтвортой байдаг байх, мөн түүнд нэмэлт оруулахад супер-олонхийн дэмжлэг шаардлагатай байх ёстой. Гэвч ямар ч баримт бичиг хувь хүний эрхийг баталгаажуулж, капитализмыг ажиллуулдаг институтцийг хамгаалж чадахгүй. Зөвхөн зүрх сэтгэл, ухаан санаа, ёс суртахуун, соёл, хүлцэн тэвчих явдал л ингэж чадна.

ДОЛООДУГААР БҮЛЭГ: Капитализмын Ёс Суртахууны Хэмжээс

Социалист болон капиталист ёс суртахууны алсын хараа

Капитализм хэрэггүй гэж үү гэсэн нэртэй, 2014 он хэвлүүлсэн номдоо Америкийн улстөрийн ухааны эрдэмтэн Жэйсон Бреннэн (1979 онд төрсөн) социалист болон капиталист ёс суртахууныг дэмждэг гаргалгаа нотолгооны ялгааг харуулсан.

Сайхан нийгмийн тухай социалист үзэл санааг хүмүүс сайн мэддэг гэж тэрбээр өгүүлжээ. Гэр бүлээрээ аялж яваа мэт хүн бүр л сайн санааны үүднээс үйл хийж, олон нийтийн сэтгэл зүрх ч хоорондоо санал нэгдсэн зорилгын төлөө байж, зөвхөн өөрсдөөрөө зогсохгүй бас хүн бүрийн сайн сайханд зорьдог гэнэ. Капитализм хэзээ ч иймэрхүү эв зохиролтой хамтын ажиллагаатай байж чадахгүй. Учир нь капитализм өөрийн-тусыг бодох болон шунах гэсэн муу үйлд тулгуурладаг ажээ. Үнэндээ, бид капитализмыг хүлцэн тэвчиж буй цор ганц шалтгаан бол бид өөрсдөө социализмд амьдрахаар хангалттай сайн үйлтэн биш, мөн өөрийгөө-бодох үйлээ бүрэн хаяж чадах, бүгдийн ашиг тусын төлөө амьдрах ёс суртахууны тэнхээгүй байгаа явдал гэнэ.

Гэвч үүнээс дутуугүй капитализмыг өмөөрсөн гаргалгаа нотолгоо гаргах боломжтой гэж Бреннэн хэлжээ. Энэ нь харилцан хамааралтайгаар харилцан туслалцах явдалд үндэслэдэг. Мөн хүч, мөлжлөгийг капитализм үгүйсгэдэг.

Итгэлцэл болон хамтын ажиллагааг цэцэглүүлдэг, бусдаа тус хүргэдэг хүмүүсийг шагнаж урамшуулдаг. Капитализм эрх мэдэлд буй хүмүүсийн сонгож авсан зарим нэг зорилгод үйлчлэх гэж хүмүүсийг албадаж хүчилдэггүй, харин хүмүүст өөрсдийнхөө

зорилгод чөлөөтэй, найртай зорьж тэмүүлэх боломж өгнө. Энэхүү олон янз байдал бусдыг хүлцэн тэвчих, тэдний ондоо алсын бодол буюу амбиц, амьдралын хэвмаягийг хүндлэх, бас тэднийг эдийн засгийн машины зүгээр л нэг эрэг шураг гэхээсээ илүүтэй тэдэнтэй хувь хүн гэж харьцаж хандах явдлыг дэмждэг. Энэхүү хүмүүнийг хайрлах анхаарал халамж капиталист нийгмийн бий болгодог баялгийн ачаар улам хүчирхэгжсэн, иргэний нийгмийн буяны байгууллагууд, сүм хийд болон бусад сайн дурын байгууллагуудаар дамжин илэрдэг.

Капитализмын тухай энэхүү алсын хараа мөн л илүү бодитой зүйл. Капиталист зарчим зөвхөн нэг бүлэг хүмүүст биш харин дэлхийн хаана ч ажиллах боломжтой байдаг бол гэр бүлээрээ аялж буй мэт социалист загвар түүнд ямар нэг харь хүн нэмэгдэхэд бутарч сүйрдэг. Түүнд бидний ёс суртахууны доройтлыг буруутгах ямар ч үндэслэл байхгүй. Капитализм биднээс гэгээрсэн, алтруист буюу өөрийгөө золиослогч байхыг шаарддаггүй харин ч бидний заяагдмал өөрийн-тусыг бодох явдлыг нийгмийн ашиг тус болгож хувиргана. Авьяас, шаргуу байдал, эрч хүч, үр өгөөжтэй зохион байгуулалтыг шагнаж урамшуулан капитализм автоматаар биднийг шинэчлэл шинэ санаа, юм шинээр олж нээх, бусдад үйлчлэх явдал руу замчилж чиглүүлдэг.

Капитализм үнэ цэнэ бүтээж, хүмүүсийг эд баялагтай болгодог

Үнэ цэнэ бүтээж, хүмүүсийг эд баялагтай болгодог капитализмын энэ чадал бол түүний ёс суртахууны сайн зүйлсийн нэг юм. Капитализм бусад хүмүүс юу хүсэж байгааг олж мэдэж, түүнийг нь хангах сэдэл хүмүүст өгдөг. Маш бүтээмжтэй үндсэн хөрөнгө хэрэглэвэл энэ нь бидэнд зөвхөн цөөхөн хүний биш харин олон хүний хэрэгцээг хангах боломж олгоно.

Капитализмын хөгжил цэцэглэлт хүмүүний орлого болон эд баялгийг асар ихээр нэмсэнд гайхах хэрэггүй. Хүмүүний түүхийн урт замналын дийлэнхид дундаж орлого өчүүхэн байж ирсэн:

орчин үеийн ойлголтоор магадгүй өдрийн \$1-3 байв. Гэвч 1800-аад оны үеэр хүмүүсийн орлого гэнэт маш огцом өссөн бөгөөд одоо ч энэ пуужиндсан өсөлт үргэлжилсээр байна. Ядуус ялангуяа маш их хожсон: 1990 онд Дэлхийн Банкны мэдээллээр хүмүүн төрөлхтөний хүн амын ойролцоогоор 40% өдрийн \$1.90-оос бага орлоготой амьдарч байжээ; өнөөдөр энэ хувь хэмжээ 10 хувиас бага байна. Ядуурлыг сүүлийн 35 жилийн дотор өмнөх 3 500 жилийн хугацаанд бууруулсан хэмжээнээс илүү ихээр бууруулав.

Хүмүүст хүссэн болон хэрэгцээтэй илүү олон зүйлээ олж авах боломж өгөхийн хажуугаар капитализм тэр хүмүүст бүр илүү сайн зүйл худалдаж авах боломж олгодог. Өрсөлдөөн шинэ зүйл санаачлах, үнэ бууруулах, стандарт төвшнөө нэмэгдүүлэхэд хүргэнэ. Үр дүнд нь бүх амин чухал зүйлс, үүн дотор хоол хүнс, орон байр, түлш, хувцас хунар одоо өмнө байснаасаа илүү хямд, илүү сайн чанартай болсон. Дэлхий даяар цөөн хүн л 1800-аад онд шинэ мах худалдан авах чадалтай байв; өнөөдөр капиталист улс орны хэн бугай ч ингэж чадна. Британийн улстөрч, байгалийн ухааны эрдэмтэн Матт Ридлий (1958 онд төрсөн) өөрийнхөө 2011 онд хэвлүүлсэн, *Саруул ухаант өөдрөг үзэлтэн* номдоо жишээлбэл, 1800-аад онд хүн нэг лаагаар гэрээ 1 цаг гэрэлтүүлдэг, мөн энэ лаа нь түүний 6 цагийн хөдөлмөртэй тэнцэх үнэтэй байсан гэж бичжээ. Харин 1880-аад онд керосин дэнгийн гэрэл хүний 15 минутын хөдөлмөртэй тэнцэх үнэтэй болсон. Одоогийн ЛЕД гэрэл ердөө л хагас секундийн хөдөлмөртэй дүйнэ. Гэрэлтүүлгийн хувьд бид 1800 оныхоос 43 200 дахин сайжирсан эд хэрэглэж байна.

Эд баялаг асар их өссөн явдал бол хүмүүс өнөөдөр өмнөхөөсөө илүү эрүүл саруул, урт удаан амьдарч байгаагийн шалтгаан юм. Үүнийг технологийн ямар нэг гарцаагүй болох хөгжлийн үе шат гэх зүйлээр тайлбарлах боломжгүй. Эцсийн эцэст капитализмын санаачилга байгаагүй юм бол технологийн хөгжлийг юу ташуурдаж урагшлуулдаг юм бол? Яагаад Аугаа Баяжилт ийм гэнэт болчихсон юм бол? Яагаад Баруун Германчууд тансаг, өндөр технологитой Мерседес болон Би-Эм-Би унаж байхад Дорнод Европд амьдрагсад нь найдваргүй, тохьгүй, бохирдол үүсгэгч Трабант болон Юготой

болох гэж тэмцэлдэж байсан юм бол?

Сайн технологи мэдээжээр бидний амьжиргааны төвшнийг ихээр нэмэгдүүлдэг ч гэсэн капитализм л түүнийг хөгжүүлэх санаачилга бий болгодог. Өмчийн эрх үүнд мөн амин чухал: өмчийн эрх хүмүүст үр шимийг нь хүртэж чадна гэж мэддэг тул судалгаа шинжилгээ хийх, зохион бүтээх, хөгжүүлэхэд цаг хугацаа, хүчин чармайлтаараа хөрөнгө оруулах арга хэрэгсэл, итгэл өгдөг. Тэр шинэ технологи болон бараа бүтээгдэхүүн маш бүтээмжтэй капиталист үйлдвэрлэл болон зах зээлийн түгээлтээр дамжин өргөн хүрээнд хурдан тархана.

Иймээс л 1980-аад оноос хойш Хятад, Энэтхэг, Дорнод Европ болон бусад улс олон-улсын худалдаа, капиталист зарчимд нээлттэй болсноор дэлхийн ядуурал хурдтай буурч буй билээ. Сингапур, Хонг Конг, Тайван, Япон, Өмнөд Солонгос улс Дэлхийн II Дайны төгсгөлд дэлхийн хамгийн ядуу улс байлаа; гэвч арилжаа худалдаа эрхэлж, капитализмд орсон хэдхэн арван жилийн дотор дэлхийн хамгийн баян улсуудын нэг болцгоосон бол харин тэдний хөрш Хойд Солонгос, Камбож, Лаос, эсвэл бүр саяхнаас л араас нь дөхөж буй Малайз, Хятад тэгсэнгүй. Иймэрхүү жишээнүүд капитализм болон арилжаа худалдаанаас хамгийн ядуу нь хамгийн их ашиг тус хүртдэг гэсэн санааг харуулдаг. Үгээгүй ядуусын хувьд өдрийн нэмэлт \$1-ын орлого бол үхэх сэхэхийн асуудал байх боломжтой.

Өмчийн эрхээс хүртдэг хүмүүний ашиг тус

Өмчийн эрх нөөц ашиглах боломж хүмүүст зүгээр өгдөггүй. Энэ эрх тэднийг нөөцөө хамгаалах, хөгжүүлэх, өргөжүүлж томруулах санаачилгатай болгодог. Дундын буюу нийтийн өмч эсвэл хэн ч өмчилдөггүй өмчийг бодвол хувийн өмчийг илүү сайн хямгадаж хайрладаг, илүү үр өгөөжтэй хэрэглэдэг. Үүний тод жишээ бол зөвхөн өлсгөлөн болон ядуурал л бий болгосон, Зөвлөлт Холбоот Улс болон Маогийн Хятадын хамтралын сэхэх аргагүй бүтэлгүйтэл юм. Загас агнуур бол өөр нэг жишээ: хэн ч өмчилдөггүй эх далайгаас далайн загасыг голдуу хэт ихээр агнадаг. Зөвхөн Исланд,

Шинэ Зиланд гэсэн загас агнуурын усан онгоцонд арилжаалах боломжтой, үнэндээ загас өмчлөх эрх болох квот буюу олборлох эрх өгдөг газарт л загасныхаа нөөцийг сайн хамгаалж чаддаг.

Өмчийн эрх хүмүүст өөрийн сонгож авснаараа өөрийгөө илэрхийлэх, хөгжүүлэх боломж мөн өгдөг. Өмч бусад хүмүүс эсвэл бүр төрийн түрэмгийллээс хамгаалах цайз болно. Англи-Австрийн улстөрсудлалын эрдэмтэн, эдийн засагч Ф. А. Хаек (1899-1992 он) 1944 онд бичсэн *Боолчлогдох Замдаа* хүмүүс хэрэв тэдэнд дайсагнадаг төр засаг уулзалтын танхим, цаасны нийлүүлэлт, хэвлэл мэдээллийг хянадаг бол улстөрийн ондоо бодол санаагаа илэрхийлэх, түүний тухай хэлэлцэж чадахгүй гэдгийг бичсэн байдаг.

Өмч бидэн дотор заяагдмал байдаг бас нэг зүйлийг бидэнд өгдөг. Бидний өмчилдөг зүйлс бол өөрсдийн маань үргэлжлэл юм. Эдгээр зүйлд хүүхэд байхдаа цуглуулсан эсвэл дотнын найзууд бидэнд өгсөн, эсвэл бидний байсан газар орон эсвэл бидэнд тохиолдсон зүйлийг сануулдаг зүйлс орно. Тэдгээр зүйл бидэнд ямар нэг ашиг тус, тав тух, бие даасан байдал өгдөг (хөнгөн тэрэг, угаалгын машин зэрэг) зүйл байж болно. Эдгээр нь бидний өөртөө байлгаж, хямгадаж бөөцийлж, хамгаалж, хөгжүүлж буйдаа таатай байдаг зүйл байж болно: гэрийн олон эзэд, жишээлбэл, өөрсдийн гэсэн байшинтайгаа байгаадаа, олон ажил хэрэгч хүмүүс өөрийн гэсэн бизнестэй байгаадаа баяртай байдаг.

Капиталистуудыг эсэргүүцдэг зарим хүн ашиглах нөөцийг өмчлөх биш харин хуваалцаж хэрэглэх ёстой гэж батлан мэдэгддэг. Гэвч үнэ цэнэтэй нөөц бид сонгож аван хувааж хэрэглэхэд бэлэн зэлэн зүгээр л оршиж байдаггүй: ийм нөөцийг бид бүтээх ёстой. Үржил шимгүй цөл газар хэн нэгэн хүн түүний боломжийг олж харах, хөдөө аж ахуйн хэрэгцээнд хэрэглэхээр түүнийг цэвэрлэх, газрын тосны цооног өрөмдөх эсвэл түүн дээр барилга байшин барих хүртэл үр шимгүй хэвээр л байна. Хэн нэгэн хүний гүн мэдлэг болон хүчин чармайлтаас үүссэн нөөцийг хүчээр дундаа хувааж хэрэглэх нь зөвхөн шударга бус төдийгүй муу үр дагавартай: яагаад хэн нэгэн хүн хэрэв тэрбээр түүнээсээ ашиг тус хүртэхгүй бол хүчин чармайлт гаргах ёстой гэж? Тэдэнд зүгээр л бусад хүмүүсийн хүчин

чармайлтыг хуваалцах гэж дэмий сууж, хүлээх нь дээр биш үү.

Тэгш байдал ба хөгжил цэцэглэлт

Капиталист нийгмийн эд баялаг болон орлогын тэгш бус байдлын тухай олон зүйл ярьж бичдэг; мөн түүнд энэ нь хэрхэн дахин-хуваарилалтыг зөвтгөдөг тухай ч бичиж ирсэн. Гэвч бодит баримт энэ гаргалгаа нотолгоог дэмждэггүй. Тэгш бус байдлын тоо мэдээнд татварын өмнөх болон нийгмийн халамж (social welfare)-ийг тооцож үзэхийн өмнөх орлогыг голдуу авч үздэг. Гэвч хамгийн их орлого ологч хүн татвараа төлж, мөн хамгийн бага орлого ологч халамж, ажилгүйдэл, эмнэлэг эсвэл тэтгэврийн халамжаа хүлээн авсны дараа гарсан орлогын хуваарилалт капиталист болон социалист улс орнуудын хооронд бага ялгаатай байдаг. Энэхүү ялгаа хэрэв эрүүлмэндийн даатгал, сургуулийн боловсрол олгох зэрэг зүйл голдуу ордог, хамгийн ядуу хүмүүстээ үнэгүй өгдөг төрөөс-үзүүлдэг үйлчилгээг оруулж тооцвол бүр ч бага болно. Дээр нь нэмэхэд тоо бүртгэлийн мэдээлэлд ямарваа нэг динамик үр нөлөөг ерөнхийдөө үл тооцдог. Нэг жилийн судалгааны логик үндэслэлээс харвал дэлхийн хамгийн ядуу хүмүүс *Айви Лийгийн* коллеж^[1]ийг саяхан төгссөн залуу Америкчууд байдаг: тавьсан их хэмжээний оюутны зээл нь тэднийг "хасах эд баялаг"-тай болгодог; гэвч нэр хүндтэй мэргэжил эзэмшсэн, энэ бүлэг хүн эцэстээ дэлхийн хамгийн баян хүмүүс болох болно.

Тэгш бус байдал бол солилцооны жам ёсны үр дагавар юм. Мянга мянган хүн алдартай дуучны концертыг очиж үзэх гэж нэг бүр нь хэдхэн доллар төлөхөд уг дуучин тэр орой нь илүү их доллартай болж, харин үзэгчид хэдхэн доллароороо ядуурсан байна. Нэмэгдэж буй тэгш бус байдал улам их болохоос сэргийлэх цор ганц арга зам бол тэр дуучны орлогыг концерт болгоных нь дараа дахин-хуваарилах явдал байх болно. Санхүүгийн тэгш байдалтай байхын тулд дахин-хуваарилалтыг тасралтгүй хийх шаардлагатай — ингэх

1 *Ivy League colleges-Дэлхийн Чансааны эхний 20-д ордог их дээд сургууль коллеж*

нь энэ дуучин шиг хүмүүст тоглолт хийх ямар шалтгаан үлдээхгүй.

Энэ байдал бусад хүн бүрд хэлцлийн санхүүгийн бус ашиг тус өгөхгүй гэсэн үг юм. Хоёр тал үнэ цэнэ олж авахгүй бол ямар ч солилцоо болдоггүй: концертын үзэгч тэр оройгоо хэдхэн доллароо алдах ч гэлээ энэ солилцоогоор тэд өөрсдийнхөө шүтдэг хүнийхээ дуулахыг сонсож хөгжин баясаад, таашаал хүртдэг. Санхүүгийн бус үнэ цэнийг хүмүүсээс нь салгаж авах, бусдад дамжуулах боломжгүй. Үнэ цэнэтэй юмсыг тэгшитгэх гэсэн утгаар бол санхүүгийн нөөцийг дахин-хуваарьлах явдал бол хийх ажлын зөвхөн хагас нь юм.

Тэгш байдлыг тодорхойлоход гардаг бэрхшээл

Капитализмд санхүүгийн тэгш бус байдал та нар бусад хүмүүст хэр сайн эсвэл хэр муу үйлчилснийг тань илэрхийлдэг. Санхүүгийн шан урамшуулал тэр үйлчилгээний тань төлөө танд бусад хүмүүсийн өгөхийг хүсэж буй тэр зүйл юм. Ямар ч зөвлөл эсвэл хороо та нарын бусдад өгдөг үнэ цэнийг үнэлж гаргаж, мөн танд өгөх шагналын хэмжээг тодорхойлж чадахгүй: та нарын үйлчилж буй тэр л хүмүүс үүнийг шүүх болно.

Үнэндээ төрийн ямар ч зөвлөл эсвэл хороо шан урамшууллыг эрүүл саруулаар шийдэж чадахгүй. Ямар үндэслэлээр рок од, спортын алдартан, далайн гүнд шумбагч, багш, гагнуурчин эсвэл сувилагч нийгэмдээ ямар үнэ цэнэ оруулж буйг тэд тодорхойлох юм бол? Тэд хэрхэн хүн бүрд тухайн үнэ цэнийг нь илэрхийлэхээр хэр их цалин авах ёстойг яаж тодорхойлох вэ? Бүр хэрэв тэд хялбар зам сонгож хүн бүрд ижил цалин олгохоор шийдсэн байсан ч гэсэн энэ нь шударга байдал эсвэл тэгш байдалд хүргэж чадахгүй байсаар байх болно. Эцсийн эцэст, зарим мэргэжил эрсдэлтэй харин зарим нь аюулгүй байдаг; зарим таатай бас янз бүр, зарим нь уйтгартай, зовлонтой; зарим нь хялбар байхад харин заримд нь асар их анхаарал шаардлагатай байдаг; зарим ажлын байр таатай, тохитой харин бусад нь тийм биш. Ижил цалин олгох явдал психологийн орлогын эдгээр ялгааг тэнцүү болгохгүй. Гэвч капитализмд хөдөлмөрийн зах зээлийн өрсөлдөөн үүнийг автоматаар хийдэг:

хүмүүс аюултай, эсвэл таагүй эсвэл асар их чадвар шаарддаг ажил хийхдээ, жишээлбэл, илүү шан урамшуулал шаардана.

Тийм учраас капитализмыг дэмжигчид санхүүгийн дахин-хуваарилалтыг үнэ цэнэ болон шан урамшууллыг объектив байдлаар шийдэж чадахгүй учраас рационал бус зүйл гэж үздэг; санхүүгийн бус хүчин зүйлийг тооцдоггүй учраас ийм зүйл шударга бус; ийм ажлыг зах зээл илүү сайн, илүү хурдан, автоматаар хийдэг учраас ингэж дахин хуваарилах шаардлага тэнд байхгүй. Гэвч тэд бас дахин-хуваарилалт ёс суртахуунгүй зүйл гэж батлан өгүүлдэг. Хүмүүст авьяас чадвар, шаргуу хөдөлмөрийнхөө үр шимийг хүртэх эрхтэй байх ёстой. Бид бүр тэгш байдлын нэрийн дор баян чинээлэг хүмүүсээс хувь хүмүүс мөнгө хулгайлахыг зөвшөөрдөггүй. Тиймээс яагаад бид ялангуяа албан тушаалтны хүсэл зоригоор ямар ч рационал үндэслэлгүйгээр шийдвэр нь гардаг төр засагт ийм зүйл хийхийг зөвшөөрөх ёстой гэж.

Хэрэв бид нар ядууст туслахыг жинхэнээсээ хүсэж буй бол капитализм л үүний хамгийн сайн арга зам гэж харагддаг. Өнөөдөр дэлхий-дэхний арилжаа худалдааны эдийн засагт баян нь биш харин ядуу нь илүү хурдан баяжиж байна: ядууст энэ нь маш их өөрчлөлт гаргадаг. Цаашилбал, хөрөнгө түүнийг өмчилдөг хүнээр зөвхөн зогсохгүй мөн хүн бүрийг илүү баян болгодог. Бүтээмж нь нэмэгдсэнээр хөрөнгө бидэнд хэрэгтэй, бидний хүсэж буй зүйлийг илүү ихээр өгнө. Энэ явдал бидэнд илүү хялбар нөхцөлд бага ажиллаж, илүү ихийг бүтээх боломж өгдөг. Капиталист улс орнуудын иргэд илүү баян учраас тэд л буяны үйлс илүү хиймтгий, өөрсдийнхөө улам л их орлогыг буяны санд хандивладаг. Бүр сайн сайны дэмжлэг байхгүй байсан ч гэсэн баян капиталист орны ядуу хүн байх нь социалист орны ядуу хүн байхаас хамаагүй таатай байдаг (орлогын хувьд л гэхэд арав дахин ихийг олдог).

Капитализм хүмүүний харилцааг сайжруулдаг

Америкийн улстөрийн ухааны сэтгэгч Айн Рэнд (1905-82 он) капитализм тогтвортой хөгжихийн тулд хүч чадалд тулгуурладаггүй

учраас энэ бол нийгмийн ёс суртахуунтай цор ганц тогтолцоо юм гэж батлан өгүүлж байв. Үүнээс илүүтэйгээр капитализм сайн дурын солилцоогоор дамжиж зөвхөн ажилладаг. Хэнийг ч өөр хэн нэгэнтэй хэлцэл хийхийг албаддаггүй. Хүмүүсийг та нартай худалдаа хий гэж ятгахад харилцан хүндлэл, итгэлцэл шаардлагатай — эдгээр нь ялангуяа хамгийн ядуу хүмүүст үнэ цэнэтэй байдаг зүйл юм.

Капитализм ялгаварлан гадуурхах явдлыг мөн л шахан зайлуулдаг. Ямар ч хууль эсвэл ёс журам үүнийг хийж чадахгүй: тодорхой жендер, арьсны өнгө, шашин эсвэл соёлтой ажилтан авдаггүй эсвэл тодорхой хүн амын бүлгээс гаралтай хэрэглэгчдэдээ бараа бүтээгдэхүүнээ зарах эсвэл түрээслэхээс татгалздаг бизнесийн газар удахгүй энэ байдлаар ялгаварлан гадуурхдаггүй өрсөлдөгчдөдөө ялагдана. Үнэндээ дүрэм журмын зохицуулалт голдуу цөөнхөд хохиролтой байхаар хөндлөнгөөс-заасан шинжтэй (positively) байж хохирол учруулдаг: жишээлбэл, цалингийн доод хэмжээ ажил олгогч илүү их цалин өгөх хүмүүс ажилд авахад хүргэдэг тул тэд туршлагагүй, залуу хүмүүс эсвэл нутгийн хэл яриа муутай, тухайн соёлын хэм хэмжээнд дасаж дадаагүй цагаачид ажилд авч, тэднийг дадлагажуулах хүсэл багатай болгодог — эд бол энэ тогтоол шийдвэрээр туслахыг зорьж буй яг тэр хүмүүс юм.

Сонирхолтой нь капитализм эмэгтэйчүүдийн бичиг үсэгт тайлагдсан их хувь хэмжээтэй холбоотой байдаг. Энэ бол гэр бүлийн эрүүлмэнд, боловсрол, хөгжил цэцэглэлтийг тодорхойлогч чухал хүчин зүйл юм. Эмэгтэйчүүдийн бичиг үсэгт тайлагдсан байдал Сэргэн Мандалын эрин үед худалдаа наймаа өргөжихөд хурдтай нэмэгдэж эхэлжээ. Ихэнхи наймаачид эрчүүд байсан тул эхнэрүүд нь тэднийг далайд явах эсвэл бараа зарж явах хойгуур бизнесийг нь удирдаж чиглүүлэх болсон байна: тиймээс эмэгтэйчүүдийн бичиг үсэгт тайлагдаж, тоо мэддэг болох явдал өнөөдөр ч гэсэн капиталист нийгэмд байсаар байгаачлан чухал болжээ.

Адилхан зүйлийг адилхантай нь харьцуулах

Давтан хэлэхэд идеал социализмыг бодитоор байгаа капитализмтай

харьцуулах нь зүй бус хэрэг. Бас хэн ч социализмыг сайн сэдэл гэх зүйл (итгэлцэл, хамтын ажиллагаа гэх мэт)-ийн утгаар, харин капитализмыг муу зүйл (шунал зэрэг)-ийн утгаар зөв зүйтэй тодорхойлж чадахгүй. Олон хүн ингэхийг оролддог ч бодит баримт түүнийг нь үгүйсгэдэг. Үнэндээ капитализм бол итгэлцэлд тулгуурлан ажилладаг, нийгмийн эсрэг аливаа сэдлийг зүйтогтолтойгоор шийтгэж цээрлүүлдэг, нийгмийн хамтын ажиллагааны биширмээр дэг журам юм.

Капитализм бол мөн нийгмийн бодит зүйлд тулгуурладаг бодитой тогтолцоо. Энэ нь жинхэнээсээ ажиллаж буй зүйлд бидний хүчин чармайлтыг төвлөрүүлдэг — харин капитализм газар сайгүй хүн бүр сайн үйл хийдэг, өөрсдийгөө золиосолдог иргэдийн төгс нийгмийн ямар нэг загварын хэрэгжүүлэх аргагүй алсын хараанд тулгуурладаггүй. Капитализмд мөн хүмүүний мөн чанарын тухай хоосон төсөөлөл байдаггүй. Энэ нь хүмүүсийг шаргуу ятгаж эсвэл хүч хэрэглэж сахиусан тэнгэр болгоно гэж зүтгэдэггүй. Үүний оронд капитализм бидний заяагдмал өөрийн-тусыг бодох явдлыг хазаарлан авч, түүнийг нийгмийн ач тустай үр дүнд хүргэх үйлдэл рүү замчилж чиглүүлдэг. Мөн энэ бол ёс суртахууны хувьд дотоод зөрчилгүй, нийцтэй зүйл: төр хийдэг учраас хулгай дээрэм, монополь байдал, тал тохой татах (favouritism), хүч хэрэглэхийг капитализм сайн зүйл гэж үздэггүй.

Капиталист алсын хараа мөн л цөөн хүнтэй бүлгээс давж, өргөжиж тэлэмтгий байдаг. Дэлхийн дийлэнхи хэсэг аль хэдийнээ капиталист болж эсвэл капиталист улсуудтай арилжаа худалдаа хийж байна. Капитализм өмчийн эрх, шударга байдал, гэрээний тохиролцоогоо хүндлэх зэрэг нийтээр-дагадаг ёс журмын дагуу ажилладаг учраас түүнд нэгдэх хүмүүсийн тоонд хязгаар гэж байдаггүй. Гэвч нийгмийг зарим нэг хамтын зорилгоор удирдан чиглүүлэх үед нийгэм өөрөө том хэмжээтэй учраас үүнээс бүр л том асуудал гардаг. Нийгмийг төлөвлөдөг, удирдаж чиглүүлдэг тэр хүмүүс хувь хүн бүр тухайн үйл явцад өөрийн хэсэгтээ хэрхэн үйл хийх ёстойг хэлж өгөхийн тулд хамаагүй их мэдээлэл цуглуулах, боловсруулах хэрэгтэй болно. Уг нийгмийн зорилго юу байх ёстой, тэдгээрт хүрэхийн тулд юу хийх

хэрэгтэй талаар тэд асар ихээр санал зөрөлдөнө. Энэ байдал эдгээр шийдвэр гаргах, аливаа зөрчлийг арилгахдаа өршөөлгүй ханддаг тэдний удирдагчдад давуу байдал олгодог.

НАЙМДУГААР БҮЛЭГ: Капитализмын товч түүхэн замнал

Капитализмыг онолд нийцүүлж тааруулахаар мушгин гуйвуулсан нь

Карл Маркс капитализмыг зүгээр л түүх урагшлахдаа гарцаагүй туулах нэг шат гэж зөвхөн харж байсан. Аажимдаа тэрбээр капитализм дотоод зөрчлөөсөө болж нурж унан, коммунизмаар солигдоно гэж бодсон. Түүхийн энэхүү шинжилгээ одоо ч гэсэн социалистууд болон нийгмийн онолчдын дунд нөлөөтэй байсаар байна. Үр дүнд нь капитализмын тухай шинжлэх ухааны болон оюун санааны хэлэлцүүлгийн дийлэнхид түүнийг зөвхөн түүхийнх нь хөгжлийн үе шатаар хардаг байсан бол орчин үеийн капитализмын тухай хэлэлцүүлэгт түүнийг муутгаж, ганхуулж буй асуудалд л зөвхөн анхаарлаа хандуулдаг болжээ.

Урьдаас тогтсон эдгээр итгэл үнэмшил тиймээс шуудхан л шүүмжлэгчдэд нь тус болдог, капитализмын талаархи гажуудсан үзэл бодол руу хөтөлдөг. Үүнээс дор зүйл бол тэр шүүмжлэгчид өөрсдөө онолдоо тааруулах гэж бодит баримтыг ихэвчлэн гажуулдаг явдал юм. Капитализм гэж дүрсэлж тодорхойлсон эдийн засгийн тогтолцооны тухай бичсэн түүх амьдрал дээр капитализмын бодит концепцтэй бараг холбоогүй байдаг. Нэмээд хэлэхэд капитализмыг түүгээр хэзээ ч шийднэ хэлж байгаагүй нийгмийн асуудал, мөн бизнес гэхээсээ илүүтэй улстөрчдийн үйлдлээс гардаг эдийн засгийн асуудалд буруутгадаг.

Цэвэр байдлаараа хэзээ ч жинхэнээсээ оршиж байгаагүй ямар нэг зүйлийн түүх эсвэл түүний тодорхойлолтыг бичих амаргүй. Социализмын дарангуйлал, устгал сүйтгэл, геноцид буюу

үндэстнээр хоморголон устгах, экологийн сүйрэл дагуулсан алдаа, өсгөлөн, эдийн засгийн хариугүй муу өсөлт, хомсдолын түүхээс нь — өөрөөр хэлбэл түүнийг бодитоор хэрэгжүүлсэн байдлын талаархи шүүмжлэлээс социализмыг хаацайлж халхлахын тулд энэ санааг голдуу онцолж дурдаж иржээ. Гэвч капитализмын дэмжигчид бодит амьдрал дээрхи түүний илрэл жишээнээс ер ичдэггүй. Тэд капитализмд асуудал бий гэж хүлээн зөвшөөрдөг боловч тэд түүний түүх эд баялаг, ардчилал, хувийн эрх чөлөө, эв найрыг огцом нэмэгдүүлж, түгээн тархаадаг тухай байдаг гэдгийг цохон тэмдэглэдэг. Тиймээс бүр цэвэр капитализм хэзээ ч оршиж байгаагүй ч гэсэн дор хаяж түүний зарим зарчмын ямар нэг хувилбарыг хүлээн авч өөриймшүүлсэн тэр улсуудын түүхийг судалж үзэх нь сургамжтай байж болох юм.

Төрөөс-чиглүүлдэг арилжаа худалдаа

Арванзургаагаас арванесдүгээр зууны хоорондохь үе эдийн засгийн национализм болон эзэн хаад, сайдуудын эдийн засгийн хувьд хүчтэй төрт-улс байгуулах гэсэн хүсэл зоригоороо өвөрмөц байдаг. Тэр хүмүүс үүнийг аль болох их эд баялаг, алт, мөнгө хуримтлуулах, өөрсдийнхөө олох орлогоо нэмэгдүүлэхийн тулд улс орон нь бусад улсдаа аль болох их зүйл зарах, чадахынхаа хэрээр бусдаасаа аль болох бага зүйл худалдаж авах гэж ойлгож байсан. Мөн тэр хүмүүс солилцооноос зөвхөн бараа зарсан хүн л тэр наймааны эцэст мөнгөтэй хоцордог тул ашиг тус хүртдэг гэж итгэдэг байсан. Тухайн улсын санд цутгаж буй алт болон мөнгө түүний хөгжил цэцэглэлт, хүч чадлын үүсгүүр, бас хэмжээ байв.

Тиймээс худалдааны бодлого (trade policy) гадаад талдаа, арилжааны бодлого (commercial policy) дотооддоо маш их протекционист болжээ. Экспортын зах зээлд зориулсан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг хүмүүст өгөөмөр татаас санал болгож байсан; импортод өндөр тариф, бусад саад тотгор тавьж байв. Британи мэт үндэстнүүд эд баялаг нь Франц, Испани, Нидерланд зэрэг дайснууд руу урсахаас сэргийлэх гэж өөрийн колониуддаа

бусад улстай наймаа хийхийг хориглож байлаа. Бусад улсын эд баялгийг тонон дээрэмддэг дайныг үндэстний баялгаа нэмэгдүүлэх зүй ёсны арга зам гэж үзэж байв. Дотооддоо хотууд нь бусад хотынхоо үйлдвэрлэгчид болон гар урчуудад үүнтэй ижилхэн хориг саад тавьдаг байсан бол харин арилжааны эвсэл (trade associations) болох гийлд (guilds) буюу мэргэжлийн холбоод өрсөлдөгчдөө хол байлгах үүднээс өөрсдийнхөө мэргэжлийг маш чанд дүрэм журмаар зохицуулж байв. Гийлдүүд бүр эзэн хаандаа гишүүдийнхээ амьдралын хэвмаягт аюул тарьж буй хөдөлмөр хөнгөвчилсөн тоног төхөөрөмжийг хууль бус зүйл болгох шаардлага хүсэлт тавьж байсан бөгөөд бизнесийнхээ амин найзууд (business cronies)-даа цардуул, давс зэрэг амин чухал барааны монополь эрхээр шагнадаг байв.

Энэ бол меркантилизм юм — энэ бол хэрэглэгч гэхээсээ илүүтэй үйлдвэрлэгч л ашиг тус хүртэхээр зохиомжилсон тогтолцоо. Энэ тогтолцоог тэр үед бизнесийн газрууд үүсчихсэн, мөн хөрөнгө, зах зээл, үйлдвэрлэгчид, арилжаа худалдаа өргөжин тэлж байсан учраас түрүү үеийн капитализм гэж голдуу шоолж гоочилдог. Гэвч энэ нь бусад бүх талаараа капитализмын үзэл санаанаас маш ондоо зүйл байсан. Үндэстнийхээ эдийн засгийн үйл ажиллагааг залж удирдахыг эрэлхийлэхдээ эрх мэдэлд байгаа хүмүүс капитализмын энэхүү очийг бүх талаас нь хяналт, тарифаар бүслэн хаасан байлаа. Эдгээр хяналт нь эргээд энэ зорилгод төрийн албадлагын эрх мэдэл ашиглах явдлаас хамааралтай байв. Энэ явдал кронизм, хулгай, хүчирхийллийг хуульжсан үйл болгожээ. Хэрэв капитализм хаа нэгтээ орших байсан бол энэ нь зөвхөн эрх чөлөөтэй газарт, мэргэжлийн холбоод захирдаггүй, иргэдийн засаг захиргаа байдаггүй газарт, чөлөөт арилжаа, шинэ санаа шинэчлэл, шинэ үзэл санаа үүсэж гарах боломжтой хотын гадна орших боломжтой байсан.

Адам Смит *Үндэстний Баялагтаа* энэхүү меркантилист тогтолцоог задлан шинжилсэн. Тэрбээр худалдан авагчид болон юмаа худалдагчид хоёулаа сайн дурын арилжаанаас ашиг тус хүртдэг гэдгийг цохон хэлсэн: тэд үүнээс ашиг олохгүй бол

арилжаанд үл оролцдог. Юмаа худалдагч алт болон мөнгө хүлээн авч болох ч харин худалдан авагч нь төлж буй мөнгөнөөсөө илүү үнэлж үзэж буй бараа бүтээгдэхүүн эсвэл үйлчилгээ оронд нь авдаг. Арилжаа худалдаа бол бидний эсэргүүцэх ёсгүй зүйл: арилжаа худалдаа их байвал бүх улс орны иргэдэд илүү их үнэ цэнэ очиж, илүү их эд баялаг тархан түгнэ. Нээлттэй өрсөлдөөн шинэ санаа шинэчлэл, мөнгөний үнэ цэнийг тэтгэдэг. Хөрөнгө болон зах зээлээс үүсэж бий болсон төрөлжилт хүн бүрд, ялангуяа ядууст ашиг тустай бүтээмжийг асар их өсөхөд хүргэнэ. Гэлээ гээд энэ бүгдийг Адам Смит сэрэмжлүүлсэн шиг төрийн эрх мэдлээр боомилж номхруулах боломжтой — ялангуяа энэ эрх мэдлийг крони буюу амин найзуудын бизнесийн нэрийн өмнөөс ашигладаг бол, мөн нэгэнт хөлөө олчихсон үйлдвэрлэгчийг хамгаалдаг бол ийм зүйл болох нь элбэг.

Хяналт, татаас, татвар, дайн, мөн худалдаа болон үнэ цэнийн тухай балар эртний үзэл санааныхаа хамтаар меркантилизм тиймээс өнөөдөр бидний капитализм гэж нэрлэдэг "жам ёсны эрх чөлөөний тогтолцоо" ерөөсөө биш байсан. Гэвч Адам Смит гаргалгаа нотолгоо удалгүй давамгайлсан. 1860-аад онд меркантилист шинжтэй хяналтыг бага татвар, дүрэм журмын зохицуулалтыг багасгах явдлаар солив. Үр дүнд нь чөлөөт худалдааны онцгой цаг үе төрөн гарч, Британи улсад хэзээ ч харж байгаагүй эдийн засгийн хурдан өсөлт бий болжээ.

Аж Үйлдвэрийн Хувьсгал

Ихэнхи хүмүүс капитализмын тухай бодохдоо тэд арваннаймдугаар зууны сүүл болон арванесдүгээр зууны эхэн үеийн Британийн Аж Үйлдвэрийн Хувьсгалын үеийн, салхин сэнсээр ажилладаг үйлдвэрийн газар болон үйлдвэрийн хотуудын тухай, мөн Чарлз Диккенс (1812-70 он) зэрэг зохиолч, үнэндээ Карл Марксын будаж шунхадсан барзгар бараан амьдралын дүр зургийн талаар магадгүй санадаг биз ээ.

Мэдээжээр энэ цагийн үеийн эдийн засаг меркантилизмтай

гэхээсээ илүүтэй капитализмын үзэл санааны хувьд ойр үе байсан. Энэ үед хөдөө аж ахуй болон аж үйлдвэрлэлд хэд хэдэн шинэ нээлт гарсан, мөн Англиас ирсэн ноос болон Америкаас ирсэн түүхий хөвөнг хямд, сайн чанартай хувцас хунар болгоод дэлхий даяар экспортолдог, ус болон уурын хүч ашиглах шинэ технологи ээрэх болон самнах үйлдвэрийг хөдөлгөдөг болсон харьцангуй чөлөөтэй, бага татвартай эдийн засаг байжээ.

Гэлээ гээд Марксист-Диккенсч тайлбарт эдгээр биширмээр хөгжил дэвшлийн жинхэнэ мөн чанар болон үр нөлөөг асар ихээр гажуулдаг. Иймэрхүү шүүмжлэгчид Аж Үйлдвэрийн Хувьсгалыг фермийн газраа хашаалахыг зөвшөөрсөн, арваннаймдугаар зууны сүүл үеийн Хашааны Актаас үүсэлтэй гэж ойлгож байсан. Энэ гаргалгаа нотолгооны дагуу тариачин фермерүүд үүний дараачаас хөдөө нутгаасаа хөөгдөж сүйрч буй хот руу очсон бөгөөд тэндээ үйлдвэрийн эздэд хямд ажиллах хүч байдлаар мөлжлөгт орсон гэдэг.

Гэлээ гээд энэ бол хэтрүүлэг. Хашаалах явдал хурдан, бас хялбар байсангүй: тухай бүрд нь Парламентаар батлуулах, бүр эсэргүүцсэн саналыг нь авч үзэх шаардлагатай байсан. Хөдөө нутгаас хот руу чиглэсэн нүүдлийн хамгийн хүчтэй хүчин зүйл үйлдвэрийн хотууд дахь цалин илүү өндөр, газар тариаланд ажиллахаас илүү хурдтай өссөн явдал байсан юм. Аж үйлдвэрийн шинэчлэл шинэ санаа, ус болон уурын хөдөлгүүр, мэргэжлийн төрөлжилт, олон-улсын худалдаа хүмүүсийн бүтээмжийг асар ихээр нэмэгдүүлж, үүнийхээ хамтаар орлогыг нь ч өсгөсөн.

Энэ бол аж үйлдвэрийн хувьсгал хүмүүсийг хот руу, ядуурал руу хүчээр туусан тухай домог биш. 1820 оны үеэр Английн орлогын бүлэг бүрийн дундаж орлого, үүн дотроо хамгийн ядуу иргэдийн орлого хурдтай өсөж байв. Үйлдвэрийн ажил ургац нь янз бүр байдаг тариалангийн газрын улирлын чанартай ажлыг бодвол хүмүүст орлогын илүү найдвартай урсгалыг бий болгосон. Хэдийгээр үйлдвэрийн ажилчид (millworkers)-ын ажлын цаг бидний стандартаар урт байж болох ч гэлээ тариа ногооны ажлынхаас уртгүй байсан бөгөөд ажил нь өөрөө хамаагүй зүдгүүр багатай,

цаг уурын эрс ширүүн нөхцөлөөс ангид байлаа. Хотод мөн дэлгүүр хоршоо, тав тухтай орчин, бас нийгмийн амьдрал, соёлын үйл ажиллагаа, боловсролын хувьд хамаагүй их боломж бололцоо байсан. Орон байр, ялангуяа олон хүүхэд амьд үлдэж, гэр бүлүүд томрохын хэрээр давчуу болж байв; гэвч төв газрын байр сав хөдөөний ажилчдын оромжийг бодвол илүү хуурай, илүү цэвэр, илүү цэвэр цэмцгэр, илүү сайн агааржуулалттай байлаа. Хот газрын чинээлэг сэхээтнүүд хотын ядуус хэрхэн амьдарч буйг хараад цочирдож байсан — гэвч хэдхэн нь л тэдний сайн дураараа орхин явсан хөдөө нутгийн ядуурлын талаар ойлголттой байжээ.

Хотуудын бүтээсэн тэр эд баялаг хүүхдийн хөдөлмөр, ажлын цаг, цалин, орон байрны стандартын тухай шинэ хуультай хамсан ажиллах, амьдрах нөхцөл улам цааш сайжрах явдлыг өдөөсөн — энэ бүх зүйл дөнгөж өөрийгөө болгодог газар тариалангийн эрин үед боломжгүй зүйл байв. Эдгээр цалин хөлс хувцас хунар болон хотын ажилчдын өөрсдийнх нь үйлдвэрлэж буй олон бусад бараа бүтээгдэхүүний үнэ асар их хямдарч, чанар нь өссөнийг тооцвол бүр л их хэмжээгээр өсөж байжээ.

Төрөөс-удирддаг эдийн засаг

Гэвч 1880-аад оны орчим төвлөрсөн суурин газрын үйлдвэрлэлийг өргөжүүлж тэлсэн эдийн засгийн харьцангуй эрх чөлөөтэй орчин нөхцөл сэхээтнүүдийн улам бүр нэмэгдэж буй дарамт шахалтад өртөх болсон. Физикийн ухаанд гарсан амжилт нийгмийн болон эдийн засгийн амьдралыг оновчтой байдлаар, шинжлэх ухаанчаар хянаж чадна гэсэн улам нэмэгдэж буй итгэл үнэмшил төрүүлжээ. Хотын хүмүүсийн нийгэмлэг цалин хөлс, ажиллах нөхцөлийн талаар илүү чанга дүрэм журмын зохицуулалт хийхийг шаардаж, ажилчид улстөрийн хувьд нэгдэх, зохион байгуулалтад орох боломж олгосон. Европ даяархи улстөрийн хурцадмал байдал протекционист, бараг л меркантилистч бодлого дахин гарч ирэхэд хүргэлээ. Арилжаа наймаа болон худалдааг аажимдаа илүү их дүрэм журмаар зохицуулдаг болж, хорьдугаар зууны эх гэхэд засгийн

газруудыг төмөрзам зэрэг амин чухал үйлчилгээний ажиллагаанд хөндлөнгөөс оролцохыг, эсвэл бүр аж үйлдвэрийн бүх салбарын ажиллагааг хяналтаа авахыг шаардах болов.

Аугаа Хямралын дараа 1930-аад онд илүү олон улс орон энэхүү улсад хураан авах үйлдлийг улам цааш өргөжүүлэх дуртай болсон. Эдийн засагчдын шинэ давалгаа эд засгаа сэргээх эхлэл болно, мөн дараагаар нь эдийн засгаа татвар, зээл, мөнгөний бодлогоор дамжуулан "долгионыг нь нарийн тааруулна" гэсэн найдлагаар төр засгаасаа зардлаа нэмэгдүүлэхийг шаардаж шахамдууллаа. 1960-аад он гэхэд дэлхийн гаднаасаа капиталист гэж харагддаг улсууд бараг бүгд хувийн болон олон нийтийн өмчийн аж ахуйнууд зэрэгцэж оршдог, компани, ажил эрхлэлт, зах зээлийг дүрэм журмаар зохицуулдаг, засаг захиргааны "тоо хөөцөлдсөн төлөвлөлт", арилжааны протекционист саад хориг бүхий, төр засаг удирдаж чиглүүлдэг холимог эдийн засагтай үнэндээ болсон байв — энэ бүгд ерөөсөө капитализмын зарчимтай үл нийцнэ.

Гэвч энэхүү холимог зүйлээс өөрийн гэсэн асуудал бэрхшээл гарсан. Төр засгийн бодлогын хамгийн өргөн хүрээтэй үр нөлөөг буруу ойлгосон байдаг. Эдийн засгийг хурдтай идэвхжүүлдэг гэх төр засгийн зарцуулалт үнэндээ түүнийг жинхэнээсээ сүйрүүлдэг, үнийн зогсоох аргагүй өсөлтийн гал өрддөг. Төр-ажиллуулдаг, үргэлж татвар төлөгчдийн мөнгөнөөс хумслах боломжтой байдаг аж үйлдвэрүүд үр өгөөж, хэрэглэгчид үйлчлэх үйлчилгээний хувьд цуутай муу аж ахуй нэгж болцгоодог. Төлөвлөгчид зүгээр л нарийн нийлмэл эдийн засгийг удирдаж залахад шаардлагатай бүх мэдээллийг цуглуулж, боловсруулж чадахгүй. Рационал байх ёстой гэж үздэг эдийн засгийн бодлого улстөржсөн зүйл болж, шунахай ашиг сонирхлын бүлгүүдийн тэмцлийн талбар болжээ. Хөдөлмөрийн маргаан ч ихсэв. Кронизм бүх үйлдвэрлэлийг гажуулдаг болсон.

Корпоратизмын гамшиг

Энэ төрлийн кронизм буюу амин найзуудын бизнес өнөөдрийн

эдийн засгийн ноёлж буй хэлбэр болсон байж магадгүй. Олон хүн үүнийг крони капитализм (буюу амин найзуудын капитализм) гэдэг ч үүнийг харин крони социализм гэвэл илүү онох биз ээ. Энэ бол хэрэглэгчдийн эрэлтээр сэдэлжиж хөдөлж байдаг аж ахуйн эрхлэлт, шинэ санаа шинэчлэл, бүтээмж, чөлөөт зах зээл, өрсөлдөөний утгаар капитализмаас шал ондоо ертөнц юм. Харин энэ нь улстөрийн нөлөөгөө ашиглаж, эдгээр бүх зүйлд илүүтэй саад тээг болох гэсэн монополист-санаархалтай алсын бодолтой пүүсүүд юм: бизнес болон төр засгийн холбоо хэрэглэгчдийн талд байгаа гэж дүр эсгэдэг (эсвэл бүр өөрөө ингэж итгэдэг) байх боломжтой ч үнэндээ тийм биш.

Сүүлийн зуун жилийн туршид бий болсон төр засгийн өсөлт, эдийн засгийн амьдралын хэсэг бүрд нэвтэрсэн түүний нөлөөг харвал ийм данхар төрөөс гаргаж авах боломжтой арилжааны ашиг их ажээ. Засгийн газар татаас өгөх, татвар хөнгөлөх, тариф өсгөх эсвэл бууруулах, газар эсвэл мөнгө эсвэл монополь байдлын баталгаа өгөх, шинэ бизнесүүдээс арилжаа хийхдээ зөвшөөрөл авахыг шаардах, эсвэл шинэ дүрэм журам гаргах, байр сууриа олчихсон бүх пүүсүүдээс бусад нь төлөх боломжгүй цалингийн хэмжээ төр засаг тогтоох боломжтой байдаг. Төр засаг ийм пүүсүүд хоорондоо үгсэн хуйвалдахыг өөгшүүлж эсвэл бүр үнэ болон үйлдвэрлэлийнхээ хэмжээг нэг хэмжээнд тогтоон барих боломжтой төлөвлөлтийн форумд хамтдаа оролцохыг шаардаж ч чадна: энэ бол нэг төрлийн төрөөс-тэтгэдэг картел юм. Хямралаас сэргийлэх эсвэл ажлын байр хадгалах нэрийн дор төр засаг гадаад өрсөлдөгчдийнхөө үнэ эсвэл чанартай өрсөлдөж чадахгүй байгаа эсвэл бүтээгдэхүүн нь хэрэглэгчдийн эрэлтэд нэгэнт зүгээр л таарахаа байсан, муу удирдаж буй бизнесүүдийг аврах тухай амархан гэгч нь та бүхнийг ятгаж сэнхрүүлдэг.

Тиймээс хэдийгээр нэр нь хувийн пүүс боловч төр засгийн дэмжлэг, татаас, татварын хөнгөлөлт, зөвшөөрөл, өрсөлдөөн-боомилох дүрэм журмаас хамааралтай банк, авиакомпани, барилгын компани, үйлдвэрийн газар, эрчим хүч нийлүүлэгч, утсан харилцааны компани, хэвлэл мэдээллийн пүүс, эмийн үйлдвэр,

автомашины үйлдвэр, их дэлгүүр, газрын эзэд, салхин сэнсний турбины компани, автобус болон төмөрзамын тээврийн компани, бараа импортлогчид, өөр бусад компаниуд бол ийм л төрлийн картел юм.

Бүр хэрэв энэ бүгдийн анхны зорилго эдийн засгийн тогтвортой байдал, ажлын байрны баталгаа, тав тух сайжруулах, байгаль орчноо хамгаалах гэх мэт сайн санааны зүйл байсан ч гэсэн төр засгийн энэхүү өгөөмөр зангийн үр нөлөө хорлонтой муу байдаг. Энэ явдал бизнесүүдийг төр засаг руу хошууруулдаг. Энэ нь хонжоо хайх (rent seeking) гэж эдийн засагчдын хэлдэг зүйл, олон нийтийн сангаас эсвэл өрсөлдөөнийг хорьдог дүрэм журмын зохицуулалтаас урсаж гардаг хялбар ашгаа баталгаажуулах давуу эрхийн төлөө лобби хийхийг тэтгэнэ. Төр засаг данхар болох тусам ийм лобби хийх явдлын ашиг, үнэндээ авилгал болон кронизмоос гарах байж болох ашиг илүү их болдог. Үүсэж тогтчихсон буюу хөлөө олчихсон үйлдвэрлэгчийн ашиг сонирхлыг илүү их биелүүлэх тусам албан тушаалтнууд улам олширч, төр засаг ирээдүйн дүрэм журмаа хэлбэржүүлэхдээ тэднээс илүү их хамааралтай болох бөгөөд байж болох илүү олон өрсөлдөгчид зах зээлээс шахагдан гарч, шинэ технологи алсран холдоно. Хэрэглэгчдийн олон янзын ашиг сонирхлыг үл тоомсорлож, улстөрийн маргаан мэтгэлцээнд ашиг сонирхол нь нэгдмэл болсон, мөн хувь хэрэглэгчдийг бодвол илүү үр нөлөөтэй лобби хийх мөнгөтэй, ур чадвартай болсон үйлдвэрлэгчдийн лобби монополь байдалтай болдог.

Гэлээ гээд энэхүү кронизм дэлхий даяар, ялангуяа "крони капитализм" гэдэг хэллэг бат тогтсон, төр засаг нь дүрэм журам болон тарифийн хана хэрмээр хамгаалсан, салбар бүрийн "лидер" компаниудыг дэмждэг Зүүн Өмнөд Азид их тархжээ. Тэр улсуудын хувьд олон-улсад өрсөлдөж чадах хэдхэн том, хүчтэй компанитай байх нь ашиг тустай. Гэвч тэр улсуудад алдагдсан боломжийн зардлыг мартчихдаг: эдгээр том компаниудын ашигладаг хөрөнгө, ажиллах хүч, бусад нөөцийг өөр газар илүү бүтээмжтэй ашиглах боломжтой. Үнэндээ тоо томшгүй хувь хүмүүсийн олж харсан боломж бололцоо бүрийг төр засаг мэдэж чадахгүй гэдгийг бодвол

энэ нөөцийг илүү бүтээмжтэй ашиглах байсан гэдэг нь бараг л баттай зүйл юм.

Арилжааны иймэрхүү давуу эрх төр засаг нь албадлагын эрх мэдлээ ашигладаг газарт л байх боломжтой. Хувь хүний эрхийг хамгаалахад л төр засаг хүч ашигладаг чөлөөт нийгэмд ийм зүйл байх боломжгүй. Гэвч кронизм (буюу амин найзын бизнес) ийм их тархсан гэсэн бодит баримт дэлхий даяар хэр олон улс зөвхөн ачир дээрээ л чөлөөтэй байгааг илэрхийлдэг.

Ирээдүйдээ зориулж капитализмыг цогцлоохуй

Хэдий мэдээжээр олон хүн гарын уран хөдөлгөөн, эсвэл хольж хутгах замаар капитализмын идеалийг түүнд л зөвхөн байдаггүй, бас түүний үндсэн зүйл биш байдаг, бодит амьдралд гарсан олон зовлонд хамаатуулан буртаглах гэж оролдсон ч гэсэн аливаа жинхэнэ утгаар нь капитализм гэж эдийн засгийн эдгээр тогтолцоог тодорхойлоход хэцүү байна. Капитализмын дэмжигчдийн өмнө буй сорилт бол түүний цөм үзэл санааг холион бантан болон төөрөгдлөөс салгаж зааглах, цаашлаад эдийн засаг, нийгэм, ёс суртахууны бүхий л ашиг тусыг багтаасан өөрсдийн капитализмын алсын хараатай илүү ойр эдийн засгийн бүтэц тогтолцоог бодит амьдралд бий болгох явдал юм.

Мэдээжээр энэ бол өрсөлдөөнд саад болдог, кронизм болон корпоратизмыг өрддөг, төр өмчилдөг аж ахуйн нэгжийг татан буулгах, татвар, татаас, тариф, дүрэм журмын зохицуулалтыг багасгана гэсэн үг. Мөн энэ бол эрхийг нь зөрчиж, эрх чөлөөг нь хумихын оронд хүмүүсийн эрх, эдийн засгийн эрх чөлөөг хамгаалахаар төрийг хязгаарлана гэсэн үг. Энэ бол төр болон эдийн засгийн амьдралыг хооронд нь зааглана гэсэн үг юм.

Энэ бол улам л олон шийдвэрийг улстөрийн үйл явцаар шийддэг, олонхи нь цөөнхидөө бүхий л төрлийн эдийн засгийн бодлогоо тулгаж хэрэглэх эрхтэй байдаг хязгааргүй-эрх мэдэлтэй ардчиллын үед хүрэхэд хялбар биш зорилго байх болно. Энэ бол ардчилал биш харин төрийн албадлагын эрх мэдлээр дэмжлэг авсан популизм

бөгөөд энэ нь яагаад Америкийн Нэгдсэн Улсын үндэслэгчид төр засгийнхаа иймэрхүү эрх мэдэлд тийм чанд хязгаарлалт тавьсан, өөр өөр институтүүдийнх нь хооронд эрх мэдлийг салгаж заагласны учир шалтгаан юм. Гэлээ гээд тэнд ч гэсэн эрх мэдэл төвлөрч, нэг дор бөөгнөрчихжээ.

Энэ бүгд хэрэв зөвөөр ойлговол кронизмын төгс нөхцөл, харин капитализм оршин тогтнох боломжгүй нөхцөл байдаг. Бүх алдаа дутагдлынх нь хамтаар кронизмыг капитализмаар гэхдээ ашиг тусыг нь цогцлоож солино гэдэг бол улстөрийн үйл явцын хязгаарлалт, хязгааруудын талаар тогтолцооны хэмжээнд дахин эргэцүүлж бодно гэсэн үг юм.

ЕСДҮГЭЭР БҮЛЭГ: Капитализмын Тухай Өгүүлсэн Аугаа Сэтгэгчид

Саламанкийн Сургууль ('Схоластууд буюу Сургуультнууд')

Өмч, нийлүүлэлт, эрэл, хүүгийн хэмжээ

Арвантавдугаар болон арвандолоодугаар зууны хооронд Испанийн санваартнууд эдийн засгийн ухааны ойлголтод хэд хэдэн чухал дэвшил гаргасан бөгөөд капитализмыг түүнийг голдуу шүүмжилдэг гэж харагддаг Загалмайтны сургаалуудад нийцүүлэх боломж олгосон. Жишээлбэл: Схоласт буюу сургуультнууд гэдэг хүмүүсээс анх Франциско де Витория (1483-1546 он)-д хандаж Бурхан болон Сүм тэдний арилжаа худалдааг хэрхэн үзэх бол гэж түгшсэн наймаачид түүнд зөвлөгөө өгчээ. Витория энэ хэрэг явдлыг бодож үзээд хүмүүс, бараа бүтээгдэхүүн, үзэл санааны чөлөөт шилжилт хөдөлгөөн бол Жам Ёсны нэг хэсэг, Бурханы бүтээл гэж дүгнэсэн. Тиймээс наймаачид муу хүмүүс байсангүй харин үнэндээ бүх хүний сайн сайханд үйлчилдэг хүмүүс байв.

Библийн сургаалд — мөнгө хүүлэх — ө.х. зээлээс хүү авахыг нүгэл гэж шүүмжилдэг байсан. Гэвч Схоластуудын үед Сэргэн Мандалтын Эрин ажил хэрэгч үйл ажиллагаанд олон боломж авчирсан бөгөөд зээллэгийг санхүүжүүлэх нь бизнес явуулах болон наймаа хийх маш чухал үйл ажиллагаа болжээ. Аз болоход Схоластууд зээлийн хүүгийн хэмжээг зөвтгөх олон арга зам олсон. Тэдний тэмдэглэж хэлснээр энэ нь зээлдэгчдэд ч ашиг тустай байдаг сайн зүйл ажээ; хүүгийн хэмжээ бол зээл нь муудаж буцааж авч чадахаа байх эрсдэлийн төлбөр — ө.х. нэмэлт төлбөр юм; нэгэнт тухайн мөнгөө ашиглах боломжтой өөр олон хэрэглээ байдаг учраас зээл олгогчийн

хувьд энэ нь "алдагдсан боломжийн зардал" байдаг; мөнгө өөрөө бараа бөгөөд бусад барааны адилаар түүнийг зээлдэхдээ та нар төлбөр төлөх ёстой.

Схоластууд буюу сургуультнууд мөн хувийн өмчийг хамгаалж байсан. Тэд хувийн өмч эдийн засгийн үйл ажиллагааг, үүнээс улбаалаад хөгжил цэцэглэлтийг тэтгэдэг ашиг тустай гэж батлан өгүүлж байлаа. Хүмүүс бусадтай хуваалцаж хэрэглэдэг зүйлээс илүү өөрийнхөө өмчилдөг зүйлээ хямгадаж бөөцийлдөг бөгөөд энэ нь өөрөөр хэлбэл Бурханы бүтээлийг илүү сайн хамгаалж байгаа гэсэн үг ажээ. Схоластууд хувь хүмүүс тэд хэрэгцээтэй зүйлээ бусадтай хуваалцах үүрэггүй байхдаа, онцгой байдлаас бусад үед өмч өмчлөх, өмчийнхөө ашиг тусыг хүртэх эрхтэй гэж дүгнэсэн.

Бүр энэ Сургуультнууд эрэлт, нийлүүлэлтийн ач холбогдлыг таньж мэдсэн байв. Тэд үнэт метал эдгээр зүйл ховор байдаг улс орнуудад илүү их үнэтэй байгааг олж харсан байсан. Бараа бүтээгдэхүүний "шударга үнэ" зөвхөн түүнийг үйлдвэрлэх, тээвэрлэх зардал биш — маалинган даавуу түүнийг далайгаар хямд тээвэрлэж болох байсаар байтал хуурай газраар өндөр үнээр тээвэрлэсэн бол яагаад далайгаар тээвэрлэснээсээ илүү үнэтэй байх ёстой гэж? Хэрэв зах зээл чөлөөтэй, нээлттэй байвал нийлүүлэлт болон эрэлтийн харилцан холбооноос үнэ хамаардаг гэж байв.

Адам Смит (1723-90 он)

Төрөлжилт, арилжаа худалдаа, чөлөөт худалдааны ашиг тус

Эдийн засагч болсон, Шотландын философич Адам Смит *Үндэстний Баялаг* (1776 он) номоороо ихэд алдартай болжээ. Түүндээ тэрбээр өөрийн болон бусад зохиогчийн санаануудыг эдийн засагт хандах шинэ, зүйтогтолцоожуулсан, орчин үеийн хандлага болгож нэгтгэсэн. Энэ номоороо тэр үед давамгайлж асан, үндэстний баялгийг цуглуулсан алт мөнгөний хэмжээгээр хэмждэг, экспортын борлуулалтаа хамгийн их болгохын тулд татаас өгдөг, импортын худалдан авалтыг хаах гэж тариф ашигладаг меркантилизмын

тогтолцоо руу довтолжээ. Смит арилжаа худалдаанаас хоёр тал хоёулаа ашиг тус хүртдэг гэж цохон хэлсэн. Үнэндээ аль нэг тал нь түүнд ашиг тус гарахгүй бол худалдаа хийхгүй. Юмаа зарагч хүн бэлэн мөнгө авч буй нь үнэн: гэвч худалдан авагч төлж буй мөнгөнөөс илүү үнэлж үзэж буй бараагаа мөнгөнийхөө оронд авдаг.

Смит улс орныг баян болгодог зүйл бэлэн мөнгө хадгалах явдал биш харин үйлдвэрлэл, арилжаа, наймааны далайц гэж дүгнэсэн — энэ бол бидний одоогийн үндэстний дотоодын нийт бүтээгдэхүүн эсвэл ДНБ гэж дууддаг зүйл юм.

Тэрбээр биднийг чадвартай, илүү бүтээмжтэй болгодог, мэргэжил зэрэг зүйл төрөлжих явдал үйлдвэрлэлийг ихээр нэмэгдүүлж чадна — ялангуяа бүр багаж хэрэгсэл болон тоног төхөөрөмж зэрэг тодорхой үндсэн хөрөнгөд хөрөнгө оруулбал үүнийгээ асар ихээр нэмэгдүүлж чадна гэдгийг ажигласан. Төрөлжсөн хөдөлмөрөөрөө бүтээсэн бүтээгдэхүүнээ дотооддоо эсвэл гадаадад бусадтайгаа солилцох замаар бид бүгдээрээ энэхүү төрөлжих явдал болон үндсэн хөрөнгөд хөрөнгө оруулсан явдлаас бий болдог асар их бүтээмжээс өгөөж хүртэнэ.

Чөлөөт худалдаа, өрсөлдөөн байдаг газарт зах зээл хүчин чармайлт болон ашиглах нөөцийг хамгийн бүтээмжтэй хэрэглэгч рүү залж чиглүүлдэг бөгөөд бэлэн болсон бараа бүтээгдэхүүнийг тэдгээрийг хамгийн их хүсэж байгаа хүн рүү нь хүргэдэг. Энэ нь хүмүүсийг маш ихээр хамтран ажиллууламтгай тогтолцоо боловч зөвхөн үйл чөлөөтэй хийдэг, чөлөөт худалдаа, чөлөөт өрсөлдөөн байдаг газарт л ажилладаг. Смит үйлдвэрлэгчид нь монополий эрх авах эсвэл тусгай дэмжлэг авах гэж улстөрчдөдөө дарамт шахалт үзүүлдэг крони капитализмыг маш их шүүмжилдэг байсан.

Төр засаг ажиллах боломж олгодог тухайн бүтцүүдийг нь сахин хамгаалахаас бусдаар эдийн засгийн амьдралд хөндлөнгөөс оролцох ёсгүй гэж тэрбээр дүгнэж байлаа.

Дэвид Рикардо (1772-1823 он)

Харьцуулсан давуу тал болон бүтээмжтэй үр ашиг

Лондон хотын амжилттай хувьцааны брокер, дамчин байсан (түүнийг Британи улс Ватерлоод ялахад мөрий тавьж 11 сая фунт олсон гэж ярьцгаадаг) Рикардо эдийн засгийн ухааны талаар Адам Смитийн *Үндэстний Баялаг* номыг уншсанахаа дараа бодож эхэлжээ. Тэрбээр рент, цалин, ашиг, татвар, үнэ цэнийн тухай онолд хэд хэдэн хувь нэмэр оруулсан.

Худалдааны бодлогын талаар тэрбээр улаан буудайн импортыг хязгаарласан *Үр Тарианы Хууль* зэрэг протекционист арга хэмжээг эсэргүүцэж байв; түүнийг алдаршуулсан, "харьцангуй өртгийн онол" (одоо харьцуулсан давуу талын онол гэж нэрлэдэг болсон)-оо Рикардо боловсруулж хөгжүүлсэн. Тэрбээр улс орнууд бүх зүйлийг үйлдвэрлэж чадах байсан ч бусад улсуудыг бодвол - тэд харьцангуй хямд үйлдвэрлэж чадах зүйлийг үйлдвэрлэхээр төрөлжвөл - илүү баян болох боломжтой гэж хэлсэн. Дээр нь хэрэв тэр улс бусдаасаа бүх зүйлийг илүү хямд үйлдвэрлэж чаддаг байсан ч тэд - заавал абсолют биш ч гэлээ харьцангуй давуу талтай байдаг - тэр л бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхээр төрөлжиж чадвал бүр илүү баян болох болно.

Орчин үеийн жишээ дурдая: алдартай кино жүжигчин кино студийн ахлах тогоочийг бодвол илүү сайн хоол хийдэг байж гэе. Гэлээ гээд тэр ахлах тогоочоос абсолют байдлаар давуу байгаа ч гэсэн тэр кино студи уг од жүжигчнээ гал тогоо руугаа явуулж ажиллуулснаас кино талбайд байлгаж авьяас болон нэр хүндийг нь ашиглавал илүү их мөнгө олох болно. Энэхүү зарчим бол чөлөөт худалдааг дэмждэг гаргалгаа нотолгооны гол үндэс суурийн нэг юм.

Лүдвиг фон Мизэс (1881-1973 он)

Хөрөнгийн мөн чанар; социализмын тухай шүүмжлэл; лэзе-фэ-ерийн ашиг тус

Мизэс эдийн засгийн юмс үзэгдлийн нарийн нийлмэл байдлыг тодосгож харуулдаг, мөн сая сая хувь хүмүүсийн өгч буй үнэ цэнэ болон үйлдэл хэрхэн нийт гарах үр дүнд чухал байдаг гэдгийг цохон тэмдэглэдэг, эдийн засагчдын "Австри Сургууль"-ийн тэргүүлэх зүтгэлтэн болсон. Жишээлбэл, хөрөнгийн хувьд нийт үнэ цэнэ нь биш харин түүний бүтэц чухал байдаг — чухам ямар үндсэн хөрөнгөд хүмүүс хөрөнгө оруулсан, эдгээр үндсэн хөрөнгө хамтаа хэрхэн үр бүтээлтэй ажилладаг вэ гэдэг нь чухал. Иймэрхүү бүтэц эмзэг нарийн зүйл: жишээлбэл, зээлийн хүүгийн хэмжээний оновчгүй бодлого зах зээлийг бусниулж, үүн дотроо хүмүүсээр буруу хөрөнгө оруулалт хийлгэж, тэднийг алдагдалд оруулдаг.

Коммунизм зэрэг зах зээлийг бүрэн устгасан газарт ухаалаг хөрөнгө оруулалт байх боломжгүй. Үнэ байхгүй бол хэн ч үйлдвэрлэлийн байж болох олон үйл явцуудаас аль нь хамгийн зардал-багатай болохыг тооцоолж чадахгүй. Ашиглах нөөцөөрөө гарцаагүй буруу үйл явцад хөрөнгө оруулж, энэ нь хаягдал болж, үр ашиггүй үйл хэрэг болох бөгөөд гаргаж буй алдаа нь хугацаа өнгөрөхийн хэрээр хуримтлагдаж өснө — учир нь эдгээр алдааг устгах шахалт дарамт хүмүүст үзүүлдэг зах зээл тэнд байдаггүй.

Мизэс төр засаг зах зээлийн тогтолцоог хяналт болон дүрэм журмын зохицуулалтаар саатуулж хорьж эхэлмэгц цөөрөмд усны долгио тардаг шигээр нэг зах зээлийг нөгөөгийнх нь араас бусниулах зэргээр зах зээлээс зах зээл рүү тархдаг (илүүдэл болон хомсдолын адил) тэнцвэргүй байдлын түрлэгийг бий болгодог гэж батлан өгүүлж, лэзе-фэерийг дэмждэг ул суурьтай гаргалгаа нотолгоог гаргасан. Хор хохирлыг нь хязгаарлах гэж оролдохдоо төр засаг юмсыг улам л муутгаж, улмаар хөндлөнгөөс улам их оролцох ёстой болдог байна.

Ф. А. Хаек (1899-1992 он)

Өөрөө-үүсдэг дэг журам; төлөвлөлтийн тухай шүүмжлэл; зах зээлийн уялдаа зохицолдоо

Лүдвиг фон Мизэсийн шавь, Вена хотын уугуул Хаек түүнтэй огцом өсөлт-хямралын бизнесийн мөчлөгийн талаархи судалгаанд хамтран ажилласан бөгөөд эдгээр мөчлөг төв банк хүүгийн хэмжээг хэт бага болгож, илүү ихээр зээл авах, зарж үрэх явдлыг тэтгэхэд бий болдог гэж дүгнэсэн. Гэвч хүүгийн бага хэмжээ мөн л хадгаламждаа мөнгө хийх явдлыг урамгүй зүйл болгон, зээлдэгчийн зээлдэх санг ширгээн хатааж, хөрөнгө оруулагчийг зээлийн хямралд оруулах бөгөөд тэд ч өөдрөгөөр харсан хөрөнгө оруулалтаа зогсооход хүрч, хөрөнгө болон ажлын байр үрэгдэж байхгүй болдог.

Хаекийн гүн мэдлэгийн нэг бол өөрөө-үүсдэг дэг журмын тухай концепц юм. Хүмүүний нийгэм болон амьтны аймагт илэрхий давтагддаг зүйтогтол харагддаг. Гэлээ гээд хэн ч зөгийнүүдийн амьдралыг эсвэл хүмүүс хэл яриагаа хэрхэн хэрэглэхийг төлөвлөж заагаагүй. Иймэрхүү дэг журам жам ёсоороо үүсэж гардаг бөгөөд эдгээр нь хэрэгтэй байсан учраас тэсэж үлддэг. Бид голдуу эдгээрийн үндэс суурь болсон ёс журам (хэлний дүрэм зэрэг)-ыг бүр үгээр ч зүйлчилж томьёолон гаргаж чаддаггүй. Нэгэнт байгальд оршдог дэг журам хэрхэн ажиллагчийг бүрэн ухаж ойлгоогүй тул бид илүү сайн зүйл хийж чадна, жишээлбэл, цалин болон үнэд хяналт тогтоож үнийн механизмыг сольж чадна, эсвэл эдийн засгийг төвлөрсөн байдлаар төлөвлөж чөлөөт зах зээлийг сайжруулж чадна гэж төсөөлөх нь хэтийдсэн бардамнал юм.

Хаекийн үзэл бодлоор бүр эдийн засгийг төлөвлөгч хүн иймэрхүү ажилд шаардлагатай мэдлэгтэй болж ч чаддаггүй. Учир нь ийм мэдлэг сарниж тархсан, хэсэг газарт байдаг, хэсэгчилж оршдог, хурдан өөрчлөгддөг, тусгай, хувь хүн л мэддэг, дамжуулахад хэцүү байдаг. Гэлээ гээд зах зээл эдгээр бүх мэдээлэлтэй агшин бүрд, сарниж тархсан нутаг орчны төвшинд харьцдаг. Ямар ч төлөвлөгч хүн ашиглах нөөцийг хэрхэн хэрэглэх ёстой гэдгийг

шийдэх шаардлага байхгүй: үнэ эдгээр нөөцийг хамгийн их үнэ цэнэтэй хэрэглээ рүү автоматаар замчилж чиглүүлдэг, энгийн дохио дамжуулдаг. Зах зээл тийм учраас хамаагүй илүү бүтээмжтэй байдаг бөгөөд төлөвлөлтийн аливаа тогтолцооноос хамаагүй том болж өсөж томорч чаддаг.

Милтон Фрийдмэн (1912-2006 он)

Баталгаажсан мөнгө (solid money)-ний ач холбогдол; дүрэм журмын зохицуулалтын өртөг

Фрийдмэн либерал үзэл санааг тайлбарлаж ятгах онцгой авьяастай хүн байсан. Эхнэр Рөүзийнхээ хамтаар бичсэн, *Капитализм ба Эрх Чөлөө* (1962 он) гэсэн ном, *Сонгох Эрх Чөлөө* (1980 он) гэсэн телевизийн цуврал нэвтрүүлэг, бусад номоос нь чөлөөт зах зээл, нээлттэй арилжаа худалдаа, эрх чөлөө, капитализмын нөөц бололцооны талаар олон сая хүн сурч мэдсэн.

1946 онд Фрийдмэн түрээсийн хяналтаас эрс шууд татгалзах санал боловсруулах үйл хэрэгт хамтран ажиллаж байв. Иймэрхүү бодлого байрны эздийг өмчөө тордож сайжруулах, түрээслэхдээ хойрго болгодог, бэлэн байгаа орон сууцны чанар болон олдцыг хоёулыг хорогдуулдаг гэдгийг тэрбээр ажиглаж мэджээ. Фрийдмэн мөн (эмч, хуульч, нягтлан бодогч гэх мэт) ажил мэргэжлийн дүрэм журмын зохицуулалт, лиценз олгох явдлыг судлаад, үүнээс олон нийт хождоггүй харин тэр мэргэжлээр ажиллагсад л хождог гэж дүгнэв. Өрсөлдөөнийг лицензээр хориглосноор хэрэглэгчдийг илүү муу чанартай үйлчилгээний төлөө төлбөр төлөх гэж албаддаг гэдгийг тэрбээр олж харсан.

Фрийдмэнийг мөнгөтэй-холбоотой бодлого, түүнээс инфляцад үзүүлдэг нөлөөний талаархи судалгаагаар нь хамгийн сайн мэддэг — энэ бол хорьдугаар зууны сүүлээр гарч буй гол асуудал бэрхшээл юм. Тэрбээртөр засаг инфляцийг татварлах, зардал гаргах явдлаараа дамжуулж хянах боломжтой гэсэн нийтээр хүлээн зөвшөөрсөн үзэл бодлыг үүний оронд төр засаг эргэлтэд буй мөнгөний тоо хэмжээг

хянах хэрэгтэй гэж батлан хэлж шүүмжилж байжээ. Гэвч мөнгөний бодлого маш бүдүүлэг багаж хэрэгсэл тул төр засаг зүгээр л институтийн-хэмжээний найдвартай бүтэц бий болгон, эдийн засагт байнга хөндлөнгөөс оролцохоо болих хэрэгтэй.

Жэймс М. Бюканэн (1919-2013 он), Гордон Таллокк (1922-2014 он)

Улстөрийн шийдвэр гаргах явцын тухай шүүмжлэл

Бюканэн болон Таллокк хоёр зах зээлийн бүтэлгүйтдэг учраас төр засаг хөндлөнгөөс оролцох ёстой гэсэн үзэл санааг эрүүл тулаанд дуудсан, эдийн засгийн *Олон Нийтийн Сонголтын Сургуулийг* үүсгэж хөгжүүлсэн. Юуны урьд тэр хоёр төр засгийн бүтэлгүйтэл л юмсыг бүр илүү муутгадаг гэдгийг тайлбарлаж байлаа. Учир нь шийдвэр гаргах үйл явц өөрийн-тусыг бодох явдал болон ашиглаж шамшигдуулах үйлдэлтэй нягт сүлжилдсэн байдаг ажээ.

Завхрал сонгуулиас л эхэлдэг. Бюканэн болон Таллокк нар сонгууль бол "олон нийтийн ашиг сонирхол"-ын шалгуур биш харин хоорондоо өрсөлдөж буй ашиг сонирхлуудын тэмцээн гэж цохон тэмдэглэсэн. Капитализмд хүмүүс сонгож авсан өөр өөр бараа бүтээгдэхүүн олж авах боломжтой. Сонгуульд олонхи нь хүн бүрийн өмнөөс энэ сонголтыг хийдэг — мөн тэд төрийн хүчийг ашиглаж цөөнхиө ашиглаж мөлжиж чадна — капитализмд үйлдвэрлэгчид ийм зүйл хийж чадахгүй.

Сонгуульд ашиг сонирхол нь сарниж тархсан, хүчгүй байдаг хүн амын нийт олонхи гэхээсээ илүүтэй гаргах үр дүнд анхаарлаа онцгойлон хандуулдаг, хүчтэй тусгай ашиг сонирхол бүхий тусгай-ашиг сонирхлын бүлэг хүмүүс байнга шахуу давамгайлдаг. Бүр хамгийн олон нийтийг гэх сэтгэлтэй улстөрчид ч гэсэн сонгогдохын тулд эдгээр ашиг сонирхлын бүлэгт буулт хийх хэрэгтэй болно. Бодлого юу рационал зүйл болох тухайд биш харин юу ашигтай вэ гэдэгт л төвлөрдөг.

Цаашилбал, арга хэмжээгээ хууль тогтоох байгууллагаар батлуулахын тулд улстөрчид ерөнхийдөө хамтрагчид болон бусад хууль тогтоогчдынхоо дэмжлэгийг бататгах гэж илүү ихээр харилцан тохиролцох ёстой болдог. Тэд бусадтайгаа "Та нар миний арга хэмжээний төлөө саналаа өгнө, харин би та нарын арга хэмжээний төлөө саналаа өгнө" гэсэн хэлцэлд орох ёстой болж болно — энэ нь хүн бүр жинхэнээсээ хүсэж байснаас илүү олон тогтоол шийдвэр хууль тогтоогч бүр гаргуулан авна гэсэн үг юм. Эцэст нь хэлэхэд тогтоол шийдвэр хэрэгжүүлдэг албан тушаалтнуудад энэхүү ухаалаг бус үйл явцаас гардаг өөрсдийнхөө тодорхой ашиг сонирхолдоо хүрэхээр тэмүүлдэг: жишээлбэл, тэд дүрэм журмыг маш нийлмэл болгон, тэдгээрээ захирч удирдахын тулд илүү олон албан хаагч шаардах замаар өөрсдийнхөө захиргаадалтын эзэнт гүрэн (bureaucratic empires)-ээ өргөжүүлж тэлэхийг эрэлхийлж болно.

Капитализм төгс бүс байж болно гэж Бюканэн, Таллокк нар дүгнэсэн: гэвч бас бид түүнийг орлуулах ямар нэг хувилбар зүйл рүү шунаж харах ёсгүй ажээ.

Гари Беккер (1930-2014 он)

Хүмүүний капитал; нийгмийн асуудлын талаархи эдийн засгийн шийдэл

Милтон Фрийдмэний шавь, Америкийн эдийн засагч Гари Беккер эдийн засгийн концепцыг нийгмийн олон өөр асуудалд, үүн дотроо эрүүгийн хэрэгтнүүдийн сэдэл, цөөнхийг ялгаварлан гадуурхахын эсрэг болон цагаачлалд хэрэглэж шинэ зам гаргасан. Гэвч түүнийг хэдийгээр энэхүү богино хэллэгийг өөрөө гаргаагүй ч гэсэн *хүмүүний капиталын талаархи бүтээлээр нь хамгийн сайн мэддэг.*

Хүмүүний капитал бол хувь хүмүүсийг илүү бүтээмжтэй болгодог зан чанар, мэдлэг, чадвар юм. Түүнд боловсрол болон сургалтад хөрөнгө оруулах явдал ордог ч гэсэн цаг барьдаг, шаргуу байдал зэрэг сайн зан чанар, бүр сайн эрүүлмэнд ч багтдаг. Беккер

хүмүүний капиталын хоёр төрлийг ялгаж гаргасан. Үүнд: *тусгай* болон *ерөнхий* төрөл хамаарна. Хүмүүний тусгай капитал бол зохих програм хангамж хэрхэн хэрэглэх зэрэг тодорхой бизнест тохиромжтой байдаг мэдлэг юм. Пүүс тэр ажилтан нь компаниас явсан ч гэсэн энэ мэдлэг өрсөлдөгчид нь хэрэгцээгүй зүйл гэдгийг учраас энэ мэдлэг олж авахад нь тусалж ажилчдынхаа өмнөөс төлбөр төлдөг. Хүмүүний ерөнхий капитал бол түргэн бичиж чадах зэрэг хаана ч ашиглах боломжтой мэдлэг юм. Пүүсүүд иймэрхүү шилжүүлэн явж боломжтой чадвар эзэмшүүлэх гэж мөнгө төлөх хүсэлгүй байдаг тул хүмүүс ийм чадварыг ерөнхийдөө өөрийнхөө зардлаар голдуу олж авдаг.

Беккерийн энэ судалгааны хандлага бусад олон гүн мэдлэг өгсөн. Жишээлбэл, тэрбээр хүмүүс яагаад өнөөдөр өмнөх үеийнхнээсээ илүү цаг хугацааг боловсролдоо зарцуулж байгаагийн гол шалтгаан бол тэд илүү урт насалдаг болсон, мөн шилжүүлэх боломжтой чадвараас нь гарах боломжтой ашиг тусыг урт хугацаанд авах, бас нэмэгдүүлэх явдал юм гэж өгүүлжээ. Технологийн дэвшил мөн л илүү нарийн мэдлэг болон өндөр-технологийн чадвар олж авах явдлыг илүү их ашигтай болгосон. Учир нь эдгээр нь хүнийг илүү их бүтээмжтэй, илүү их үнэ цэнэтэй болгодог. Хүмүүний капиталын тухай ойлголт яагаад бүр илүү олон эмэгтэй өмнөх үеийнхнээсээ илүү боловсролтой болж байгааг тайлбарлахад тус болсон. Энэ бол зөвхөн социологийн өөрчлөлтийн хэрэг явдал биш бас гэр орон нь автоматжсан учраас эмэгтэйчүүдэд ажлын замналаа хөөх цаг хугацаа гарсан явдал юм.

Эцэст нь хэлэх хамгийн сүүлийн гэхдээ амьдралд хэрэгтэй чухал нэг дүгнэлт байна. Технологи улам бүр хурдан өөрчлөгдөхийн хэрээр хүмүүст шинэ чадвар эзэмших, хүмүүний капиталаа шинэчилж сайжруулах боломж олгодог, бүх насаараа суралцах хэрэгцээ одоо гарч байна гэдгийг Беккер хэлсэн.

Израэл Кирцнер (1930 онд төрсөн)

Ажил хэрэгч байдлын үүрэг нөлөө; динамик үр дагаврын ач холбогдол

Лондонд төрсөн Кирцнер Нью Йорк хотод Лүдвиг фон Мизэсийн удирдлага дор суралцжээ. Мизэсийн адилаар тэрбээр стандарт ‘статик тэнцвэр’-ийн загвар эдийн засгийн хөдөлгөөнт мөн чанарыг алдагдуулсан гэж батлан өгүүлж байсан. Эдийн засгийн үйл ажиллагаа хэзээ ч ямар нэг төгс тэнцвэрт оршдоггүй: үүний эсрэгээр хувь хүмүүс өөрсдийн төлөвлөгөөгөө байнга залруулж, үйлдлээ бусдынхаа үүнтэй адилхнаар өөрчлөгдөж буй үйлд тохируулдаг ажээ. Энэхүү динамик үйл явц хэдийгээр төгс биш ч байнга тэдний үйлдлийг уялдуулж зохицуулж байдаг.

Кирцнер ажил хэрэгч байдал энэхүү уялдуулж зохицуулах үйлдлийг сэдэлжүүлэх, сахин хамгаалах, сайжруулахад чухал үүрэгтэй гэж тайлбарласан. Ажил хэрэгч байдал бол (заавал мэргэжлийн ажил хэрэгч хүмүүс биш бас жирийн хүмүүс ч тэр) хувь хүмүүс зах зээл дэх хоосон зай болон үл нийцлийг олж нээдэг, дараагаар нь түүнийг нөхөх, залруулах гэж үйл хийдэг үйл явц юм. Жишээлбэл, хэн нэгэн хүн шинэ хэрэглэгдэхүүн тодорхой бараа бүтээгдэхүүнийг илүү хөнгөн эсвэл илүү бат бөх болгох боломжтой гэдгийг олж харж ч болох юм; өөр нэгэн нь шинэ оффис барих явдал тэр орчмын кофе шопын хэрэгцээг нэмэгдүүлнэ гэдгийг олж харах боломжтой; бас нэг нь олонд алдартай нутгийн нарийн боовны газар үндэстний хэмжээний сүлжээ болж чадна гэдэг итгэж ч болно. Тэд өөрсдөдөө ажил хэрэгч байдлын ашиг хийхээр шулуудан эдгээр таамаглалдаа үндэслэж үйл хийж ч болно: гэвч ингэж хийх үедээ тэд үйлдвэрлэлийг олон нийтийн янз бүрийн хэрэгцээ, хүсэлд нийцүүлж тааруулан хүмүүний эдийн засгийн үйл ажиллагааг уялдуулж зохицуулахад тус болдог.

Энэ байдал эргээд эдийн засгийн тохируулга, уялдаа холбоо өөр өөр хүмүүст байх боломжтой зах зээлийн нөхцөлийн талаархи тухайн орон газрын мэдлэгээс хүчтэй хамаардаг болохыг харуулдаг.

Гэвч үүнийг давамгайлж буй эдийн засгийн ухааны "төгс мэдээлэл"-ийн тухай санаанд зүгээр л мартчихсан байдаг. Энэ нь мөн бидэнд энэхүү ажил хэрэгч зүрх сэтгэлийг цэцэглүүлэхийн тулд бид зөв бодлого, институт, нээлттэй зах зээлээ байх газарт нь байлгах ёстой гэдгийг сануулдаг.

Деирдре МакКлоский (1942 онд төрсөн)

Либерал үнэт зүйлс, эдийн засгийн өсөлт

МакКлоский эр хүн болж төрсөн ч 53 насандаа эмэгтэй болж хүйсээ солиулсан хүн. Аль хэдийнээ үнийн тухай онол, бусад сэдвээр хийсэн бүтээлээрээ (Доналд МакКлоский гэж) олонд танигдсан ч гэсэн гол хувь нэмрээ Британийн эдийн засгийн түүхийн судалгаагаараа хожим оруулжээ. Тэрбээр сүүлийн хоёр зуун жилийн туршид гарсан эдийн засгийн асар их өсөлтийг хөрөнгө эсвэл институтээр зөвхөн зогсохгүй бас либерал үзэл санаа, ялангуяа "хөрөнгөтний үнэт зүйлс" түгэн тархсанаар тайлбарлах боломжтой гэж дүгнэсэн.

МакКлоский эдийн засгийн сүүлийн үеийн өсөлтийн цар хүрээний хэмжээсийг гаргасан. 1800-аад онд дундаж хүн өдөрт хэдхэн доллартай тэнцэх орлого олж байжээ. Өнөөдөр дундаж орлого хэдэн арав дахин их байна. Дэлхийн хүн ам 1800-аад оноос хойш долоо дахин өссөнийг бодолцвол энэ бол эд баялаг асар ихээр өссөн гэсэн үг юм. Бас хүмүүс зүгээр л материаллаг зүйлээр баяжсангүй: эд баялаг, хүний наслалт, бичиг үсэгт тайлагдсан явдал нэмэгдэхийн хэрээр оюун санаа болон соёл мөн баяжсан.

Хөдөө аж ахуй мандсан цагаас хойш гарсан хөгжил цэцэглэлтийн асар том, гэхдээ хамаагүй том хэмжээнд гарсан үсрэлт болох энэхүү Аугаа Баяжилт 1860 оны орчмоос эхэлсэн. Үүнийг арвандөрөвдүгээр зууны Хар Үхэлээс хойших Британийн эдийн засгийн тогтвортой тогтуун өсөлтөөр ч тэр, мөн бүр арваннаймдугаар зууны сүүлээр эхэлсэн Аж Үйлдвэрийн Хувьсгалаар ч тэр, бас Британийн институтууд болон хууль ёс хөгжсөн явдлаар ч бүрэн тайлбарлах аргагүй байдаг. Зөвхөн үзэл санаа л юмсыг ийм ихээр, ийм хурдан

өөрчилж чадна гэж тэрбээр ятган хэлдэг. Энэхүү Аугаа Баяжилт жирийн хүмүүст түүхэнд анх удаа эрх чөлөө, нэр төртэй байх, хөгжил цэцэглэлтийг биеэрээ эдлэх боломж олгосон "хөрөнгөтний либерализм" түгэн тархах явдлаас ургаж гарчээ. Зуу зуун жилийн туршид арилжаа худалдааг булхай оролцсон дор муу зүйл гэж боддог байв: гэвч Жон Локк болон Адам Смит зэрэг зохиогчид эрх чөлөө, арилжаа наймаа, эд баялаг болон хөрөнгө хураах зэрэг сайн үйлийг хамгаалцгаасан бөгөөд энэ бүгд жирийн иргэдийг нэр төртэй, өөрийгөө-хүндэлдэг болгосон. Гэнэт л чөлөөт хүмүүсийн бүтээлч суут ухааныг хорьж саатуулах юмгүй болов.

АРАВДУГААР БҮЛЭГ: Шүүмжлэгчид ба Шүүмжлэлүүд

Егөөтэй нь Америкийн кино бүтээгч Майкл Мүүр (1954 онд төрсөн), Солонгосын эдийн засагч Ха-Жүүн Чанг (1962 он), Канадын идэвхитэн Наоми Клайн (1970 онд төрсөн), Франц зохиолч Тома Пикетти (1971 онд төрсөн) зэрэг хүмүүс капитализмын шүүмжлэлээрээ өөрсдөө эд баялагтай болцгоосон. Үзэл санаа нь эрэлттэй байвал капитализм — шүүмжлэлийг голдуу л нам дардаг бусад тогтолцоог — бодвол бүр өөрсдийнхөө шүүмжлэгчдээ ч шагнаж урамшуулдаг гэж санагддаг.

Үүнтэй адилаар капитализм тэднийг дутуу үнэлж байна, мөн илүү шударга нийгэмд тэд илүү өндөр байр суурьтай, эрх дархтай байна гэж боддог эрдэмтэд, багш, зохиолч, жүжигчид бий. Гэвч тэд капитализм биш харин бусад хүмүүс ажлыг нь үнэлдэг гэдгийг мартдаг. Хэн тэдэнд бусад хүмүүс тэдний талаар өгсөн үнэлгээг хүндлэх хэрэггүй гэж хэлсэн юм бол?

Үүсгүүр нь юу ч байсан дэмжигчид нь анхаарал хандуулах ёстой, капитализмын тухай бодитой олон шүүмжлэл бий. Үүнд: ёс суртахууны тухай шүүмжлэл, капиталист эдийн засгийн бүтцийн тухай санаа зовоосон асуудал, корпорацын хүч чадлын тухай шүүмжлэл, геополитикийн санаа зовоосон асуудал багтана.

Ёс суртахууны шүүмжлэл

Тэгш байдлыг хөгжил цэцэглэлттэй харьцуулбал. Капиталист нийгэмд тэгш байдал онцгой сайн байдаг ч гэсэн хүмүүс бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээг мөнгөөр солилцохын хэрээр тэнд санхүүгийнх нь хөрөнгийн активд (хэдийгээр тэдний худалдаж

авсан таашаалаар тэнцвэрждэг ч гэсэн) гарцаагүй өөрчлөлт гарна. Санхүүгийн тэгш байдлыг хадгалж үлдэх цор ганц арга зам бол байнга дахин-хуваарилалт хийх явдал байх болно.

Тэдгээрт татварын өмнөх, мөн халамж авахын өмнөх орлогод анхаарал хандуулдаг учраас санхүүгийн тэгш байдлын талаархи статистик мэдээллийн олон нь төөрөгдөлд оруулдаг. Татвар болон халамжийг тооцож үзэхэд тэгш байдал дэлхий даяар бодит байдал дээр маш адилхан байдаг. Түүнээс харахад хүн амын хамгийн бага орлоготой 10 хувь дундаж орлогын 40 орчим хувийг авч байна. Тоон мэдээлэл мөн нас болон шилжих хөдөлгөөний нөлөөг халхалдаг: залуус хүмүүний капитал, биет хөрөнгөө бүтээх хэрэгтэй байгаа учраас эд хөрөнгө багатай байх хандлагатай; харин бага ур чадвартай цагаачид болон бусад нь бага цалинтай ажил хийдэг боловч тэд үүнийгээ илүү сайн ажилд орох шат гэж үздэг. Иймэрхүү дэвшил аливаа тогтолцоонд жам ёсны зүйл байдаг.

Зарим шүүмжлэгчид бүрэн тэгш байдалд хүрэх боломжгүй гэдгийг хараад эд баялаг зүгээр л бүтээмж муутай хүнд шуудхан очдог байх ёсгүй, мөн хүн бүр бараг л тэнцүү нөхцөлөөс эхэлдэг байх ёстой гэж өв залгамжлалын маш өндөр татварыг өмгөөлж хамгаалдаг. Гэвч үүнийг эсэргүүцэх ёс суртахууны болон олон бусад шалтгаан бий. Жишээлбэл, хүмүүн бодгаль хүүхдүүдээ эд баялаг өгөх гэсэн хүчтэй хүсэл зоригтой байдаг учраас энэ татвар хүмүүний энэ мөн чанартай зөрчилддөг; зарим хүн бусдаасаа урт насалдаг бөгөөд хүүхдүүдээ амьд байхдаа эд хөрөнгөө шилжүүлж чаддаг; хүмүүс үхсэнийх нь дараа хөрөнгийг нь татварлана гэдгийг мэддэг бол энэ мөнгөө үрэх болно. Ингэснээр хөрөнгө оруулалт буурч, ирээдүйн хөгжил цэцэглэлт саардаг; гэр бүлээрээ-өмчилдөг пүүс алга болно. Ямар ч тохиолдолд өв залгамжилж авсан хөрөнгө бидний харсанчлан нэг газартаа тогтвортой байдаг зүйл биш.

Зарчмын хувьд бараг хүн бүр л тэдэнтэй ижил тэнцүү харьцах, боломж бололцооны тэгш байдлыг дэмждэг ч гэлээ тэд өөрийнхөө хөгжил цэцэглэлтээ илүү их тэгш байдлын төлөө золиослох дургүй байдаг нь гайхалтай. Мөнгөөр аз жаргал худалдаж авч чадахгүй гэж хэлдэг ч бүх нотолгоо ингэдэг гэдгийг харуулдаг. Бидний анхаарал

хандуулах хэрэгтэй асуудал бол орлогын тэгш байдал биш харин хангалттай орлоготой байх явдал юм: хүмүүс нэр төртэй амьдрахад орлого нь хангалттай байна уу?

Капитализм ба шунал. Капитализм шуналд суурилдаг гэсэн шүүмжлэл шунал болон өөрийн-тусыг бодох хоёрыг хольж хутгаснаас гарсан: хэрэв бараа нийлүүлэгч жинхэнээсээ шуналтай бол хэрэглэгчид нь түүнийг орхин одно. Яагаад "шуналтай" гэж буруутгахдаа зөвхөн бизнес рүү дайрдаг юм бол оо? Бизнесүүд ашгийн төлөө шунаж байж болно гэвч хэрэглэгчид нь үүнтэй адилаар хэмнэх гэж шунаж байдаг, харин ажилчид нь илүү их цалин авах гэж шунадаг. Гэлээ гээд бид "шуналтай" хэрэглэгчид, ажилчдыг шүүмжилж буйг ховор сонсдог шүү дээ.

Гэхдээ заримдаа онцгой тохиолдол гардаг: жишээлбэл, шүүмжлэгчид капитализм хүн бүрийн шуналыг тэтгэж, олон нийтийн амин чухал үйлчилгээнд хэрэгтэй татварыг эсэргүүцдэг гэж хэлдэг. Гэвч татварт эргэлзэх нь муу үйл биш: (эрүүлмэндийн үйлчилгээ болон боловсрол зэрэг) олон нийтийн ихэнхи үйлчилгээг зах зээлд хувь хүмүүс нийлүүлэх эсвэл (соёлын болон халамжийн хөтөлбөр зэрэг) иргэний нийгмээр дамжуулж дэмжих боломжтой. Хэдий татвар шаардлагатай байж болох ч энэ нь хэрэгцээтэй муу үйл. Эцэст нь татварыг хүчээр хүмүүсээс авдаг; үүнийг зарим татвар төлөгчид ихээр эсэргүүцдэг (шорон, цэрэг арми эсвэл үр хөндөлт мэт) зүйлд зарцуулна; татвар үр өгөөж багатай, сонголт хийхээс муу үйлчилгээ үзүүлдэг төрийн үйлчилгээ үзүүлэх монополийг тэтгэдэг; энэ нь хүмүүс өөртөө татаас болон ашиг хүртэх гэж өрсөцгөөхийн хэрээр лобби хийх явдал болон кронизмыг өдөөдөг; татвар муу нөлөөтэй сэдэл төрүүлдэг – жишээлбэл, орлогын татвар ажил хийх явдлыг бага урамшуулдаг бол харин өв залгамжлалын татвар хадгалж хураах, хөрөнгө оруулах явдлыг мохоодог.

Материализм ба хэрэглээг шүтэх үзэл (consumerism). Ёс суртахууны талаархи өөр нэг шүүмжлэл бол капитализм нь материализм болон "хэтэрсэн" хэрэглээг тэтгэдэг гэх санаа юм.

Энэ гаргалгаа нотолгоо хачирхалтай угшилтай. Капитализмын талаархи эхэн үеийн шүүмжлэлд түүнийг ажилладаггүй зүйл, харин

зохистой төлөвлөлт л амьжиргааны төвшнийг хурдан нэмэгдүүлдэг гэж хэлдэг байсан: гэвч хэрэг явдал үүнийг нь буруу болохыг батлав. Тиймээс бүр саяхнаас энэ шүүмжлэл капитализм хэтэрхий сайн ажиллаж, нийгмийн чухал зорилгоос холдуулан хүмүүст хэрэгцээгээ "хэтрүүлж" хангах, хэрэггүй зүйлс хэрэглэх боломж олгож байна гэсэн утгатай болсон. Гэвч юуг "хэтэрсэн" гэж үзэх нь бодол санааны хэрэг юм – олон нийтийн бодлогын хувьд ялангуяа иймэрхүү хэрэглээг хүч хэрэглэн дарах тухай хэн нэгэн бодож байвал энэ нь ядмаг үндэслэл болно.

Энэхүү гаргалгаа нотолгоонд өөр хоёр сул тал бий. Эхнийх нь хүмүүс бүр бид түүнийг нь өөрсдөө үнэлж үздэггүй байсан ч тэдний үнэлж үздэг зүйлээ үйлдвэрлэх, хэрэглэхээс нь сэргийлэх ёс суртахууны эрх дарх бидэнд байхгүй – мөн хэдий бид эдгээр үйлийг сайн үйл гэж үздэг байсан ч өөрсдийнхөө үнэт зүйлийн дагуу тэднийг үйл хийлгэх гэж албадах ёс суртахууны эрх бидэнд байхгүй. Ингэх нь тэдний сонгох эрх, өөрийгөө-мэдэх (self-determination) эрхийг зөрчинө.

Хоёрт нь бид капитализмыг хүлээн авч өөриймшүүлдэг гол шалтгаан бол энэ нь эдийн засгийн бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэхдээ гаргуун сайн байдаг явдал юм. Бид үүнийг тэгш байдал эсвэл эв нэгдэл зэрэг *нийгмийн үр дагавар* бий болгох гэж хүлээн авч өөриймшүүлдэггүй. Капитализм ийм ажилд тохирохгүй багаж хэрэгсэл бөгөөд бид түүнийг ингэж чаддаггүй гэж буруутгах боломжгүй. Капитализм бол үнэндээ эв найр, бүх нийтээрээ хөгжиж дэвжих зэрэг нийгмийн зарим нэг аз жаргалтай үр дагавар үүсгэдэг – гэвч эдгээр нь зөвхөн түүний дайвар шагнал юм.

Зардал танах ба чанар. Олон шүүмжлэгч өрсөлдөөн үйлдвэрлэгчдийг хэрэглэгчдэд хямд боловч чанар муу бараа бүтээгдэхүүн очихоор зардлаа хамгийн бага болтол багасгахад хүчилж албадаг гэж боддог. Тэд юмсыг мөнх байхаар чанартай хийдэггүй гэж гомдоллодог – энэ бол ухаалаг бус, худал хэмнэлт юм.

Үнэндээ үйлдвэрлэгчид ирдэг өрсөлдөөний дарамт шахалт тэд хэн ч байсан гэсэн хэрэглэгчдийнхээ эрэлтийг ханга гэсэн тулгалт

байдаг. Зарим тохиолдолд хүмүүс чанар, нөгөө нэгд нь хямд үнэ нэхэх боломжтой. Жишээлбэл, хэв загварынх нь хандлага хурдан өөрчлөгдвөл удалгүй хэв маяг нь өөрчлөгдөх үнэтэй хувцас хийх нь утгагүй зүйл. Үүнтэй адилаар хувийн хэрэглээний электрон хэрэгсэл шинэ технологи гарч ирэхэд удалгүй хуучрах боломжтой. Нөгөө талаас хэв загвар эсвэл технологийн өөрчлөлт тийм ч их чухал биш байдаг удаан эдэлгээтэй (зүлэг тайрагч эсвэл том төгөлдөр хуур зэрэг) бараа бүтээгдэхүүний хувьд хэрэглэгчид хямдхан нэгнээс нь илүүтэй илүү сайн чанартай бүтээснийг илүүд үзэж болно.

Энэ бүх тохиолдолд эд бүгд хэрэглэгчээс хамаарч байна: настай, баян хүмүүс илүү сайн чанартайг илүүд үзэх бол харин залуу, мөнгө хөрөнгө багатай хүмүүс чанар муутай боловч мөнгөндөө таарсан зүйл худалдан авахыг чухалчилдаг байж болох юм. Хэн тэднийг ийм сонголт бүү хий гэж хэлж чадах вэ?

Хүмүүс сонголт муу хийдэг. Зарим шүүмжлэгчид олон хүн өөрсдөө ойлгодоггүй хадгаламж хийх төлөвлөгөө гаргах эсвэл хэрэгцээнд нь нийцдэггүй бараа бүтээгдэхүүн авах зэргээр сонголтоо муу хийдэг гэж эсэргүүцдэг. Тэд шинэ бүтээгдэхүүн, ялангуяа санхүүгийн бүтээгдэхүүнийг нарийн чанд ёс журмаар зохицуулах эсвэл бүр бүрэн үр нөлөө нь ил болох хүртэл хааж хориглох хэрэгтэй батлан өгүүлдэг.

Тэдгээрийг худалдаж авахдаа алдаа гаргаж магадгүй гэсэн үндэслэлээр шинэ бүтээгдэхүүн зарж борлуулахыг хориглоно гэдэг нь шинэ санаа шинэчлэл, хөгжил дэвшлийг устгах дардан зам юм. Энэхүү хөгжил дэвшлээс ашиг тус хүртэх ирээдүйн үеийнхэн бас хохирно. Нарийн нийлмэл хадгаламжийн бүтээгдэхүүнд худалдан авалтаа буцаах хугацаа (cooling-off period) гэх мэт зарим нэг энгийн, бүх хүнд хэрэглэдэг хамгаалалт тавихыг дэмжих үндэслэл байж болно. Иймэрхүү дүрэм журмын зохицуулалт гэвч утгагүй зүйл. Хэн ч байгууллагын лицензийг нь шалгадаггүй: тэд найзууд, хөршүүдээсээ аль байгууллагыг санал болгох вэ гэж асууцгаадаг.

Бидний хэн ч (бүр дүрэм журам тогтоогч ч гэсэн) бүх зүйлийг ухаж ойлгож чадахгүй тул бид тэр бараа бүтээгдэхүүний талаар бидэнд байгаа хамгийн сайн мэдээлэлдээ үндэслэж бараа

бүтээгдэхүүн худалдан авдаг. Ихэнхи хүмүүс үүнд үндэслэн өөрийнхөө сонголтоо хийх бүрэн чадвартай. Тэд мөн зарим нэг хол буй албан тушаалтнаас илүү өөрийнхөө хэрэгцээг хамаагүй сайн мэддэг: дүрэм журмаар зохицуулагч хүн хувь хүмүүст худалдан авч буй зүйлийг нь худалдан авахад яг юу сэдэл өгч буйг мэдэж чадахгүй – тиймээс тэр зохицуулагчид тэр хүмүүсийг зогсоох ёстой ямар эрх эсвэл үндэслэл байна вэ? Хэрэв бид хүмүүс алдаа гарвал тэднийг батлан даадаг бол бид энэ нь зүгээр л тэднийг хайхрамжгүй үрэлгэн байдалд л сургаж байна гэсэн үг; хэрэв бид тэдэнд сонголт хийх эрхийг нь эдлүүлэхээс татгалзвал бид тэднийг өчүүхэн дорд амьтан болгоно. Өөрийнхөө сонголтын үр дагаврыг хүртдэг байх нь илүү үр дүнтэй, илүү ёс суртахуунтай зүйл.

Капитализмын бүтцийн тухай шүүмжлэл

Үйлдвэрлэлийн анархи байдал. Олон шүүмжлэгч капиталист үйлдвэрлэлийг үр ашиггүй, рационал бус, анархи шинжтэй гэж ойлгодог. Жишээлбэл, өөр өөр пүүс ижилхэн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг, түүнийгээ зарах гэж зар сурталчилгаандаа мөнгө дэмий үрдэг гэнэ: ганц, том хэмжээтэй үйлдвэрлэгч илүү үр өгөөжтэй бөгөөд зар сурталчилгаа хэрэггүй зүйл гэдэг. Мөн ашиглах нөөцийг капиталист үйлдвэрлэлийн санамсаргүй мөн чанарт найдалгүйгээр хэрэв үйлдвэрлэлийг зөв төлөвлөсөн бол үйлдвэрлэлийг илүү рационал байдлаар бүтэцжүүлж, илүү бага хаягдалтайгаар хэрэглэх боломжтой гэнэ.

Гэвч иймэрхүү шүүмжлэлд өрсөлдөөн капитализмыг маш динамик тогтолцоо болгодгийг мартчихдаг. Пүүсүүд бүгдээрээ нэг ижил зүйл үйлдвэрлэдэггүй ч тэд хэрэглэгчдэдээ санал болгож буй бүтээгдэхүүнээ тэдгээрийг байнга сайжруулан, хэрэггүй зардлаа танах замаар илүү дур татам болгохыг оролддог. Туршлагаас харахад цор ганц үйлдвэрлэгч бүтээгдэхүүнээ сайжруулах, бас бүтээмжээ нэмэгдүүлэх санаачилга багатай байдаг.

Үнэн хэрэгтээ капитализмд хангалттай их төлөвлөлт бий: хувь хүмүүс болон пүүсүүд бүх цаг үед байнга л төлөвлөж байдаг.

Тэдгээр төлөвлөгөө юу худалдаж авах эсвэл авахгүй талаар гаргасан хэрэглэгчдийн өдөр тутам гаргаж буй шийдвэрээс ирж буй шуурхай эргэх холбоо дамжуулдаг саналыг хүлээн авдаг бөгөөд үйлдвэрлэгчид төлөвлөгөөгөө түүнд тааруулан хурдан тохируулдаг. Хэрэв тэд алдаа гаргавал тэр үйлдвэрлэгчид л үүнээс болж хохирно. Гэвч үндэстний нийт үйлдвэрлэлийг төлөвлөвөл юмс үүнээс тэс ондоо байдаг. Иймэрхүү асар том төлөвлөгөө удаан хэрэгждэг, түүнийг өөрчлөхөд хэцүү; хэрэглэгчдэд сонголт бага учир тэднээс ирэх санал бага байдаг; тиймээс ийм бүдүүвч төлөвлөгөөнд динамизм, хөгжил дэвшил бага байна. Хэрэв төлөвлөгөө нь алдаатай бол нийт үндэстнээрээ зовдог.

Бүтээмжгүй дамын наймаа. Олон шүүмжлэгч капитализмд байдаг санхүүгийн аз сорьсон наймааг эсэргүүцдэг: хувьцаа эсвэл валютын ханш, фючерс буюу ирээдүйн зах зээлийн ханш, өөр бусад бүх зүйлд бооцоо тавих үүнд хамаарна. Тэдний хэлэхээр энэ нь юу ч бүтээдэггүй харин асар их цаг хугацаа, эрч хүч, мөнгө үрдэг ажээ.

Үнэндээ аз сорьсон наймаа бол амьд эдийн засаг, хөрөнгийн зах зээлийн шинж тэмдэг бөгөөд дамын наймаачид (speculators) үнэ цэнэтэй ямар нэг зүйл бүтээж байдаг. Нэгэнт үйлдвэрлэл төрөлжсөн байдаг тул дамын наймаачид буюу азаа соригчид өрсөлдөгчидтэйгөө дүйцэхийн тулд зөвхөн хэдхэн пүүс эсвэл нэг салбараар л дагнасан их мэдлэгтэй байх ёстой болдог. Тэдний хаана хөрөнгө оруулах эсвэл оруулахаа болих тухай мэдээлэлд-тулгуурласан шийдвэр тиймээс тэр пүүс эсвэл салбарын эрүүл байдал болон ирээдүйн төлөвийн талаархи үнэ цэнэтэй илтгэгч байдаг бөгөөд бусад хүмүүст өөрсдийнхөө мөнгийг хаана оруулах талаар илүү үндэслэлтэй шийдвэр гаргахад тусалдаг. Хөрөнгө оруулах явдлын эрсдэлийг багасгаснаар энэ нь илүү их хөрөнгө оруулах, хөрөнгө бүтээх, үүнээс улбаалаад бүтээмжтэй үр ашгийг тэтгэдэг – энэ нь ашиглах нөөцийг хамгийн бүтээмжтэй хэрэглээ рүү хурдан залж чиглүүлнэ.

Ардчилсан бус үйлдвэрлэл. Өөр нэг шүүмжлэл байдаг нь капитализмд үйлдвэрлэлийг өмчлөгчдөд нь ашиг хүртэхээр зохион байгуулсан байдаг, үнэндээ үйлдвэрлэлийг олон нийт болон бусад

оролцогчдод ашиг тустай байхаар зохион байгуулах ёстой гэх санаа юм. Тиймээс үйлдвэрлэлийг ардчилсан хяналтад авах хэрэгтэй – ингэснээр үйлдвэрлэлийг өмчлөгчдийнх нь богино хугацааны ашиг сонирхлоор биш харин үндэстний урт хугацааны ашиг сонирхлоор удирдан явуулах боломжтой гэнэ.

Харамсалтай нь "ардчилсан хяналт" гэдэг нь улстөрийн хяналт гэсэн үг – энэ хяналтыг улстөрийн бүх асуудал, үүн дотроо даралт шахалт үзүүлдэг бүлгүүдийн хүч чадал болон сонгогчид, улстөрчид, албан тушаалтнуудын өөрийн-тусыг бодох явдал дагалдах болно. Улстөрийн үйл явцаар оролцогч талуудын ашиг тусын төлөө хянадаг эдийн засаг гэдэг нь түүний одоогийн оролцогч талуудын ашиг тусын төлөө л ажиллуулна гэсэн үг юм – одоогийн оролцогчид бол хөгжил дэвшлээр амьдралыг нь бусниулаасай гэж боддоггүй харин өнөөгийн хэвшсэн арга ажиллагааг сахин хамгаалах гэж тэмүүлдэг хүмүүс. Дараагийн сонгуулиа л боддог улстөрчдөөс өөр хэн хамгийн богино хугацааны бодолтой байх вэ? Үүний эсрэгээр өмчлөгч хэрэв тэд бизнесийнхээ урт хугацааны хүч чадлаа тэтгэж – өөрөөр хэлбэл хөрөнгө татаж, үнэ цэнийг нь өсгөж чадвал л ашиг тус хүртдэг.

Корпорацийн хүч чадал

Том корпорациуд. Капитализмын тухай олон шүүмжлэл том корпорацийн хүч чадалд төвлөрдөг. Том корпорацийг улстөрчид, олон нийтийн бодол санаа, хэрэглэгчдийнхээ сонголтыг өөрчилж удирдах, төрөөс татварын хөнгөлөлт авч, монополь байдал үүсгэх чадалтай гэж хардаг.

Гэвч монополь компани болон том корпорац заавал капитализмын зайлшгүй хэсэг биш юм. Капиталист өрсөлдөөнд компанийн хувьд том хэвээр үлдэх цор ганц арга зам бол олон нийтэд үйлчилсээр байх явдал байдаг. Бүр хамгийн том компанийг ч гэсэн өөр нэг том компани эсвэл жижиг компаниуд бизнесийнх нь өөр өөр хэсгийг булаан авах зэргээр сорилтод оруулах боломжтой. Том компаниуд монополь байдал үүсгэж чадах цор ганц арга зам бол татвар эсвэл төрөөс хүртэж буй дүрэм журмын зохицуулалтын

ач тусаар өрсөлдөөнд саад болох явдал юм. Энэ бол капитализм биш харин кронизм (танил талын сүлжээ буюу амин найзуудын бизнес).

Монополь байдал болон кронизмд төр л зөвхөн буруутай. Төр татварлах, хууль, дүрэм журам гаргах эрх мэдэлтэй; төр бүр чамайг шоронд хийж эсвэл дайнд явуулж ч чадна. Бизнесийнхэн тэгж чадахгүй. Гэвч хүмүүс том компаниудын хүч чадлын талаар гомдоллодог ч төрд л жинхэнэ эрх мэдэл эсвэл хүч чадал бий. Бидэнд том, байр сууриа олчихсон үйлдвэрлэгчдийн ашиг сонирхолд үйлчилдэггүй, харин өрсөлдөөнийг дэмждэг улстөрч хэрэгтэй.

Удирдлагын багийг өмчлөлтэй харьцуулбал. Зарим шүүмжлэгчид олон нийтийн том корпорацуудын удирдлагын баг өмчлөгчдөөсөө салчихсан учраас үр ашиггүй ажилладаг гэж батлан өгүүлдэг. Менежерүүд ямар нэг хязгаар, захиргаагүй, хүчирхэг, хэт өндөр цалинтай болчихдог гэнэ.

Гэвч өмчийн эзэд болон менежментийг хувааж зааглах явдал бол хөдөлмөрийн хуваарийн зүгээр л өөр нэг хэлбэр юм. Мэдээж компанийн өмчлөгчид (ө.х. хувьцаа эзэмшигчид) менежерүүдээ хянах эрх мэдэлтэй байх ёстой; гэвч олон оронд компанийн тухай муу хуулиар гажуудуулсан байдаг – хуулиар ингэж муу зохицуулдаг явдал бол капитализмын жигд тогтуун ажиллагааг улстөрийн явц саатуулдаг тухай өөр нэг жишээ юм.

Мөн бизнес илүү том болох тусам илүү ур чадвартай менежер бизнесийг нь удирдахад хэрэгтэй болдог. Дэлхийн-хэмжээний олон-улсын корпорацыг удирдаж чадах маш цөөхөн хүн байдаг бөгөөд тэдэнд сайн цалин өгдөгт гайхах явдалгүй. Гэвч заавал илүү өндөр өгөөд байдаггүй: сайн гүйцэтгэх захирал компанийг орхихоор шийдэхэд компанийн үнэ цэнэ огцом буурдаг. Менежер тэр цалинд тохирч буй эсэхийг улстөрийн өөр сэдэлтэй улстөрч биш харин өмчлөгч шийддэг байх ёстой.

Даян дэлхийн харилцан хамаарал

Үндэстэн-дамнасан корпорациуд. Үндэстэн-дамнасан корпорациудаас илүү их шүүмжлэлд өртдөг аж ахуйн нэгж хэдхэн л байдаг байх. Шүүмжлэгчид ийм корпорацийг тусгай хамгаалалттай байдаг, татвараа багасгахын тулд улс орнуудын хооронд зардлаа шилжүүлдэг, хамгийн их бохирдуулдаг үйл явцаа ядуу улсууд руу шилжүүлдэг гэж буруутгадаг. Тэд дэлхийн зах зээлийг том хөрөнгөтэй, үндэстэн-дамнасан корпорациуд сууриар нь ганхуулдаг, мөн бараг улс оронтой дүйцэхүйц зарим нэг нь зах зээлийн тоглогч гэхээсээ илүүтэй эзэнт гүрний шинжтэй үйл хийдэг батлан өгүүлцгээнэ.

Гэвч тэр засаг болон кронизм л компаниудад ийм том хэмжээтэй болж өсөх боломж олгодог. Зарим нь өсөлт-хурдасгадаг бизнес болон хөрөнгө өөртөө татахыг хүсдэг учраас л улс орнууд татварын өөр өөр горимтой байдаг. Үндэстэн-дамнасан корпорациуд үнэндээ ядуу улсуудад асар их хөрөнгө оруулж, тэдгээр улсын аж үйлдвэрийг илүү бүтээмжтэй болгон, ажлын байрны бололцоог нээж, цалинг нь өсгөдөг. Баян улсуудын хүмүүс ажиллахаар сонгож авдаг ажлыг бодвол зарим ажил нь хүнд хүчир, зарим үйл явц нь бохир заваан байж болно; гэвч үүнээс өөрөөр байх гэвэл эдгээр улсын хөгжил удааширна, илүү цэвэр, илүү хялбар үйлдвэрлэлтэй болж чадна гэсэн найдвар нь биелэх явдал хойшилно, тэр хүмүүс ядуу хэвээр удаан хугацаанд амьдарна.

Империализмийн хувьд бол үндэстэн-дамнасан корпораци болон дэлхий-дэхний зах зээл дэлхийн эв найрыг жинхэнээсээ тэтгэдэг. Хөгжиж буй эдийн засагт оруулсан хөрөнгө оруулалт тэрбум тэрбум хүнийг ядуурлаас гаргаж, хөгжиж цэцэглэж буй дундаж анги бий болгосон; эд бол эв найртай нөхцөлд л байх боломжтой эв найр болон арилжааг сахин хамгаалах гэж жинхэнээсээ тэмүүлдэг хүмүүс юм.

МакДоналджих явдал. Гэлээ гээд зарим шүүмжлэгчид баян улсуудын хөрөнгө оруулалтыг соёлын империализм мөн дагаж ирдэг, Өрнөдийн брэндүүд, амьдралын хэвмаяг, дадал хэвшил орон

нутгийнхны ийм зүйлсийг шахан зайлуулдаг гэж батлан өгүүлдэг.

Гэвч үнэн бол даяарчлал асар олон янзын бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээг жинхэнээсээ түгээн тархаадаг. Одоо Дорнод Европ болон Зүүн Өмнөд Азийн ихэнхи хэсэг Өрнөдийн улсуудад хаалттай байхаа больж, хоёр тал хоёулаа хэзээ хэзээнээс илүү олон бүтээгдэхүүн таашаан эдлэх боломжтой болжээ. Арилжаа худалдаа бий болгосон эд баялаг хөгжиж буй улсуудаас илүү баян улсууд руу оюутан эсвэл жуулчид байдлаар очих боломж олгодог бөгөөд тэд ч өөрийн үнэт зүйлс, соёлоо тээж очдог. Үр дүнд нь соёлын империализм биш харин олон янз байдал, сонголт бий болно.

Ажлын байр хамгаалах. Хөгжиж буй эдийн засагт "нялх" аж үйлдвэрүүдээ өсгөж томуулах, эдийн засгийн хувьд хүчтэй болгохын тулд тусгай хамгаалалт шаардлагатай гэж голдуу ярьцгаадаг. Энэ нь илүү баян улсууд тэр улсуудыг ганхуулж хүчгүйдүүлэхээс сэргийлж хяналт, импортын тариф тавьж, экспортын татаас өгнө гэсэн үг юм.

Гэвч үнэндээ ядуу улсуудад байдаг хамгийн том зовлон бол хөрөнгө дутуу байх явдал; гадаадын хөрөнгө оруулалтад нээлттэй болох явдал бол түүнийг олж авах хамгийн дардан зам юм. Шинэ хөрөнгө тэр улсуудыг илүү бүтээмжтэй болгоно – бүтээмжтэй болсноор дэлхийн хаана ч өрсөлдөх боломжтой бараа бүтээгдэхүүн болон үйлчилгээ бүтээх чадвартай болох, мөн өөрсдийнхөө амбицдаа хүрэхээр тэмүүлэх боломж нутгийн иргэдэд ирдэг.

Протекционизм бол төр ивээж буй аж үйлдвэрүүдээ татаас өгөх гэж татвар төлөгчдөө албадаж хүчилдэг эсвэл импортлогчдынхоо эсрэг импортын тариф, квот тавьж чаддаг, зөвхөн чөлөөт-бус улсуудад орших боломжтой зүйл. Гэвч зах зээл одоо дэлхий-дэхний зүйл болсон: түүний нэг хэсэг байхаас улс орнууд ашиг тус хүртдэг – харин протекционист хананы цаана ч хөгжихгүй үлдэх ч боломжгүй эсвэл бүр тэр хэвээрээ үлдэж чадахгүй.

Крони бизнесээс татгалзах

Капитализмыг шүүмжилдэг хэд хэдэн шүүмжлэгч чөлөөт зах зээл гээч зүйл байдаггүй гэж батлан өгүүлцгээдэг. Үргэлж л лобби,

хуйвалдаан байдаг тул капитализмыг хүлцэн тэвчиж болохоор ажиллуулахын тулд хүчтэй дүрэм журмын зохицуулалт, ёс журам хэрэгтэй гэнэ.

Гэвч капитализмын дэмжигчид мөн л хуйвалдаан болон кронизмыг эсэргүүцдэг бөгөөд эдгээрийг зөвхөн капитализмд байдаг зүйл биш гэж үздэг. Үнэндээ эдгээр зүйл социалист тогтолцоонд илүү тархсан байдаг. Шударга ёс, өмчлөх болон өмчөө чөлөөтэй арилжаалах эрх зэрэг зах зээл ажиллах боломж олгодог ёс журам шүүмжлэгчдийн санал болгож буй илүү нарийвчилсан дүрэм журмын зохицуулалтаас хамаагүй энгийн, илүү ерөнхий байна.

Үүнээс илүүтэй төр засаг эдийн засгийг удирдан явуулахад биш харин хувь хүмүүсийн эрх болон эрх чөлөөг хамгаалах гэсэн чухал үүрэгтээ анхаарлаа төвлөрүүлэх ёстой: энэ бол эдийн засаг болон төрийг хооронд нь салгаж зааглана гэсэн үг юм. Түүхийн гашуун сургамж туршлагаас харвал олон нийтийн албан тушаалтнууд жирийн иргэдээс илүү ухаантай, бас илүү ёс суртахуунтай байдаггүй. Үнэндээ төрийн эрх мэдэл ийм эрх мэдлийг ашиглах хамгийн муу хүмүүсийг өөртөө татаж, тэдэнд илүү аймшигтай алдаа хийх боломж олгодог.

АРВАННЭГДҮГЭЭР БҮЛЭГ: Капитализмын Ирээдүй

Капитализм олон төрлийн хүч тэнхээтэй бөгөөд энэ тогтолцоонд дэлхий даяар эв найр, хөгжил цэцэглэлт түгээн тархаах олон боломж бий. Гэвч түүнд бас сул талууд байдаг бөгөөд нарийн эмзэг механизмыг сулруулж, үр нөлөөг нь гажуудуулан, олон нийтийн дундахь дэмжлэгийг нь ганхуулж, түүнийг улам сулруулах аюул заналтай нүүр тулж байна.

Хүч тэнхээ

Хөгжил цэцэглэлт. Капитализмыг, бүр түүний өнөө цагийн маш их зохицуулалттай хэлбэрийг дэмждэг гол гаргалгаа нотолгоо бол энэ нь хөгжил цэцэглэлтийг дэмждэг, ялангуяа хамгийн ядуу хүмүүст ч хөгжил дэвшлийг хурдан хүргэдэг явдал юм. Дэлхийн зах зээлийн саяхны даяарчлал үгээгүй ядуурлаас тэрбум тэрбум хүн гаргасан – ингэхдээ тэдний орлого болон эд хөрөнгийг нь нэмэгдүүлж, илүү сайн эрүүлмэндийн үйлчилгээ авчран, хүүхдийн эндэгдлийг багасгаж, амьдралыг нь уртасган, (ялангуяа эмэгтэйчүүдийн дундахь) бичиг үсэг болон тоо бодлогод тайлагдсан байдал (literacy and numeracy)-ыг нэмэгдүүлж, мөн хүмүүний бусад олон тав тух өгсөн.

Үүн дээр нэмээд дэлхийн хөрөнгөд нээлттэй болсноор хөгжиж буй эдийн засгуудын бизнесүүд илүү бүтээмжтэй болов. Энэ байдал нутгийн хүмүүс илүү сайн, илүү хямд, илүү элбэг болсон нутгийнхаа бүтээгдэхүүнийг таашаан эдлэх боломж олгодог бөгөөд тэдний цалин улам их болоход хүргэнэ. Асар их бүтээлч байдал шинэ бизнесүүд амжилтад хүрэх явдлыг шинэ аж ахуйн нэгж эхлүүлэх

эрсдэлийг багасган, шинэ санаа шинэчлэлийг болон хөгжил дэвшлийг тэтгэж мөн нэмэгдүүлдэг.

Хүний ухааныг чөлөөлдөг. Үйлдвэрлэлийг илүү хялбар, илүү бүтээмжтэй болгон, мөн хүмүүн бодгалийг хүчир хөдөлмөрөөс ангижруулан чөлөөлж, бас өдөр тутам амьдрах гэж санаа зовоохоос хүмүүсийг авран хамгаалдаг эд баялаг бүтээн капитализм хүмүүст өөрсдийн үнэлж үздэг зүйлдээ ухаанаа зарах, мөн бусад асуудлаа шийдвэрлэхэд оюун санаагаа хэрэглэх эрх чөлөө өгдөг. Хэрхэн амьдрах тухайгаа эргэцүүлж бодох асар олон өөр өөр ухааныг чөлөөлөх нь мэдээжээр хөгжил дэвшлийг мөн тэтгэнэ. Өөр өөр хүмүүс бараа бүтээгдэхүүний зах зээл, мөн үзэл санааны зах зээл дээр ч турших боломжтой ондоо ондоо төлөвлөгөөгөө дэвшүүлж зүтгүүлдэг. Бид дараагаар нь үндэстний хэмжээний нэг ямар нэг төлөвлөгөөнд баригдсанаас ажиллаж буй зүйлдээ тулгуурлан хамаагүй хурдтай хөгжих, ажиллахгүй зүйлээ хаяж орхих боломжтой болно.

Хувь хүний олон утопи санаа. Капитализм бол олон-ургальч зүйл. Бреннэн хэлсэнчлэн капитализм нэг утопи санааг тэтгэдэггүй – харин энэ нь олон утопи санааг хөхиүлэн дэмждэг. Ондоо ондоо хүмүүс зүгээр л сонгож авсан өөр өөр амбицтай, мэргэжилтэй байх боломжтой. Тэд төр засаг тэдэнд хамтын төсөлд ажил үүргийг нь оноон өгөхийг хүлээн зүгээр суудаггүй. Тэд бусад хүмүүс ч өөрийнхийгөө бүтээхэд нь саад болохгүйгээр өөрийнхөө диваажинг бүтээж чадна. Тэд бүгдийн хийх ёстой зүйл бол бусадтайгаа найртай сайн харилцах – тэд Маркс хөрөнгөтөн анги хийдэг гэж хэлж байсанчлан бусдыгаа дарж дарангуйлах ёсгүй. Капитализм олон өөр цэцэгт дэлгэрэх боломж өгдөг.

Хүмүүний мөн чанар. Капитализм бас хүмүүний мөн чанарт тулгуурладаг. Хүмүүс өөрийнхөө өмчтэй гүн холбоотой байдаг: тэдний мэргэжил тэдэнд чухал, мөн материаллаг үнэ цэнээс илүү утга учиртай. Өгсөн амлалтаа хүндэлдэг хүмүүсийг хүндлэх бат итгэлтэй байдагчлан шударга ёсны тухай бидний үзэл санаа мөн гүн гүнзгий байдаг. Хүмүүс бусадтайгаа эв найртай амьдрангаа мөн сонгож авснаараа чөлөөтэй амьдрах, үйл хийхийг хүсдэг. Тэд

өөрсдийнхөө болон гэр бүлийнхээ нөхцөлийг илүү сайн болгох гэж чармайдаг. Эдгээр зүйл бол үнэндээ капитализмын үндэс суурь юм. Тиймээс хамгийн өршөөлгүй хамтач улс орнуудад ч хүмүүс өөрийн гэсэн өмчтэй болох, түүнийгээ хамгаалахыг оролддог, мөн боломж бололцоо гарах бүрд зах зээл бий болдогт гайхах арга алга.

Сул талууд

Стэтизм ба кронизм. Өнөөдөр "капитализм" гэж нийтээрээ хэлдэг зүйлийг хамгаалах хэцүү. Дэлхийн ихэнхи хэсэгт "капитализм" гэж харуулж буй зүйл үнэндээ хувийн аж ахуйнуудаас өндөр татвар авдаг, тэдгээрийг дүрэм журмаар их зохицуулдаг, үндэстнийх нь орлогын хагас эсвэл түүнээс ихийг нь төр засаг зарцуулдаг, төрийн аж ахуйн нэгж нь чухал салбаруудад, үүн дотроо эрүүлмэндийн үйлчилгээ, боловсрол, нийтийн аж ахуй, төмөрзамын тээвэр, шуудангийн үйлчилгээний монополь байгууллага эсвэл бараг монополь байгууллага байдаг холимог эдийн засаг байдаг. Ийм эдийн засаг бол том бизнесүүд эдийн засгийн хүч чадлаа улстөрчдөөс түсламж аван, оронд нь заримдаа санхүүгийн дэмжлэг өгч байж олж авдаг голдуу крони буюу амин найзуудын эдийн засаг юм.

Гэвч үүнтэй адилаар Зөвлөлт Орос, Маогийн Хятад, Хойд Солонгос эсвэл Кубад ноёлж байсан, байгаа "социализм"-ыг өмгөөлж хамгаалах хэцүү – учир нь тэнд хариуцлага хүлээлгэх, ардчилал байхгүй байсан бөгөөд дарангуйлал, намын элитүүдийн тансаглал, зуун сая хүний амь авсан цэвэрлэгээ нэртэй хядлага, өлсгөлөн болж байсан.

Кронизм нь капитализмын салшгүй хэсэг байдаггүй харин социализмын салшгүй хэсэг байдгаараа энэ хоёр тогтолцоо ялгаатай. Учир нь капитализм хувь хүний эрх чөлөө, сайн дурын солилцооны зарчимд үндэслэдэг. Үүнээс ялгаатай нь социализмд эдийн засгийн бүх үйл ажиллагааг чиглүүлэх улстөрийн эрх мэдэл шаардлагатай байдаг. Капитализмд хүмүүс хоорондоо санал нийлэх албагүй: тэд бусад нь сонголттой нь санал нийлэхгүй байсан ч өөрсдийнхөө бизнесээ эрхлэх, илүүд үзсэн бараа бүтээгдэхүүнээ хэрэглэх

боломжтой. Социализм гэвч хүмүүс санал нэгдэх ёстой хамтын зорилго, түүнд хүрэх хамтач арга хэрэгслийг илэрхийлдэг. Санал нийлэхгүй байгаа хүмүүсийг хамтралын аж ахуйд оролцуулахын заавал хүчлэх, албадах ёстой болдог.

Капитализм олон янз байдал болон сонголтод тулгуурладаг байхад харин социализм аялдан дагах явдал, эрх мэдэлд суурилна. Гэвч аялдан дагах явдал хөгжил дэвшлийн анд найз биш бол харин эрх мэдэл бүр хамгийн нийтийн-төлөө сэтгэлтэй хувь хүмүүсийг ч завхруулдаг – мөн энэ нь эрх мэдлийг хамгийн өршөөлгүй, харгис хэрцгий ашигладаг тэр хүмүүсийг өөртөө татдаг. Нээлттэй өрсөлдөөнөөр зөвхөн хэрэглэгчдэд үйлчилж хөгжиж дэвждэг, харин төрийн крони буюу амин найзуудын дэмжлэг авдаггүй аж ахуйн нэгжүүд оршдог, тийм "цэвэр" капитализмын талаар бид төсөөлж чадна. Гэвч хүн бүр тэднийг албадаж хүчлэх төрийн эрх мэдлийн ямар нэг аппаратын оролцоогүйгээр аз жаргалтайгаар хамтралын аж ахуйд оролцож ажиллахыг зөвшөөрдөг "цэвэр" социализм бол яагаад ч төсөөлөх боломжгүй зүйл.

Бизнесийнхний хоёр нүүр. Гэвч улстөрчдөд амин найзуудын бизнесдээ тустай үйлчилгээ батлан олгох боломж өгдөг эрх мэдэл бизнес хийж буй хүмүүс яагаад капитализмын хамгийн сул хамгаалагчид эсвэл бүр хамгийн аюултай дайсан байдаг байдгийн тайлбар болдог. Бизнес эрхэлдэг корпорацууд өөрийн салбарт өрсөлдөөнийг барагтаа бол дэмждэггүй. Үнэндээ тэд өрсөлдөөнийг хязгаарлах дүрэм журмын зохицуулалт шаарддаг, ингэхдээ голдуу өөрсдийгөө олон нийтийг аюултай "зуйгуул" операторуудаас хамгаалж байна гэж зарлан мэдэгддэг. Хэдийгээр тэд "капитализм"-ыг дэмждэг гэж мэдэгддэг ч гэсэн тэр бизнесүүд улстөрчдийн гарт бэлэн буй баталгаа, татаас, нөхөн олговор, бусад хөнгөлөлтийн төлөө маргаж мэтгэлцэхдээ уран цэцэн болчихдог.

Бизнес эрхэлдэг хүмүүс олон нийтэд ажил хэрэгч байдал болон чөлөөт зах зээлийн ашиг тусыг тайлбарлах чадваргүй (эсвэл хүсэлгүй) байдаг явдал мэдээжээр капитализмын хамгийн том сул тал, бас түүнд учирдаг хамгийн том аюул занал юм. Капитализмыг кронизмтай хольж хутгаснаар иймэрхүү бизнесийн

аваргууд гэх хүмүүс капитализмын үйл хэрэгт ямар ч тус болдоггүй. Капитализмын үзэл санаа аль хэдийнээ ойлгоход хангалттай хэцүү болжээ: төрийн хөндлөнгөөс оролцох үйлдлийн ойрын ашиг тусыг ойлгоход амар боловч зах зээл болон өрсөлдөөн өөрийнхөөрөө ажиллахын урт-хугацааны ач тусыг ухаж ойлгоход хэцүү байдаг; хэдхэн хүн л зах зээлийн дэг журам хэрхэн нарийн эмзэг зүйл болох, түүнийг улстөрийн бүр жижигхэн хөндлөнгийн оролцоогоор үгүй хийх боломжтой болохыг ойлгож мэддэг.

Худал тайлбарууд. Цаашилбал, нэгэнт хөгжингүй эдийн засгуудын ихэнхи нь бодит байдал дээр холимог эдийн засаг байдаг тул хүмүүст үйл явдлын аль нь капитализмаас өөрөөс нь гарсан харин аль нь капитализмыг гажуулагч улстөрийн хөндлөнгийн оролцооноос болсон гэдгийг ялгаж танихад хэцүү болжээ. Жишээлбэл, бараг бүх улстөрчид болон ихэнхи жирийн иргэд 2007-2009 оны санхүүгийн хямралыг капитализмаас шалтгаалсан, "банкируудын шунал" үүнийг үүсгэсэн гэж төсөөлцгөөдөг. Гэвч капитализмын дэмжигчид энэхүү хямрал хэдэн арван жил явуулсан зээлийн хүүгийн бага хэмжээ болон мөнгөний зөөлөн бодлого л өрдсөн, АНУ-ын төр засгийн (сайн-зорилготой ч буруу) дүрэм журмын зохицуулалт өдөөсөн гэж үүнийг үгүйсгэдэг. Эдгээр зүйл банкуудыг зээлийн эрсдэлийн талаар муу мэддэг ядуу өрхүүдэд зээл өгөхөд албадаж хүчилсэн – ингэснээр хэд хэдэн санхүүгийн институтцийг дампууруулсан стандартад-хүрээгүй ипотекийн сүйрлийг өдөөсөн. Тэд мөн төр засагтаа – энэ хямралын эсрэг хэрэгжүүлсэн хариу арга хэмжээ, банкуудыг хамгаалж аврах гэж илүү их мөнгө хэвлэсэн, мөн зээллэгийн өртгийг улам ихээр багасгасан явдал – эдийн засгийн стагнац буюу агшилт бий болгон, энэ хэцүү зовлонг зүгээр л уртасгадаг гэж сануулж байв. Тэдний хэлэхээр үүний зөв шийдэл бол банкуудыг өрсөлдөөнд оруулан тогтворжуулах, мөнгөний болон зээлийн тогтвортой тогтуун бодлого явуулах, зах зээлд бат суурилсан эдийн засгийг сэргээн босгож ажиллах боломж олгох явдал байдаг.

Санхүүгийн хямралын талаар нийтэд тархсан тайлбар ийм учраас алдаатай зүйл юм. Гэвч буруу эм хэрэглэсэн, дараагаар нь эдийн

засгийн өсөлт удаан хугацаанд бага байсан, 2007-2008 оны үйл явдал капитализм болон чөлөөт зах зээлийн талаар өргөн тархсан алдаатай төсөөлөл бий болгон, илүү их хяналт, дүрэм журмын зохицуулалт, төр засгийн бусад хөндлөнгөөс оролцох явдлыг улам ихээр шаардахад хүргэсэн. Харамсалтай нь энэ бүгд капитализмын үзэл санааг ноцтой ганхуулж сулруулсан.

Боломж бололцоо

Капитализм өргөжин тэлж байна. Гэлээ гээд капитализм өөрөө өргөжин тархсаар л байна. Хэдийгээр нэгэнтээ коммунизм аажмаар даяндэлхийг бүрхэх юмшиг санагдаж байсан ч гэсэн нөөдөрдэлхийн хэдхэн хэсэгт л капиталист үзэл санаа, дадал зуршил нэвтрээгүй үлджээ. Зөвлөлт Холбоот Улс 1990-ээд оны эхээр задарсны дараа Ази, Дорнод Европ, Африкийн ихэнхи хэсэг дэлхийн арилжаа худалдааны сүлжээ рүү үсрэн орцгоож, институтцийн-хэмжээний шинэчлэл хийсэн нь хүмүүст өөрийнхөө бизнесээ босгох, чөлөөтэй арилжаа наймаа хийх боломж олгожээ. Энэ нь эргээд капиталист аж ахуй эрхлэн явуулдаг эсвэл түүнд ажилладаг, мөн улам их эрх чөлөө, хөгжил цэцэглэлтийн төлөө шунан тэмүүлдэг шинэ дундаж анги бий болгов. Гээд улам олон зах зээл нэмэгдэж, дээр нь дэлхий дахины харилцаа холбоо, тээвэр өсөхөд энэхүү өөрчлөлт баттай хурдассан. Улстөрчид чөлөөт худалдаа дотоодын ажлын байрыг булааж магадгүй санаа зовж болох ч гэлээ бүх эдийн засагчид үүний ашиг тусыг таньж мэдсэн: одоо дэлхийн хүн амын дийлэнхи ихэнхи нь капитализм болон чөлөөт худалдаанд найддаг болсон бөгөөд одоо хямд, сайн чанартай бараа бүтээгдэхүүн таашаан эдлэх боломжтой болжээ.

Ядуусын бололцоог өргөжүүлэх. Хамгийн ядуу хүмүүсээ ч энэхүү хөгжил дэвшилд бүрэн оролцуулах явдал сорилт, бас нөөц боломж ч болдог. Хэдийгээр ядуу улс орнуудын хүмүүс илүү их хадгалж хураах хандлагатай байдаг ч тэдний, жишээлбэл, цуглуулсан зүйлс нь хөрөнгө биш байдаг: үнэндээ тэдний хадгалж хураасан зүйл голдуу, үр өгөөжгүй бэлэн мөнгө байдаг. Перүгийн эдийн засагч Хернандо

де Сото Полар (1941 онд төрсөн) дэлхийн хамгийн ядуу хүмүүс гэр орноо өөрийн чадах газраа байшин барьдаг ч энэ нь хуульзүйн дагуухь өмчлөх эрхгүй байдаг, мөн төрөөс шаарддаг тусгайлан заасан лицензгүйгээр бизнес эрхэлж, дэлгүүр ажиллуулдаг гэж тэмдэглэн хэлсэн. Нэгэнт тэдний гэр орон болон бизнест хуульзүйн статус байхгүй тул тэд эдгээрээ зээл болон гэрээний барьцаа болгож ашиглаж чаддаггүй, мөн хэзээ ч аж ахуйгаа томруулж, эсвэл санхүүгийн жинхэнэ аюулгүй байдалд хүрч чадахгүй. Гэвч төр эдгээр хүмүүсийг тэдэнд газраа өмчлөх эрх олгож, дүрэм журмын зохицуулалтыг илүү хялбар, илүү бодитой болгон – мөн тэдний хадгаламжийг бүтээлч хөрөнгө болгож хувирган, тэдэнд улс орных нь эдийн засгийн бодит жинхэнэ хэсгийг өгч чадна.

Газарзүйн эсвэл ёс суртахууны хязгаар байдаггүй. Капитализм өргөжин тэлэх явдал болон шинэ зах зээлд жам ёсны хязгаар гэж байдаггүй. Шинэ санаан дээр бий болсон шинэчлэл хүмүүсийн хэрэгцээ болон хүслийг илүү сайн, хямд, хурдан, бүр асар хол зайнаас хангаж нийлүүлэх шинэ бололцоо ажил хэрэгч хүмүүст нээсэн. Хэн ч ийм эрх чөлөө болон хөгжил дэвшил хаа хүргэхийг мэдэхгүй – энэ нь гутранги үзэлтэн болон төлөвлөгчдийг сэтгэлийг гонсойлгох ёстой ч хүмүүн төрөлхтөний дийлэнхи ихэнхийг бүрдүүлдэг индивидуалистууд болон өөдрөг үзэлтнүүдийн сэтгэлийг сэргээдэг.

Бас үүний нөөц бололцоо материаллаг ашиг тусаар зогсдоггүй. Капиталист багцын нэг хэсэг болох өмчлөх эрх, бие даасан байдал, эрх чөлөө, эв найр, хүчийг үгүйсгэхийн үнэ цэнэ мөн л чөлөөт зах зээл болон арилжаа наймаа тархаж түгэхэд батжиж бэхэжсэн. Энэ нь хүмүүний сэтгэл зүрхийг хөгжүүлдэг ёс суртахууны ололт байх учиртай.

Аюул занал

Сэхээтнүүд. Магадгүй капитализмд учирдаг хамгийн том аюул сэхээтнүүдээс ирдэг биз ээ. Тэдний сэдэл олон нийтийн-төлөө эсвэл тийм биш байж болно: магадгүй зах зээл тэд өөрсдийг нь дутуу үнэлж байна гэж боддог байж болно эсвэл эдийн засгийн

шинэ дэг журмыг удирдах нь зугаатай санагдаж болно эсвэл бусад хүмүүс рационал сонголт хийнэ гэж итгэдэггүй байж болох юм. Аль ч тохиолдолд олон нийт ч, улстөрчид ч сэхээтнүүдийг мэдээлэлтэй сайтай, ухаантай гэж ерөнхийдөө үздэг, капитализмын тухай тэдний шүүмжлэл, мөн түүнд ул суурьтай завсар хийх шаардлагатай гэдгийг нь хүлээн зөвшөөрсөөр ирсэн.

Гэвч сэхээтнүүд капитализмын мөн чанар болон нарийн нийлмэл ажиллагааг бараг ойлгодоггүй бөгөөд голдуу түүний талаар хувийн туршлага багатай байдаг. Тиймээс ихэнхидээ тэд түүний асуудал бэрхшээлийг төсөөлнө, учир шалтгааныг нь буруу оношилно, буруу эм хэрэглэдэг.

Сурах бичгийн алдаа. Олон сэхээтэн, жишээлбэл, асар олон нийлүүлэгчид ижилхэн үнээр яг ижил бүтээгдэхүүн зардаг "төгс өрсөлдөөн"-ий сурах бичгийн загварт шигдсэн байдаг. Тиймээс тэд үнэ эсвэл зах зээлийн хувь хэмжээн дэх аливаа өөрчлөлт заавал алдаа байх ёстой гэж үзнэ. Тэд супермаркетын сүлжээний хурдтай өсөлтийг хэрэглэгчид зүгээр л түүний санал болгож буй зүйлийг илүүд үзэж буйн тэмдэг биш харин, жишээлбэл, зах зээл "төгс бус" байх ёстой гэдгийн шинж тэмдэг гэж хардаг. Тэр супермаркет үнээ бууруулбал түүнийг нь хурдтай өөрчлөгдөж буй зах зээлээс хэрэглэгчид олж авах оролдлого гэж үзэхгүй "түрэмгий араатанлаг үйл" гэж үзнэ. Үр дүнд нь тэд домгийн-шинжтэй "төгс өрсөлдөөн"-өө тэр пүүсүүдийн өсөлтийг хязгаарлах эсвэл тэдгээрийн үнийг хянах замаар сэргээе гэж санал гаргацгаадаг – энэ нь зах зээлийг маш динамик-шинжтэй байлгадаг тэр л хүчийг алж устгана. Сэхээтнүүд эдийн засгийн амьдрал төгс биш учраас л өрсөлдөөн зөвхөн гардаг, ингэхдээ пүүсүүд гарч ирж буй хоосон зайг дүүргэхийг оролддог, бас бусадтайгаа яг адилхан бүтээгдэхүүн биш харин ямар нэг өөр, илүү сайн, илүү хямд бүтээгдэхүүн санал болгон тэмцэлддэг гэдгийг ухаарч мэддэггүй.

Популизм. Төрийн социализм капитализмд давамгайлах аюул занал мэдээж 1990-ээд оноос өмнөх үеийнх шиг тийм их биш болжээ. Социализм аугаа төлөвлөгөө бараг байхаа больж, харин капитализмын ажиллагаа, жишээлбэл, тэгш бус байдал зэрэг үр

дагаврын талаархи үргэлжилсэн гомдол маягтай зүйл болсон. Гэвч капитализм хэзээ ч нийгмийн бүх өвчнийг шийдвэрлэнэ, бас ингэж чадна гэж амлаж байгаагүй: түүний үнэ цэнэ эдийн засгийн бараа бүтээгдэхүүнийг үр өгөөжтэй үйлдвэрлэх, түгээх явдалд оршдог. Шүүмжилдэг олон үр дагавар нь жинхэнэдээ төр засгийн хөндлөнгийн оролцооны үр дагавар байдаг. Хэт хялбаршуулан дүгнэсэн, бас хөнгөн хуумгай эмчлэх жор бүхий популист улстөрчид уриалж эдийн засгийн интервенционизмийг асар ихээр нэмэгдүүлсэн. Бид бүтээмжтэй актив буюу хөрөнгийн бүрэлдэхүүн хэсгийг төр өмчлөх тухай үзэл санаанаас төр тэдгээрийг хянадаг тийм бодит байдал руу очжээ. Бид иймэрхүү улстөрийн хөндлөнгөөс оролцох явдлаас хортой муу үр дагавар гарвал гайхах ёсгүй.

Холбиромхой хяналт. Гэсэн хэдий ч дүрэм журмын зохицуулалт өссөөр л байна. Үүнд олон учир шалтгаан бий: жишээлбэл дүрэм журмын зохицуулалтад түүнийг хэрэгжүүлэх төр засгийн агентлаг хэрэгтэй болно, тэр агентлагуудад өөрсдийнхөө үүрэг нөлөөг нэмэгдүүлэх жам ёсны ашиг сонирхол байна, ингэснээр энэ нь голдуу шинэ, бүр дүрэм журмын илүү нарийн зохицуулалтын гол үүсгүүр болдог. Төр засаг том болох, эдийн засгийн гол тоглогч болохын хэрээр хонжоо-хайх (rent seeking), кронизм, авилгалд боломж бололцоо илүү гарна; мөн лобби хийх явдлаас гарч болох ашиг тус ихээр нэмэгддэг. Улстөрчид эрх мэдэл, давуу эрхтэй болж, өөрийнхөө үнэт зүйлээ эдийн засаг болон нийгмийн амьдралд нялзаан хэрэглэж таашаал хүртэж баясацгаадаг – ингэхдээ дахин сонгогдох эсэх нь хамаардаг электорат буюу сонгогчдодоо өөрийнхөө сайн үйлээ жишээ болгон харуулна.

Энэ бүхэн харамсмаар зүйл боловч хөндлөнгөөс оролцох явдлын урт хугацааны үр нөлөөг хүмүүс маш муу ойлгодог, үүнээс улбаалаад ховор анхаарч үздэг учраас л дүрэм журмын зохицуулалт үргэлж бараг эсрэг үр дагавартай байдаг гэсэн бодит баримт бол бүр хамгийн муу зүйл юм. Цалингийн доод хэмжээний хууль, жишээлбэл, ядуурлын эсрэг чиглэсэн эерэг үйлдэл гэж харагдаж болно; гэвч үнэндээ ажлын байрнаас бүхэлд нь зайлуулж ядуу, залуу, ур чадваргүй хүмүүст муугаар нөлөөлөн, үүнээс эсрэг үр дагавар

гардаг. Эсвэл дахиад л шинэ эмийг удаан хугацаанд турших тухай дүрэм журмын зохицуулалт олон нийтийг туршигдаагүй эмийн зүйлээс сайн хамгаалдаг байж болно; гэвч өмнөхийн адилаар энэ нь эцсийн шатандаа үхлээ хүлээж буй хүмүүст шинэ эм хэрэглэж амиа аврах боломж өгөхөөс зүгээр татгалзаж буй хэрэг. Түрээсийн хяналт хүн бүрд түрээсийн байрыг боломжийн үнэтэй болгодог гэж харагдаж болох юм; гэвч байр түрээслэх явдлыг бага ашигтай болгох тул байрны эзэд түрээсийн зах зээлээс байр, оффисоо гарган авна эсвэл тэдгээр байраа муу тордож сайжруулах болно.

Харамсалтай нь улстөрчдийг биш харин капитализмыг эдгээр үр дагаварт буруутгадаг – ингэснээр бас илүү их дүрэм журмаар түүнийг зохицуулахыг гарцаагүй шаардахад хүргэдэг. Нэгэнт гараад хэрэгжихсэн дүрэм журмын зохицуулалтаас хамаардаг шунахай ашиг сонирхлын бүлэг аль хэдийнээ бий болчихдог учраас түүнийг үгүй хийх хэцүү – энэ бүлэг хүмүүс бол энэ бодлогыг удирдаж чиглүүлдэг зохицуулагчдыг хамаатуулахгүй юмаа гэхэд түрээсийн-хяналттай, хямд түрээсийн байранд амьдрагч хүмүүс юм. Иймэрхүү өргөжиж тэлэмтгий, дүрэм журмын зохицуулалт капитализмын ирээдүйд ноцтой аюул занал учруулдаг.

Капитализмын бат бөх байдал

Капитализмын хувьд биширмээр зүйл бол түүний амьдрах чадвар, бат бөх байдал юм. Энэ эсвэл тэр хувилбараараа капитализм бидэнтэй мянган жил болжээ. Хамтач гэхээсээ илүүтэй индивидуалист нийгмийн дэг журмын хувиар энэ тогтолцоо хувь хүмүүст тэдэнд амьдрал тулгаж буй нийгэм, улстөр эсвэл технологийн бодит нөхцөл ямар ч байсан гэсэн өөрийнхөө арга замаар түүнтэй харьцах боломж өгдөг. Хувь хүн бүрийн бүтээлч суу залиг хөлөглөн капитализм бүр хамгийн хор сүйтгэлтэй улстөрийн хөндлөнгийн нөлөөг ч даван туулж чаддаг: хор хөнөөлтэй дүрэм журмаас авахуулаад, буруу явуулсан эдийн засгийн бодлого ороод, бүр бүхнийг хамарсан төрийн төлөвлөлт, хяналтыг тэсэж гарсан.

Капитализмын өнөөдөр давамгайлж буй улстөржсөн хувилбарыг

сайжруулах боломжтой гэдэг нь эргэлзээгүй зүйл – ингэхдээ улстөрийн явц болон төрийн хөндлөнгийн оролцоог арилгаж, мөн хүн бүрийн ашиг тусын төлөө тогтолцооны-хэмжээнд, бүхнийг-хамруулсан байр байдлаар ажиллах боломж капитализмд олгож, түүнийг чөлөөлөх хэрэгтэй. Гэвч жинхэнэ капитализм шиг ямар нэг зүйлгүйгээр хүмүүний төрөл зүйл хөгжиж цэцэглэсэн, либерал ирээдүйг харж төсөөлөхөд хэцүү.

АРВАНХОЁРДУГААР БҮЛЭГ: Нэмж Унших Зүйлс

Дайсагнасан таниулга тайлбар

Капитализмын тухай таниулга тайлбар гэж нэрлэдэг маш олон зүйл үнэндээ Карл Марксын түүхэн шинжилгээнээс урам зориг авсан, түүний тухай шүүмж байдаг гэдгийг тэмдэглэж хэлүүштэй.

Ийм зүйл жишээлбэл, Жэймс Фалчерийн *Капитализм: Богино Тайлбар* (2004 он) гэсэн номд бий. Түүндээ Марксын ашиг, цалингийн тогтолцоо, хотын ядуурал, түүхийн мега-ерөнхий хандлагын тухай улайрсан донтолттой санал нийлж, үүнтэй адилхан сэтгэлгээг өнөөдрийн санхүүгийн тогтворгүй байдал болон даяарчлалын тухай иймэрхүү улайрсан бодолдоо хэрэглэжээ. Гэвч энэ номд капитализм гэж юу болохыг, энэ нь хэрхэн ажилладаг эсвэл түүний цаана орших үзэл санааг тайлбарлаж чадсангүй.

Википедиагийн капитализмын тухай оруулга мэдээ (<https://en.wikipedia.org/wiki/Capitalism>) бол олон зохиогчийн, дахиад л Марксын үзэл бодлыг голдуу хүлээн зөвшөөрдөг зохиогчдын замбараагүй ажил юм. Энэ нь капитализмын тухай Марксын тодорхойлолтоос эхлэлээ аваад капитализмын түүх, төрөл, шинж чанар, мөн зах зээл, өмч, ашиг, санхүүгийн хөрөнгө, монополь, зах зээл, капитализм ба дайны талаар өгүүлээд, дахиад капитализмын төрлүүд, төр засгийн үүрэг нөлөөг дурдаж, эсрэг гаргалгаа нотолгоо бараг үгүй бусад шүүмжлэлүүд рүү үсчиж ордог – ийм байдлаар уншигчдаа бүрэн будлиулж орхидог.

Ха-Жүүн Чангийн *Капитализмын Тухай Тэдний Танд Хэлдэггүй 23 Зүйл* (2011 он) гэсэн ном бол үндсэндээ капитализм муу зүйлсийн хамгийн сайн нь ч гэлээ түүнийг хянах, дүрэм журмаар зохицуулах

хэрэгтэй гэдгийг голчлон санал болгосон цуврал эссэ юм. Түүнд бизнесүүд богино-хугацааны зүйлд анхаардаг, даяарчлалын үр дүнд багахан зүйлд хүрсэн, эд баялаг баячуудад л наалддаг, капитализм улам л үр өгөөжгүй болж байна, чөлөөт зах зээл ерөөсөө оршдоггүй гэж өгүүлдэг. Чангийн номыг Тим Волстоллын *Капитализмын Тухай Бидний Хэлж Буй 23 Зүйл* (2014 он, <http://tinyurl.com/y8fxth82>) гэсэн номын хамт унших хэрэгтэй. Энэ номд улстөрчид илүү богино-хугацааны зүйлд анхаардаг, протекционизм ажилладаггүй, мөн хүчинд тулгуурладаг, дүрэм журмын зохицуулалт кронизмыг тэтгэдэг, данхар төр засаг чөлөөт зах зээлийг бодвол эдийн засаг нийгмийг хөгжүүлж дэвжүүлэхдээ илүү муу, уян хатан биш байдаг гэж эсрэг зүйл өгүүлжээ.

Элгэмсэг таниулга тайлбар

Капитализмыг ойлгох, түүнийг тайлбарлах илүү сайн нөөц бололцоотой, капитализмыг өмгөөлж хамгаалагчдын бичсэн олон хэрэгтэй таниулга тайлбар мөн бий. Магадгүй хамгийн нөлөөтэй, танин мэдэх аяллаа эхлэх хамгийн сайн газар бол Милтон болон Рөүз Фрийдмэний *Сонгох Эрх Чөлөө* гэсэн видео цуврал нэвтрүүлэг болон ном (1980 он) байх биз ээ. Түүнд хөндлөнгөөс үл оролцох лэзе-фээр бодлогыг шийдвэртэй, сонирхол татмаар хамгаалдаг бөгөөд эрх чөлөө болон эдийн засгийн хөгжил дэвшлийн хоорондох холбоог үзүүлж, мөн өндөр татвар, төрийн боловсрол олгох үйлчилгээ болон бусад үйлчилгээний муу чанар, мөнгөний бодлого, халамжийн гээд олон асуудлыг хөндсөн байдаг (түүндээ Фрийдмэн орлогын хасах татвар (negative income tax)-ыг санал болгосон).

Энэ хоёр зохиогч өмнө нь *Капитализм ба Эрх Чөлөө* (1962 он) номыг хамтдаа бичжээ. Хэдийгээр бодлогынх нь хэрэглэгдэхүүний зарим нь хуучирсан, дээр нь мөнгөний бодлогод голчлон анхаарал хандуулсан байдаг (энэ үед инфляц том асуудал байсан) ч гэсэн монополь үүсгэхэд үзүүлдэг төр засгийн үүрэг нөлөө, капитализм хэрхэн ялгаварлан гадуурхах явдлыг багасгадаг, дүрэм журмын

зохицуулалтаас олон нийт биш харин тэр үйлчилгээ нийлэгч хэрхэн ашиг тус хүртдэг, мөн эдийн засгийн эрх чөлөөний ач холбогдлын тухай чухал санаанууд бий.

Эдийн Засгийн Ухаан болон Эрх Чөлөөний Онлайн Номын-санд Роберт Хессенгийн жижигхэн таниулга тайлбар бий (<http://www.econlib.org/library/Enc/Capitalism.html>). Түүнд "капитализм" гэж хэллэгийг хүмүүс одоо ч капиталистууд буюу хөрөнгөтнүүд биднийг арваннаймдугаар зууны Английн баргар бараан аж үйлдвэрлэлийн хот руу буцаан аваачихыг хүсэж байна гэж бодохоор дайсагнасан утгатай байхаар хэрхэн зохион гаргасныг харуулсан. Санал болгож байсан ерөндөг болох – санал нэгдэх болон эв зохиролтой утопи социализм нь – ажиллаагүй тул Маркс капитализмыг сүйрнэ гэж таамагласан "шинжлэх ухаанч" социализмаа томьёолж гаргасан. Харин капитализм хөгжиж дэвжмэгц шүүмжлэгчид нь гэнэт үгнээсээ буцацгааж капитализмын материализм болон "хэтэрхий сайн" байгаа тухай гомдоллох болсон. Харамсалтай нь Өрнөдийн хүмүүс өөрсдийнхөө тогтолцоог ухаж ойлгодоггүй, түүнийгээ хамгаалахдаа тун хойрго байдаг гэж Хессен бичжээ.

Бага зэрэг философийн тухай номыг Жэйсон Бреннон *Ягаад Капитализм биш гэж* (2014 он) гэсэн нэртэй бичсэн. Түүнд социалист болон капиталист ёс суртахууныг дэмждэг гаргалгааг нотолгоог харьцуулжээ. Ингэхдээ социалист алсын хараа нь капиталист алсын хараанаасаа илүү гараад байх зүйлгүй гэж батлан өгүүлсэн. Үүний эсрэгээр капитализм сайн дурын хамтын ажиллагаа, харилцан биесээ хүндлэх, бие биедээ санаа тавихад тулгуурладаг. Социализмтай адилгүй нь капитализмын зарчим том ч нийгэм, жижиг ч нийгэмлэгт ажиллана. Капитализм мөн ашиглах нөөцийг хамгаалж, нэмэгдүүлдэг, бас хүмүүст өөрсдийгөө хөгжүүлэх, илэрхийлэх, утопи алсын хараандаа хүрэхээр зорьж тэмүүлэх боломж олгодог.

Артур Шелдоны *Капитализм: Хураангуйлсан Хувилбар* (2007 он) бол бага зэрэг хуучирсан (1990 оны номоос хураангуйлсан) ч гэсэн Аж Үйлдвэрлэлийн Хувьсгал нийтэд тархсан үзэл бодлоос ялгаатай нь хүмүүст оромжийн оронд гэр орон, хувцасны оронцгийн оронд

хувцас, мөн ажлын богино цаг, эрүүл ахуйн илүү сайн нөхцөл, өөр бусад олон тав тух өгсөн гэдгийг харуулсан. Дараагаар нь түүнд өмч, үнийн тогтолцоо, хэрэглэгчийн эрх зэрэг капитализмын үндэс суурийг тоймлож өгүүлээд араас нь халамжийн үйлчилгээ, боловсрол, эрүүлмэндийн үйлчилгээ, байр сууцаар хангах явдлыг төр нийлүүлэх хэрэггүй гэдгийг харуулжээ.

Капитализм, Ардчилал, Ралфын Дажгүй Сайн Дэлгүүр (2001 он) номдоо Жон Мюллер капитализм болон ардчиллын аль нь ч төгс биш, бас сүйрэл ч биш гэвч ажиллаж буй нь "нэлээд сайн" гэдгийг тайлбарлажээ. Хэдийгээр капитализмыг шуналд үндэслэсэн гэж хэлдэг ч үнэндээ капитализм л шударга, чин үнэнч, иргэний, биесээ хайрласан үйлдлийг шагнаж урамшуулдаг ажээ. Ардчиллыг эгалитарич, оролцоо нэхэмтгий гэж хэлдэг бол энэ нь үнэндээ эмх замбараагүй, тэгш бус, бусдыг үл бодсон шинжтэй байдаг. Энэ хоёр хамтдаа бидэнд диваажин биш харин эрх чөлөө, аюулгүй байдал, хөгжил цэцэглэлт өгдөг.

Матт Ридлийн *Чөлөөт Зах Зээлийн Анти-капитализмыг дэмждэг гаргалгаа нотолгоо* гэсэн лекц (2017 он)-дээ чөлөөт зах зээл бол крони капитализм, корпоратизм, монопольтой адил зүйл биш гэдгийг цохон заасан. Том пүүсүүд "капитализм" гэдэг хэллэгийг ашиглах аргагүй хэллэг болгочихжээ. Учир нь тэд эдийн засгийн эрх чөлөөнд тулгуурладаггүй харин төр засгийн дэмжлэг, татаас, татварын хөнгөлөлт, дүрэм журмын зохицуулалтаас хамаардаг. Гэвч эдийн засгийн эрх чөлөө хорин жилийн хугацаанд ядуурлыг 50 хувь бууруулж, бүтээлч байдал болон өглөгч байдлыг хурдтай нэмэгдүүлэн, ялгаварлан гадуурхах болон тэгш бус байдлыг багасгажээ.

Иймонн Батлерын *Зах Зээлийн Тухайн Шилдэг Ном* (2008 он) бол эдийн засгийн индивидуализм хэрхэн ажилладаг тухай богино тайлбар юм. Түүнд хэрхэн зах зээл хэзээ ч "төгс" биш байж ирснийг - мөн энэхүү төгс бус байдал л түүн дотор буй хүн бүрийг хэрхэн сэдэлжүүлдгийг харуулсан. Тиймээ, зах зээлийн бүтэлгүйтэл гэж бий: гэвч төр засгийн бүтэлгүйтэл бүр илүү муу зүйл байдаг. Солилцоо үнэ цэнэ өсгөдөг; хяналт түүнийг устгадаг. Энэ номд

ашиглах нөөцийг-удирдаж залдаг үнэ болон өрсөлдөөний үүрэг нөлөө, мөн чин үнэнч зан, өмчийн үүрэг нөлөө, зах зээлийн ёс суртахууныг өгүүлжээ.

Петер Бергерийн *Капиталист Хувьсгал* (1986 он) номд өмч, үндсэн хөрөнгө (capital goods), чөлөөт зах зээл, хөрөнгийн актив буюу бүрэлдэхүүн хэсгийг автоматаар байршуулдаг байдал, урьдаас таамаглахуйц хуульзүйн тогтолцоо зэрэг капитализмын хэвшинжүүд түүнийг хэрхэн үр ашиг болон хөгжил дэвшлийн төгс сайн дэмжимтгий тогтолцоо болгодгийг харуулсан. Аливаа юмсыг хүчээр тулгаж хэрэглэдэг социализмтай адилгүй нь капитализм улстөрийн эрх мэдлээс хамгаалах хорогдох байр хүмүүст санал болгодог – социалист алсын хараа аугаа байх тусам улам илүү их дарангуйлсан засаглал тэнд байх ёстой болдог. Гэвч капитализм өөрөө бий болгосон ч өөрийг нь эсэргүүцдэг сэхээтнүүд болон хуульжсан давуу эрхийн төлөө лобби хийдэг ашиг сонирхлын бүлэг зэрэг нянд баригджээ.

Жорж Райсманы *Капитализмын Өгөөмөр Мөн Чанар* (2012 он) номд яагаад эдийн засгийн болон хувийн эрх чөлөө эв найр, хөгжил дэвшил, аюулгүй байдалд амин чухал гэдгийг тайлбарласан. Капитализм хэрэгтэй нөөцийн нийлүүлэлтийг нэмэгдүүлдэг, хүрээлэн байгаа орчныг сайжруулдаг, асар их бүтээмж бий болгодог. Үнэ, хүүгийн хэмжээ хөрөнгө оруулалтыг хамгийн их үнэ цэнэтэй хэрэглээ рүү залж чиглүүлэн, өмчийн эзэн, бас өмчийн эзэн биш хүмүүст ашиг тус хүртээнэ. Капитализм бол анархи биш рационал зүйл, энэ нь монопольд биш өрсөлдөөнд тулгуурладаг.

Капитализм ба ядуурлын тухай

Капитализм өргөжин тархсан явдал хэрхэн ядуурлыг асар ихээр хорогдуулсан тухай өгүүлсэн элгэмсүү хэд хэдэн ном бий. Ж. П. Флоругийн *Дэлхий Дээрхи Диваажин* (2013 он) гэсэн номд хэрхэн эдийн засгийн либералчлал Чили, Шинэ Зиланд, Хятад, Хонг Конгийн хөгжлийн өсөлтийг огцом нэмэгдүүлсэн, мөн хамгийн ядуу хэсэгт эд баялаг өсөж нэмэгдэх, түгэн тархахад тус болсныг

харуулсан. Татвар, дүрэм журмын зохицуулалт, төвийн төлөвлөлт зүгээр л ядуу байх хугацааг уртасгадаг гэж дүгнэжээ.

Шведийн эдийн засагч Иохан Норбергийн *Даян-Дэлхийн Капитализмыг Хамгаалья* (2001 он) гэсэн нэртэй ном бол арилжаа худалдаа, хөгжил цэцэглэлт, боловсрол, эрүүлмэндийн үйлчилгээ, дундаж наслалт, хүүхдийн эндэгдэл, өөр бусад хамаагүй олон зүйлд үзүүлдэг капитализмын эерэг нөлөөнүүдийн талаархи сонгодог тайлбар юм. Бодит баримт, тоо график дүүрэн энэ номд даяарчлал болон өрсөлдөөний өргөн ашиг тусыг дэлгэж харуулахын тулд (Тайван болон Хятад, Зүүн болон Баруун Герман, Хойд болон Өмнөд Солонгос зэрэг) хөрш зэргэлдээ капиталист болон социалист улсуудын амжилт болон бүтэлгүйтлийг ялгаж харуулжээ. Норберг энэхүү гаргалгаа нотолгоог өөрийнхөө *Хөгжил Дэвшил: Ирээдүйдээ Итгэх Арван Шалтгаан* (2016 он) гэсэн номдоо либералчлалын дараахь хүнсний чанар, эрүүл ахуй, дундаж наслалт, хүрээлэн байгаа орчин, эв найр, бичиг үсэгт тайлагдсан байдал, эрх чөлөө, тэгш байдал сайжирсан явдлыг ерөнхийлж үзүүлсэн.

Хернандо де Сото Поларын *Капиталын Нууц* (2001 он) гэсэн номдоо хэрхэн капитализм, өмчийн эрх үнэ цэнэгүй зүйлсийг зүгээр л бүтээмжтэй, үнэлж үздэг хөрөнгө болгодогийг харуулжээ. Түүний төрөлх Перу улсын ядуу хүмүүс өөрсдөдөө гэр орон, бизнес бий болгодог хэдий ч газрын хуульзүйн эрхгүй, худалдаа хийхэд шаардлагатай нарийн заасан зөвшөөрөлгүй учраас эдгээр нь хэрэгцээт "капитал" болж чаддаггүйг тэрбээр тэмдэглэж хэлсэн. Хернандо де Сото эдгээр үхмэл хөрөнгийг хуульзүйн эрхийг нь батлан олгох замаар хөрөнгө болгох, ингэснээр илүү олон ядуу хүмүүсийг эдийн засагт жинхэнэ оролцоотой болгодог, мөн хөгжиж, дэвжих боломж тэдэнд олгодог гэж батлан өгүүлдэг.

Философи ба ёс суртахууны тухай

Томас Палмерын гаргасан *Капитализмын Ёс Суртахуун* (2011 он) гэсэн нэртэй ном бол философичид, зохиогч эдийн засагчид, тинк-танк байгууллага, үүнд дотроо хоёр Нобелийн шагналтан

(Вернон Смит болон Марио Варга Лиоза) ордог, олон хүний бичсэн цуврал эссэ юм. Тэд арилжаа худалдаа гадаадын тусламжаас илүү ядуурлын эсрэг арга хэмжээ болдог, мөн капитализм бол маш ёс суртахуунтай зүйл: капитализм шуналд биш харин итгэлцэлд үндэслэдэг; капитализм шинэ санаа шинэчлэл, үнэ цэнэ бүтээх явдлыг тэтгэдэг; капитализм харилцан биесээ хүндлэх болон итгэлцлийг бий болгодог; энэ нь соёлын үнэт зүйлсийг тэтгэдэг, бас хамгаалдаг гэж батлан өгүүлцгээдэг.

Майкл Новак *Ардчилсан Капитализмын Сэтгэл Зүрх* (1982 он) гэсэн номдоо капитализмыг шашин, хүмүүний сэтгэл зүрхний үүднээс харжээ. Түүндээ ардчилсан, олон ургальч (pluralist), капиталист нийгэм клүб, сүм, буяны байгууллага, иргэний бусад институтуудээр дамжуулан биесээ халамжилдаг нийгэмлэг байгуулдаг гэж батлан өгүүлсэн. Гэвч эдийн засгийн болон нийгмийн үйл ажиллагааг улстөржүүлэх, засаг захиргаа хариуцлагыг нь өмнөөс хүлээдэг болоход ёс суртахууны амьдрал болон бүрэн дүүрэн байдал (completeness)-ын энэхүү амин чухал хэсэг алга болдог.

Айн Рэндийн *Капитализм: Бидний үл мэдэх идеал* (1966 он) гэсэн ном бол Рэндийн радикал капитализмыг бат суурьтай дэмжсэн, янз бүрийн сэдвээр бичсэн түүвэр эссэ юм. Түүнд капитализмыг хүмүүн төрөлхтөний мөн чанар, эволюц, эрхтэй холбож тайлбарладаг; дайн капитализмаас биш харин стэтизмээс үүсэж гардаг гэж батлан мэдэгдсэн; том бизнесүүдийг мөрдөн мөшгөж буйд харамссан; өргөн нэвтрүүлгийн зах зээлийн тухай хэлэлцэж мэтгэлцсэн; өмчийн хэлбэрийн хувиар патент болон өмчийн эрхийг нягталж үзсэн; капитализмын "консерватив үзэлтэй" дэмжигчид энэ идеалаа ухаж ойлгох, дэмжих, хамгаалах явдлаас хол хөндий байна – энэ бол дэндүү амиа хорлож буй хэрэг – гэж батлан өгүүлсэн.

ЭЗХЯХ-гийн тухай

Энэ хүрээлэн бол хязгаарлагдмал санхүүжилттэй, судалгаа болон боловсролын буяны байгууллага (No. CC 235 351) юм. Түүний алсын зорилго чөлөөт нийгмийн суурь институтүүдийн талаархи ухаарац мэдлэгийг эдийн засаг болон нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд үзүүлэх зах зээлийн үүрэг нөлөөг шинжлэх, түгээн дэлгэрүүлэх замаар сайжруулах явдал юм.

ЭЗХЯХ хэтийн зорилгодоо дараахь арга замаар хүрнэ:

- хэвлэн нийтлэх сайн чанартай хөтөлбөр
- бага хурал, семинар, лекц, бусад үйл ажиллагаа
- дунд сургууль, коллежийн оюутнуудад хүрч ажиллах
- хэвлэл мэдээллийн танилцуулга бэлдэх, нэвтрүүлэг ярилцлаганд орох

1955 онд Эрхэм Энтони Фишер үүсгэн байгуулсан ЭЗХЯХ бол улстөрийн байгууллага биш харин боловсролын буяны байгууллага юм. Энэ байгууллага аливаа улстөрийн нам эсвэл бүлгээс ангид байдаг бөгөөд ямар нэг сонгууль эсвэл олон нийтийн санал асуулгын үеэр эсвэл хэзээ хаана ч аливаа улстөрийн нам эсвэл түүний нэр дэвшигчийг дэмжихэд нөлөөлөхүйц үйл ажиллагаа явуулдаггүй. ЭЗХЯХ ном хэвлэлийнхээ борлуулалт, бага хурлын хураамж, сайн дурын хандиваар санхүүждэг.

Гол цуврал ном товхимолоосоо гадна ЭЗХЯХ мөн улирал тутмын Economic Affairs гэсэн сэтгүүл хэвлүүлдэг.

ЭЗХЯХ-гийн ажилд олон-улсын нэр хүндтэй Эрдэмтдийн Зөвлөх Зөвлөл [анг. Academic Advisory Council], мөн олонд алдартай Хүндэт Гишүүд [Honorary Fellows]-ийн бүлэг туслалцаа үзүүлдэг. Бусад эрдэмтдийн хамтаар энэ улс ЭЗХЯХ-гийн ирээдүйд гарах ном товхимлыг хянуулах, тэдний тайлбар санамжийг зохиогчид нь нэргүйгээр дамжуулж өгдөг. ЭЗХЯХ-гийн бүх ном зохиол тиймээс шинжлэх ухааны тэргүүлэх сэтгүүл гаргахад ашигладаг бие даасан, хатуу чанга хянаж шалгах үйл явцыг давж гардаг.

ЭЗХЯХ-гийн ном товхимлыг өргөн хэмжээгээр дунд сургууль, их сургуулиудад хичээлд ашигладаг. Эдгээр бүтээлийг дэлхий даяар борлуулдаг бөгөөд ихэвчлэн л орчуулан дахин-хэвлэж түгээдэг.

ЭЗХЯХ 1974 оноос хойш дэлхийн 70 улсад ижил төстэй 100 институтийн дэлхий-дэхний сүлжээг бүтээлцсэн билээ. Тэдгээр нь бүгд бие даасан байгууллага ч гэлээ ЭЗХЯХ-гийн хэтийн зорилготой зорилго нь дүйдэг.

ЭЗХЯХ-гийн ном товхимолд илэрхийлсэн үзэл санаа бол (корпорацын үзэлгүй) уг Хүрээлэн, түүний Удирдлагын Итгэмжлэгдсэн Баг, Эрдэмтдийн Зөвлөх Зөвлөлийн гишүүд эсвэл ахлах ажилтнуудынх биш харин зохиогчдынх нь үзэл санаа юм.

Тухайн Хүрээлэнгийн Эрдэмтдийн Зөвлөх Зөвлөл, Хүндэт Гишүүд, Итгэмжлэгдсэн Баг, Ажилтны багийн гишүүдийг арын хуудсанд жагсаан бичлээ. ЭЗХЯХ Профессор Роналд Кооз агсны бидний хэвлэлийн хөтөлбөр болон бусад ажлыг санхүүжүүлсэн өгөөмөр дэмжлэгт гүнээ талархаж байна.

Director General & Ralph Harris Fellow

Mark Littlewood

Editorial Director

Dr Jamie Whyte

Managing Trustees

Chairman: Neil Record

Kevin Bell

Robert Boyd

Neil Record

Sir Michael Hintze

Professor Patrick Minford

Professor Mark Pennington

Bruno Prior

Michael Fisher

Professor Martin Ricketts

Linda Whetstone

Academic Advisory Council

Chairman: Professor Martin
Ricketts

Graham Bannock

Dr Roger Bate

Professor Alberto Benegas-
Lynch, Jr

Professor Christian Bjørnskov

Professor Donald J Boudreaux

Professor John Burton

Professor Forrest Capie

Professor Steven N S Cheung

Professor Tim Congdon

Professor Christopher Coyne

Professor N F R Crafts

Professor David de Meza

Professor Kevin Dowd

Professor David Greenaway

Dr Ingrid A Gregg

Dr Samuel Gregg

Walter E Grinder

Professor Steve H Hanke

Professor Keith Hartley

Professor David Henderson

Professor Peter M Jackson

Dr Jerry Jordan

Dr Lynne Kiesling

Professor Daniel B Klein

Dr Mark Koyama

Professor Chandran Kukathas

Dr Tim Leunig

Dr Andrew Lilico

Professor Stephen C Littlechild

Professor Theodore Roosevelt

Malloch

Dr Eileen Marshall

Professor Antonio Martino

Dr John Meadowcroft

Dr Anja Merz

Professor Julian Morris

Professor Alan Morrison

Professor D R Myddelton
Paul Ormerod
Professor David Parker
Professor Victoria Curzon Price
Professor Colin Robinson
Professor Pascal Salin
Dr Razeen Sally
Professor Pedro Schwartz
Professor J R Shackleton
Jane S Shaw

Professor W Stanley Siebert
Dr Elaine Sternberg
Professor James Tooley
Professor Nicola Tynan
Professor Roland Vaubel
Dr Cento Veljanovski
Professor Lawrence H White
Professor Walter E Williams
Professor Geoffrey E Wood

Honorary Fellows

Professor Michael Beenstock
Sir Samuel Brittan
Professor Richard A Epstein
Professor David Laidler

Professor Deirdre McCloskey
Professor Chiaki Nishiyama
Professor Vernon L Smith
Professor Basil S Yamey

Other papers recently published by the IEA include:

Selfishness, Greed and Capitalism: Debunking Myths about the Free Market

Christopher Snowden

Hobart Paper 177; ISBN 978-0-255-36677-9; J12.50

Waging the War of Ideas

John Blundell

Occasional Paper 131; ISBN 978-0-255-36684-7; J12.50

Brexit: Directions for Britain Outside the EU

Ralph Buckle, Tim Hewish, John C. Hulsman, Iain Mansfield and Robert Oulds

Hobart Paperback 178; ISBN 978-0-255-36681-6; J12.50

Flaws and Ceilings – Price Controls and the Damage They Cause

Edited by Christopher Coyne and Rachel Coyne

Hobart Paperback 179; ISBN 978-0-255-36701-1; J12.50

Scandinavian Unexceptionalism: Culture, Markets and the Failure of Third-Way Socialism

Nima Sanandaji

Readings in Political Economy 1; ISBN 978-0-255-36704-2; J10.00

Classical Liberalism – A Primer

Eamonn Butler

Readings in Political Economy 2; ISBN 978-0-255-36707-3; J10.00

Federal Britain: The Case for Decentralisation

Philip Booth

Readings in Political Economy 3; ISBN 978-0-255-36713-4; J10.00

Forever Contemporary: The Economics of Ronald Coase

Edited by Cento Veljanovski

Readings in Political Economy 4; ISBN 978-0-255-36710-3; J15.00

Power Cut? How the EU Is Pulling the Plug on Electricity Markets

Carlo Stagnaro

Hobart Paperback 180; ISBN 978-0-255-36716-5; J10.00

Policy Stability and Economic Growth – Lessons from the Great Recession

John B. Taylor

Readings in Political Economy 5; ISBN 978-0-255-36719-6; J7.50

Breaking Up Is Hard To Do: Britain and Europe's Dysfunctional Relationship

Edited by Patrick Minford and J. R. Shackleton

Hobart Paperback 181; ISBN 978-0-255-36722-6; J15.00

In Focus: The Case for Privatising the BBC

Edited by Philip Booth

Hobart Paperback 182; ISBN 978-0-255-36725-7; J12.50

Islamic Foundations of a Free Society

Edited by Nouh El Harmouzi and Linda Whetstone

Hobart Paperback 183; ISBN 978-0-255-36728-8; J12.50

The Economics of International Development: Foreign Aid versus Freedom for the World's Poor

William Easterly

Readings in Political Economy 6; ISBN 978-0-255-36731-8; J7.50

Taxation, Government Spending and Economic Growth

Edited by Philip Booth

Hobart Paperback 184; ISBN 978-0-255-36734-9; J15.00

Universal Healthcare without the NHS: Towards a Patient-Centred Health System

Kristian Niemietz

Hobart Paperback 185; ISBN 978-0-255-36737-0; J10.00

Sea Change: How Markets and Property Rights Could Transform the Fishing Industry

Edited by Richard Wellings

Readings in Political Economy 7; ISBN 978-0-255-36740-0; J10.00

Working to Rule: The Damaging Economics of UK Employment Regulation

J. R. Shackleton

Hobart Paperback 186; ISBN 978-0-255-36743-1; J15.00

Education, War and Peace: The Surprising Success of Private Schools in War-Torn Countries

James Tooley and David Longfield

ISBN 978-0-255-36746-2; J10.00

Killjoys: A Critique of Paternalism

Christopher Snowden

ISBN 978-0-255-36749-3; 112.50

Financial Stability without Central Banks

George Selgin, Kevin Dowd and Mathieu B  dard

ISBN 978-0-255-36752-3; 110.00

Against the Grain: Insights from an Economic Contrarian

Paul Ormerod

ISBN 978-0-255-36755-4; 115.00

ЭЗХЯХ-гийн бусад ном товхимол

ЭЗХЯХ-гийн бүтээл болон бусад ном хэвлэлийн талаархи мэдээллийг www.iea.org.uk гэсэн сайтаас үзэх боломжтой. Аливаа ном товхимол захиалахыг хүсвэл мэдээллийг нь дороос үзнэ үү.

Хувь хэрэглэгчид

Хувь хэрэглэгчид захиалгаа ЭЗХЯХ-д өгөхдөө дор хаягаар хандах хэрэгтэй:

Clare Rusbridge

IEA

2 Lord North Street

freepost lon10168

London sw1p 3yz

Tel: 020 7799 8907. Fax: 020 7799 2137

Email: crusbridge@iea.org.uk

Арилжааны хэрэглэгчид

Арилжааны номын бүх захиалгыг өгөхдөө ЭЗХЯХ-гийн дистрибьютерүүд рүү дараахь хаягаар хандах хэрэгтэй:

Gazelle Book Services Ltd (IEA Orders)

freepost rlys-eahu-yscz

White Cross Mills

Hightown

Lancaster la1 4xs

Tel: 01524 68765. Fax: 01524 53232

Email: sales@gazellebooks.co.uk

ЭЗХЯХ-гийн товхимолын захиалга

ЭЗХЯХ-гээс мөн тогтмол хэвлэлийн захиалга авдаг. Жилийн нэг удаагийн төлбөр (одоогоор J42.00, НХУ) төлж тус Хүрээлэнгээс хэвлүүлсэн монограф бүрийг захиалагч хүлээн авах болно. Илүү дэлгэрэнгүй мэдээллийг холбоо барих мэдээлэлд дурдсан хүнтэй холбоо барина уу:


Clare Rusbridge
Subscriptions
IEA
2 Lord North Street
freepost lon10168
London sw1p 3yz
Tel: 020 7799 8907. Fax: 020 7799 2137
Email: crusbridge@iea.org.uk

ОРЧУУЛСАН БҮТЭЭЛҮҮД:

(Зарим бүтээлээ www.libraryforfreereople.mn гэсэн
онлайн номын-сандаа байрлуулав)



Худалдаанд гарсан




Худалдаанд гарсан



Худалдаанд гарсан




Номын-сан, он-лайнаар
нийтэд түгээв.




Номын-сан, он-лайнаар
нийтэд түгээв.




Номын-сан, он-лайнаар
нийтэд түгээв.



Номын-сан, он-лайнаар
нийтэд түгээв.



Номын-сан, он-лайнаар
нийтэд түгээв.



Номын-сан, он-лайнаар
нийтэд түгээв.

ОРЧУУЛСАН БҮТЭЭЛҮҮД:

(Зарим бүтээлээ www.libraryforfreereople.mn гэсэн
онлайн номын-сандаа байрлуулав)




Номын-сан, онлайн-
наар нийтэд түгээв.




Номын-сан, онлайн-
наар нийтэд түгээв.



Худалдаанд гарсан



Орчуулж дуус-
сан. 2024 он 2-р хагас



Орчуулж буй.




Номын-сан, онлайн-
наар нийтэд түгээв



Худалдаанд гарсан.



Номын-сан, онлайн-
наар нийтэд түгээв.



Орчуулж буй.

Капитализмын Үндэс...

Сүүлийн үеийн судалгаа Британийн хүн амын нэлээд хэсэг капитализмын тухай бараан төсөөлөлтэй байгааг харуулжээ. Улстөрийн зүүнтнүүд, үүн дотроо Хөдөлмөрийн Намын одоогийн удирдагчид капитализмыг орвонгоор эргүүлэхийг зорьж байна. Ингэх аваас Иймонн Батлер капитализмын оршил бүтээлдээ батлан өгүүлсэнчлэн, энэ нь бидний хөгжил цэцэглэлт, либерал-шинжтэй, хамтран ажилламтгай, динамик нийгмийн үндэс учраас сүйрэл байх болно.

Капитализмын тухай олон шүүмжлэл түүний тухай алдаатай үзэл санаанд тулгуурладаг, тэдгээрийн заримтай нь бүр капитализмыг өмгөөлж хамгаалагчид санал нийлдэг. Энгийн Англи хэлээр бичсэн, уншигчдаа эдийн засгийн ухааны мэдлэгтэй гэж тооцоогүй энэ ном эдгээр будлиан төөрөгдлөөс гарахад тусална. Түүнд хөрөнгийн мөн чанарыг, үүн дотроо түүнийг бүтээх, хадгалж хамгаалах, устгах явдал, мөн капитализм ажиллахад зах зээл болон өмчийн эрхийн үзүүлдэг үүрэг нөлөөг тайлбарлажээ.